

Г А Р Ч И Г

Нэгдүгээр бүлэг

Бизнесийн эрх зүйн үндсэн асуудал

- 1§. Бизнесийн эрх зүйн ойлголт 1-4
2§. Бизнесийн эрх зүйн систем, зарчим, үүрэг..... 4-6

Хоёрдугаар бүлэг

Бизнесийн удирдлага

- 1§. Бизнесийн удирдамж, түүний арга 7-9
2§. Аж ахуйн харилцааны эрх зүйн зохицуулалтын хэлбэр 10-12

Гуравдугаар бүлэг

Бизнесийн эрх зүйн субъект

- 1§. Бизнес эрхлэх хэлбэр 13-15
2§. Аж ахуйн нэгжийг байгуулах нь 16-17
3§. Аж ахуйн нэгжийг бүртгэх нь 17-19
4§. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа дуусгавар болох 19-21

Дөрөвдүгээр бүлэг

Хоршоо, түүний эрх зүйн зохицуулалт

- 1§. Хоршооны тухай ойлголт 22-23
2§. Хоршоог байгуулах, бүртгэх журам 23-25
3§. Хоршооны эд хөрөнгөний ба удирдлагын эрх зүйн зохицуулалт..... 25-28
4§. Хоршооны гишүүдийн эрх зүйн байдал 28-29

Тавдугаар бүлэг

Нөхөрлөл, түүний эрх зүйн зохицуулалт

- 1§. Нөхөрлөлийн тухай ойлголт 30-31
2§. Нөхөрлөлийг байгуулах, бүртгэх 31-33
3§. Нөхөрлөлийн эд хөрөнгийн ба удирдлагын эрх зүйн зохицуулалт 33-35
4§. Нөхөрлөлийн гишүүдийн эрх зүйн байдал 36-37

5036

Зургадугаар бүлэг

Компаний эрх зүйн зохицуулалт

1§. Компанийн тухай ойлголт	38-40
2§. Компани байгуулах журам	40-43
3§. Компанийг өөрчлөх замаар байгуулах	43-45
4§. Компанийн удирдлагын эрх зүйн зохицуулалт	46-50
5§. Компанийн хийх зарим төрлийн хэлцэл, түүний эрх зүйн зохицуулалт	51-51

Долдугаар бүлэг

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, түүний эрх зүйн зохицуулалт

1§. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ойлголт	52-54
2§. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн эрх зүйн байдал	55-58

Наймдугаар бүлэг

Өрсөлдөөн, түүний эрх зүйн зохицуулалт

1§. Өрсөлдөөний тухай ойлголт	59-61
2§. Шударга бус өрсөлдөөн	61-63
3§. Өрсөлдөөнд төрийн гүйцэтгэх үүрэг	64-65

Есдүгээр бүлэг

Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай ойлголт

1§. Дампуурлын тухай ойлголт	66-68
2§. Дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл, журам	68-70
3§. Хэрэг гүйцэтгэгч, түүний эрх, үүрэг	70-71
4§. Дахин хөрөнгөжүүлэлт	71-74

Аравдугаар бүлэг

Үнэт цаасны эрх зүй

1§. Үнэт цаасны ойлголт	75-77
2§. Үнэт цаасны төрөл	77-84

Арваннэгдүгээр бүлэг

Бизнесийн эрх зүйн хамгаалалт	85-88
-------------------------------------	-------

Нэгдүгээр бүлэг

БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДСЭН АСУУДАЛ

1§. Бизнесийн эрх зүйн ойлголт

А.Бизнес эрхлэх шаардлага. Нийгмийн амьдралын түүхэн замналыг эргэн ажиглавал хүн материал баялгийг тасралтгүй үйлдвэрлэж хэрэглэсээр ирсэн байна. Их сэтгэгч К.Маркс "Нийгэм хэрэглэхгүй байж болохгүй учраас үйлдвэрлэхгүй байж болдоггүй" гэж бичсэн нь үйлдвэрлэл, хэрэглээ¹ гэсэн хоёр үйл явц салшгүй холбоотойн зэрэгцээ тасралтгүй өсөж хөгжиж байдаг зүй тогтлыг илэрхийлсэн хэрэг юм. Нийгмийн эрэлт, хэрэгцээ хязгааргүй бөгөөд түүний байнга өсөж нэмэгдэхийн хирээр үйлдвэрлэл ч мөн тэр аясыг даган өөрчлөгдөн хөгждөг жамтай юм.

Хүн төрөлхтөн материал баялгийг үйлдвэрлэж өмч, өмчийн харилцаанд оролцож эхэлсэн урт удаан хугацааны түүхэн үе шатуудад эдийн засгаа зах зээлийн ба төвлөрсөн, төлөвлөгөөт арга, хэлбэрээр эрхлэн хөтөлж иржээ. Үүний зах зээлийн арга хэлбэр нь эртний бөгөөд өвөг хэмээн ойлгож болох, учир нь дэлхийн ихэнх улс орон эдийн засаг, нийгмийн амьдралаа зах зээлийн аргаар хөтөлж эцсийн бүлэгт өндөр хөгжилтэй (АНУ, Англи, Япон г м) орон гэж нэрлэх болсныг бид мэдэх билээ.

Өнөөдрийн улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн дүр төрх, чиг хандлагыг бүхэлд нь авч үзвэл гурван хэсэгт хувааж болох мэт. Үүнд: **Нэгд:** чөлөөт зах зээлийн хөгжлийн урт удаан бартаат замаар аажим явсаар төрийн удирдлага, зохицуулалттай зах зээлд шилжиж, орчин үед өндөр хөгжилтэйд тооцогдож буй орон байна. **Хоёр:** дээрх замыг сонгон авч, тэдгээр орны хөгжлийн жишигт хүрэхийн төлөө нийгэм, эдийн засгийн зорилго, зорилтоо тодорхойлон замнаж яваа Ази, Африк, Латин америкийн олон орныг нэрлэж болно. **Гуравт:** төвлөрсөн төлөвлөгөөт эдийн

¹ 1.К Маркс. Ф, Энгельс зохиолуудын 2 дахь хэвлэл 23-р боть 578 дахь тал (орос хэл дээр)

засгийн тогтолцооноос зах зээлийн харилцаанд шилжиж буй социалист системийн гэгдэж байсан орнууд байна. Монгол орон энэхүү замыг сонгож эдийн засаг, эрх зүйн шинэчлэлээ хийж байна.

Монгол улсад, иргэн хуулиар хориглоогүй ямар ч төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нь чөлөөтэй бөгөөд үүнийг хуулиар баталгаажуулсан юм. Тухайлбал Монгол улсын иргэн хуулийн этгээд байгуулах буюу байгуулахгүйгээр аж ахуйг эрхлэх эрхтэй гэж Монгол Улсын Үндсэн хууль болон Иргэний хуульд заасан байна.

Иргэн баян бол улс баян байна гэсэн үзлийг иш үндэс болговол хүн юуны өмнө өөрөө гэр бүлээрээ гачигдах, дутагдах юмгүй өөдрөг амьдрахын тулд аж ахуйг аль нэг хэлбэрээр эрхлэх болдог. Өөрөөр хэлбэл иргэн өөрийн мэргэжил боловсрол, чадвар сонирхолд тулгуурлан олон төрөл чиглэлийн бизнес эрхлэх явцдаа хүссэн хүсээгүй бусад иргэн байгууллагатай зайлшгүй харилцдаг.

Тухайлбал нэг хэсэг нь үйлдвэрлэж, нөгөө нь хэрэглэж, гурав дахь нь төрөл бүрийн туслалцаа, үйлчилгээ үзүүлж, дөрөв дэх нь оюуны үйлдвэрлэл эрхлэх г м хөдөлмөр мэргэжлийн нарийн хуваарь ёсоор бизнес эрхэлж эцсийн бүлэгт хоорондоо харилцана гэсэн ойлголт юм.

Иргэн бизнес эрхэлсний нийгэм эрх зүйн ач холбогдол нь өөрийн ахуй амьдралыг дээшлүүлж эдийн засгийн баталгаатай болох, улмаар улсын сан хөрөнгийг арвижуулах болон хэрэглэгчийг бүтээгдэхүүн ажил үйлчилгээгээр хангахад оршино.

Б."Бизнес" хэмээх үгийн утга. Үг бүр цаанаа утгыг агуулсан байдаг. "Бизнес" гэдэг үг аж ахуйг эрхлэх арга ухаан, онол сэтгэлгээний агуулгыг илэрхийлж буй дэлхий нийтийн түгээмэл нэр томъёо юм. Бизнес¹ гэдэг нь аж ахуйг үр ашигтай эрхлэх гэсэн утга бүхий Англи гаралтай үг бөгөөд энэ нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, ашиг, хуримтлал,

¹ 1 Словарь иностранных слов 1962 М, С-97.

үйлдвэрлэлийн удирдлага, зохион байгуулалт, гм олон ухагдахууныг өөртөө багтаасан өргөн ойлголт болно.

Хэрэв бизнес гэдэг нь аж ахуйг эрхлэх ухаан юм бол Монгол газар нутагт өмчийн харилцаа, хөдөлмөрийн хуваарь үүссэн тэр цаг үеэс бизнес хийх ухаан үүссэн байна. Энэ нь монголчуудын аж ахуйг эрхлэх уламжлалт арга, зан заншил, шашин шүтлэг, соёл боловсролын гүнд үүсэж жинхэнэ монгол хувилбартай хөгжиж иржээ.

Энэ уггаар нь бизнес гэдэг үгийг аж ахуйг эрхлэх ухаан гэж эх хэлнээ хөрвүүлж болох боловч нэгэнт дэлхийн олон орон өөрийн эх хэлэнд буулгалгүй шууд авч хэрэглэсээр өнөөдөр олон улсын чанартай нэр томъёо болсныг харгалзан орчуулалгүй тэр хэвээр нь хэрэглэх нь зүйд нийцэх болов уу хэмээн үзнэ.

В.Бизнесийн эрх зүй гэж юу вэ. Бизнес эрхлэх явцад олон чиглэл, талтай, тэгсэн атлаа бүхэлд нь авч үзвэл нэг төрлийн харилцаа үүсэх бөгөөд үүнийг бизнесийн харилцаа гэнэ. Бизнес эрхлэх явцад дан ганц бизнесийн харилцаа төдийгүй, түүнтэй холбоотой өөр төрлийн, тухайлбал, хөдөлмөрийн, захиргааны, санхүү, татварын гм харилцаа давхцан үүсэх бөгөөд эдгээр харилцааг тухайн салбар хууль тогтоомжоор зохицуулна.

Бизнесийн харилцааг төрийн хууль тогтоомжоор зохицуулахаар **бизнесийн эрх зүй** гэсэн шинжлэх ухааны бие даасан ойлголт бий болно. Бизнесийн эрх зүйн харилцаа нь:

1. Бизнес эрхлэгч иргэдийн хооронд;
2. Бизнесийн байгууллагуудын хооронд;
3. Бизнес эрхлэгч иргэн, байгууллагын хооронд;
4. Бизнесийн байгууллага, иргэн, төрийн хооронд;
5. Манай үндэсний бизнес эрхлэгч иргэн байгууллага, гадаад (**хилийн чанад болон манай нутагт орших**)-ын байгууллага, иргэдийн хооронд тус тус үүсдэг.

Бизнес эрхлэгч буюу бизнесмен гэж хэнийг хэлэх вэ гэвэл аливаа иргэн, хуулийн этгээд бүгдийг бус зөвхөн тодорхой зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээг байнга эрхлэж, ашиг, орлого, хуримтлалын төлөө ажилладаг этгээд байна. Бизнесийн эрх зүйн харилцааны онцлог шинж нь:

- ❖ Бизнесийн эрх зүйн харилцаанд оролцогчид харилцан тэгш эрхийн зарчимд тулгуурлан оролцоно.
- ❖ Бизнесийн эрх зүйн харилцааны субъектийн зорилго нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэсний эцэст тодорхой ашиг, орлого олохын төлөө байна.
- ❖ Бизнесийн эрх зүйн харилцааны субъектийн үйл ажиллагаа нь байнгын тогтвортой байдаг.
- ❖ Бизнесийн эрх зүйн харилцаа өөртөө төрийн хамгаалалтын арга, хэлбэрийг агуулсан байна.

Г. Бизнесийн эрх зүйн байр, суурь. Бизнесийн эрх зүй нь бие даасан болон цогцолбор (комплексный) эрх зүй биш, иргэний эрх зүйн нэгэн дэд салбар юм. Иргэний эрх зүй нь зохицуулах нийгмийн харилцааны цар хүрээ, сэдвийн төрөл, чиглэлээс хамаарч өмчийн, үүргийн, өв залгамжлалын, бизнесийн г м дэд салбаруудад хуваагддаг. Бизнесийн харилцаа нь иргэний эрх зүйн зохицуулах зүйл болох эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус болон зохион байгуулалтын харилцааны нэг хэсэг болно. Өөрөөр хэлбэл бизнесийн эрх зүй нь бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын арга, хэлбэрийг гүнзгийрүүлэн авч үзэж судална.

Эл сэдвийг дэлхийн улс орнууд "Аж ахуйн нэгжийн эрх зүй", "Компаний эрх зүй", "Аж ахуйн эрх зүй", "Бизнесийн эрх зүй" гэсэн өөр өөр нэр томъёогоор илэрхийлж сургалтын төлөвлөгөөгөөр судлахын сацуу мөн тийм нэр бүхий олон арван сурах бичиг, нэгэн сэдэвт зохиолууд хэвлэгдсэн байна.

2§. Бизнесийн эрх зүйн систем, зарчим, үүрэг

Бизнесийн эрх зүйн систем. Бизнесийн эрх зүй нь харьцангуй бие даасан, хоорондоо уялдаа, холбоотой эрэмбэ дараалал бүхий, бүлэг, зүйл хэсгүүдээс бүрдсэн системтэй байна. Энэхүү систем нь сургалт, танин мэдэхүйн хэрэгцээ шаардлагад зохицсон байх ёстой.

Систем нь:

- Бизнесийн эрх зүйн ойлголт, зарчим, систем
- Бизнесийн эрх зүйн харилцаа, түүний онцлог
- Бизнесийн эрх зүйн харилцааны субъект
- Аж ахуйг удирдах арга, эрх зүйн зохицуулалтын хэлбэр

- Бизнесийн байгууллага, тэдгээрийн төрөл (нөхөрлөл, хоршоо, компани г м)
- Өрсөлдөөн
- Аж ахуйн нэгжийн дампуурал
- Үнэт цаас, түүний төрөл

Бизнесийн эрх зүйн зарчим. Бизнесийн эрх зүй нь иргэний эрх зүйн зарчмыг удирдлага болгохын сацуу өөртөө баримтлах зарчимтай байна. Тэрхүү зарчим нь:

- Бизнес эрхлэх нь **сайн дурын** зарчимд үндэслэнэ. Иргэн хэний ч ятгалга зааваргүйгээр ямар ч төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээг аж ахуйн нэгж байгуулах буюу байгуулахгүйгээр эрхлэх эрхтэй. Нэгэнт байгуулсан аж ахуйн нэгжээ хэдийд ч өөрчлөн байгуулах буюу татан буулгаж болдог.

- Үйлдвэрлэл, зах зээлээ **чөлөөтэй сонгох** зарчимтай. Энэ нь бизнесмен юу үйлдвэрлэх нь бус, хэнд зориулж юу үйлдвэрлэх нь чухал гэсэн зах зээлийн эдийн засгийн амьдралаас урган гарч буй зарчим болно. Бизнесмен юуны өмнө хэрэглэгчийн хэрэгцээ болон өрсөлдөгчөө судлах, ингэснээр үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр, төрөл, загвар, маяг, тоо, чанар г м үзүүлэлтүүдийг сонгоно гэсэн ойлголт юм.

- **Төлөвлөгөөт зарчим.** Бизнесменүүд эрхлэх аж ахуйн хэтийн хөгжлийг урьдчилан тооцоолж хэлбэржүүлсэн төлөвлөгөөгүйгээр хөтлөх аргагүй юм. Энгийн үгээр хэлбэл төлөвлөгөөгүйгээр ажиллах нь харанхуй мушик (хөзөр) тоглосонтой адил хэмээн барууны орны зарим хэвлэлд бичсэн байдаг нь санамсаргүй зүйл биш бололтой. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны өнгөрсний гүйцэтгэл, өнөөгийн шинж төлөвт дүн шинжилгээ хийж баймааж ирээдүйн дүр төрхийг тодорхойлсон төлөвлөгөө нь тухайн бизнесмен болон хамт олны заавал биелүүлэх хууль зүйн үүрэг байдаг.

- **Төрийн хуулийг хүндэтгэж, түүнийг сахин биелүүлэх зарчимтай.** Хууль ёсны зарчим ч гэж нэрлэдэг. Бизнесменүүд төрийн хуулийг биелүүлэх гэдэг нь нэг талаар зарчим, нөгөө талаар үүрэг болж байдаг онцлогтой. Бизнесийн

хууль тогтоомжууд бүхэлдээ бизнес эрхлэгчийн үйл ажиллагаа, үзэл бодлын чиглэмж, зөвлөмж болохын хувьд зарчим, харин заавал биелүүлэх, үл биелүүлбэл хариуцлага оногдуулах хэм хэмжээг агуулснаараа үүрэг болно гэсэн үг юм.

Бизнесийн эрх зүйн үүрэг. Бизнесийн эрх зүй нь *нийгмийн харилцааг боловсронгуй* болгох үүрэг гүйцэтгэнэ. Бизнесийн харилцаа нь нийгмийн харилцааны нэгэн хэсэг бөгөөд бизнесийн олон талт ажиллагааг ардчилал, зах зээлийн нөхцөлд зүй зохистой зохицуулж чадсанаар улс орны эдийн засаг, эцсийн бүлэгт нийгмийн амьдралыг төгөлдөржүүлэх үүрэгтэй байна.

Бизнесийн эрх зүй аж ахуйн амьдралд шалгарч гарсан дэвшилтэт арга, хэлбэр, үзэгдэл юмсыг бататган бэхжүүлэх, болзошгүй сөрөг нөлөө, үр дагавараас урьдчилан сэргийлэх, хэрэв гарвал түүнийг засаж залруулах үүрэгтэй.

Өмчийн олон төрлийн хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрх ашгийг хамгаалах, ингэснээр үйлдвэрлэгчийн бие даасан чөлөөт нөхцөл боломжийг хангах нь бизнесийн эрх зүйн нэг чухал үүрэг байдаг. Бизнес эрхлэхэд саад, хориг тавих, үйл ажиллагаанд нь хутгалдан оролцох, шахалт хавчилт үзүүлэх зэрэг аливаа хууль зөрчсөн үйлдлийг хуулиар хориглодог.

Бизнесменүүдийн эрхийг хамгаалах үүрэгтэй. Энэ нь бизнес эрхлээгүй бусад субъектээс бизнес эрхлэгчийн эрхийг илүүтэйд үзнэ гэсэн хэрэг биш, бизнес хийх эрх зүйн таатай нөхцөл, орчинг бүрдүүлэх, тэдний эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус зөрчигдсөн эрхийг хуульд заасан арга, хэлбэрээр хамгаална гэсэн үг юм.

В.Г.М

Хөёрдугаар бүлэг

БИЗНЕСИЙН УДИРДЛАГА

1§. Бизнесийн удирдлага, түүний арга

Бизнесийн эрх зүйд аж ахуйн удирдлага, түүнийг хэрэгжүүлэх аргын асуудлыг зайлшгүй авч үзэх шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл бизнесменүүд ямар аргаар аж ахуйгаа эрхлэн хөтөлбөл илүү үр дүнд хүрэх вэ гэдгийг онцгой анхаарах хэрэгтэй болдог.

Удирдлага гэдэг ухагдахуун нийгмийн амьдралын макро, микро түвшиний бүх хүрээнд хэрэглэгддэг өргөн утгыг илэрхийлсэн ойлголт юм. Энэ тухай судлаачид өөрсдийн бүтээлдээ нийгмийн удирдлага¹ төрийн удирдлага² аж ахуйн удирдлага³, бирж, үнэт цаасны удирдлага⁴, төрийн экологийн удирдлага⁵, гэр бүлийн удирдлага⁶ г.м нийгмийн амьдралын тодорхой салбар хүрээнд авч үзэж тайлбарласан байна.

Бизнесийн харилцаан дахь төрийн удирдлага нь төрөөс эдийн засгийг удирдах чиг үүргийн нэг салшгүй хэсэг болно. Өөрөөр хэлбэл бизнесменүүд аж ахуйг эрхлэхдээ төрийн удирдлагыг амьдралд шууд хэрэгжүүлэгч субъект байна гэсэн ойлголт юм. Төрийн эдийн засгийн удирдлага, бодлого, түүний хэрэгжих арга замыг ашиглахгүйгээр бизнесийн орчинг төлөвшүүлж аж ахуйн хүссэн үр дүнд хүрэх боломжгүй нь дэлхийн улс орнуудын амьдралаар нотлогдсон аж. Ийм ч учраас хөгжингүй орнууд төрийн удирдлага, эрх зүйн зохицуулалттай зах зээл хэмээн нэрлэж байна.

Бизнесийн удирдлага нь аж ахуйн амьдралд захиргааны аргаар нөлөөлж хэрэгждэг. Хүн төрөлхтөн аж ахуйг эрхлэсэн цагаасаа эхлэн янз бүрийн аргыг өөр өөрийн аж ахуйн хэвшилд

¹ В.Г.Афанасьев "Нийгмийн шинжлэх ухааны үндэс (монгол хэлээр) 1973.М

² Н. Лүндэндорж, "Төрийн онол" 1997, УБ

³ Т.Мөнхжаргал, "Аж ахуйн эрх" 1990. УБ

⁴ Ж. Ядамсүрэн "Монгол Улсын үнэт цаасны зах зээл" 1998 УБ

⁵ Т. Сэнгэдорж "Экологийн эрх зүй" 1997 УБ

⁶ "Гражданское и торговое право капиталистических стран" 1990, М

нийцүүлэн ашиглаж, тэр нь хөгжлийн жам, цагийн эрхээр боловсронгуй болон өөрчлөгдсөөр ирсэн байна. Бид бусад орнуудын аж ахуйн удирдлагын аргыг онцлохдоо гол нь биш, эдгээр оронд түгээмэл дэлгэрсэн, амьдралаар шалгарсан аргыг монголын өнөөгийн зах зээл, эдийн засаг, ард түмний уламжлалт зан заншилд тохируулан авч хэрэглэх нь зүйд нийцнэ.

Бизнесийн удирдлагыг хэрэгжих аргын хувьд захиргааны, эдийн засгийн, сэтгэл зүйн гэсэн гурван төрөлд хувааж үзэж болох юм.

Захиргааны арга. Бизнесийн харилцаан дахь аж ахуйн удирдлагыг хэрэгжүүлэхэд захиргааны арга чухал үүрэг гүйцэтгэж ирсэн, одоо ч гүйцэтгэсээр байна. Ер нь төрт ёс оршин тогтнож, түүнийг дээдлэн хүндэтгэж байгаа бол захиргааны аргыг хүлээн зөвшөөрөх учиртай. Төр бол сайн үйлсийг дэмжин дэлгэрүүлэхийн сацуу саар муу бүхнийг захиргааны аргаар таслан зогсоож нийгмээ цэвэршүүлж баймааж төр түвшин, улс орон маань урагшлан хөгждөг жамтай. Захиргааны арга нь эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажих бөгөөд тэр нь дараах хэлбэрээр илэрч хэрэгждэг.

1. Бизнесменүүдэд эрх олгож **зөвшөөрөх** (аж ахуйн нэгж байгуулах, үл хөдлөх хөрөнгийг түрээслэх г.м), **үүрэг болгох** (хэрэв аж ахуйн нэгж байгуулах бол заавал бүртгүүлэх г.м), **хориглох** (хориотой үйлвэрлэл эрхлэх г.м)

2. Зөвшөөрсөн, хориглосон, үүрэг болгосон хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлэх, анз оногдуулах, хориотой үйлдвэрлэл эрхэлсэн болон хууль бус өрсөлдсөн аж ахуйн нэгжийг татан буулгах гэх мэт албадлагын арга хэмжээнд захиргааны аргын хэрэгжиж буй илрэл юм.

Эдийн засгийн арга. Зах зээлийн аж ахуйн үүсэл, өөрчлөлт, хөгжилт нь өөрийн дотоод агуулга, мөн чанараас урган гарч, түүгээр тодорхойлогдсон эдийн засгийн бодит хуулийн дагуу явагддаг. Энэ хуулийг хэн ч өөрчлөх буюу зогсоож болдоггүй бөгөөд харин уг хуулийн илрэх хэлбэр, зүй тогтол, үйлчлэх үйл явцыг таньж мэдэх нь чухал болно. Эдийн засгийн хууль нь өртөг, өөрийн өртөг, үнэ, аж ахуйн тооцоо, материаллаг урамшил болон

өрсөлдөөн, дампуурал гэх мэт категориудаар илэрдэг байна. Цар хүрээний хувьд их бага ямар нэг төрлийн бизнес эрхлэгчид дээрх хууль категориудыг таньж мэдэж баймааж аж ахуйг эрхлэн хөтлөх бөгөөд энэ нь эдийн засгийн аргаар удирдана гэсэн ойлголт болно.

Зохион байгуулалтын арга нь бизнесийн удирдлагыг хэрэгжүүлэх нэг хэлбэр байна. Бизнесменүүд эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, онцлогт удирдлагын бүтэц, энд захирал, менежер, бүх гишүүдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, төлөөлөгчийн ба салбар байгууллага г м. субъектүүдийн бүрэлдэхүүн, эрх байдал хамаарна. Мөн үйлдвэрлэл явуулах байршил, энд материал хангамж, үйлдвэрлэл, зах зээл (хэрэглэгч) гэсэн гурван холбоог зохистой зохион байгуулах шаардлагатай.

Бизнесийн удирдлагын зохион байгуулалтын аргад: бүтцийн, байршлын, үйлдвэрлэлийн, хөдөлмөрийн, менежементийн зохион байгуулалт багтдаг.

Сэтгэл зүйн арга. Бизнесийн байгууллагын гишүүд болон гэрээт ажиллагсадын хамтын хөдөлмөрийг нэг санаа, зорилго, эрмэлзлэлд чиглүүлэн удирдаж чадсанаар үр дүнд хүрэх нь мэдээж бөгөөд үүнд сэтгэл зүйн арга онцгой нөлөөлөл үзүүлнэ. Өөрөөр хэлбэл тэднийг үйлдвэртээ ажиллах урам зориг, ирээдүйдээ итгэх итгэлийг бий болгох эрх зүй, материаллаг сонирхлыг бүрдүүлж улмаар эвсэг хамт олныг бүрдүүлнэ гэсэн ойлголт юм.

Хангалттай цалин хөлс, таатай хөдөлмөрийн нөхцөл, удирдлагын анхаарал халамж, материалын болон сэтгэл санааны дэм туслалцаа, шагнал урамшил зэрэг олон асуудал нь сэтгэл зүйн аргад хамаарна. Бизнесменийн ашиг орлого, хуримтлал бий болох зорилго нь эцсийн бүлэгт тухайн хамт олны сэтгэл зүйн тааламжтай орчинг хэрхэн бүрдүүлэхтэй шууд холбоотой байдаг. Иймд Бизнесмен бүр сайн аж ахуйч, байхын сацуу авъяаслаг сэтгэл зүйч халамжлан хүмүүжүүлэгч байх шаардлагатай.

2.§ Аж ахуйн харилцааны эрх зүйн зохицуулалтын хэлбэр

Бизнесменүүд аж ахуйн харилцааны эрх зүйн зохицуулалтын хэлбэрүүдийг ашиглахгүйгээр гэрээ, дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх боломжгүй юм. Хэрэв ашиглахгүй буюу ашигласан ч буруу ашиглавал өөрөө, эсхүл өрөөл бусдыг хохироох болно.

Төлөвлөлт бол эрх зүйн зохицуулалтын нэг чухал хэлбэр байдаг. Монгол орон ардчилал, зах зээлд хөл тавьж эхэлсэн анхны жилүүдэд төлөвлөгөөг үгүйсгэх, ач холбогдлыг бууруулах хандлага байсан, харин сүүлийн үед аж ахуйн нэгжүүд төлөвлөгөөний нийгэм, эдийн засаг, эрх зүйн үнэ цэнийг ойлгож аж ахуйгаа төлөвлөх болж байна. В.Хойер төлөвлөлт гэдэг ойлголтод зорилго ба түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох асуудал багтана. Барууны орнуудад үйлдвэрийн газрын үйл ажиллагааны төлөвлөлт нь борлуулалт, санхүү, үйлдвэрлэл, худалдаа гэсэн нэн чухал чиглэлүүдээр хэрэгжиж байна гэж бичжээ.

Төлөвлөлт нь эдийн засаг, эрх зүйн зохицуулалтын агуулгыг багтаасан ойлголт юм. Эдийн засаг талаасаа тухайн бизнесийн байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний өнгөрсний гүйцэтгэл, одоогийн түвшин, ирээдүйн дүр төрхөд эдийн засгийн үндэслэл бүхий дүн шинжилгээ хийж, түүнийг математик үзүүлэлтээр илэрхийлсэн баримт бичиг буюу мөрийн хөтөлбөр байдаг. Эрх зүйн талаасаа төлөвлөгөө нь тухайн хамт олон өөрсдөө боловсрууж хэлэлцэж баталсан, заавал биелүүлэх хууль зүйн эрх, үүргийг агуулсан эрх зүйн акт байна.

Төлөвлөгөөг хууль, зарчим, хэлбэр гэж ном зохиолуудад бичдэг бөгөөд энэ нь эдийн засгийн амьдралд заавал байх бодит байдал нь хууль, үйл ажиллагааны хөтөлбөр, удирдамж болдгоороо зарчим, аж ахуйн харилцааг зохицуулдаг шинж нь эрх зүйн акт болж байдгаар тайлбарлагдана.

¹ Вольфганг Хойер. "Бизнес хийх ухаан" 2 дэвтэр 1992 5-р талд

Гэрээ аж ахуйн харилцааны эрх зүйн зохицуулалтын хэлбэр байна. Бизнесменүүд аж ахуйн олон талтай ажил, үүргийг гүйцэтгэхдээ гэрээ эрх зүйн харилцаанд зайлшгүй татагдан орох болдог. Материал, түүхий эдээ захиалах, бэлтгэн нийлүүлэх, хэрэглэгчээ сонгож бүтээгдэхүүнээ борлуулах, эд хөрөнгө хөлслөх, түрээслэх, зээл, тусламж, зуучлал г м олон төрөл харилцаанд оролцохдоо гэрээний хэлбэрийг өргөн ашиглана.

Гэрээ, төлөвлөгөө хоёр харьцангуй бие даасан өөр өөр ойлголт болохын сацуу харилцан бие биедээ нөлөөлж нэгнийхээ оршин байх нөхцлийг бүрдүүлж байдаг. Төлөвлөгөө бол аж ахуйг эрхлэн хөтөлж хөгжүүлэх мөрийн хөтөлбөр байдаг бол гэрээ нь төлөвлөгөөний үзүүлэлтийг тодорхойлох (конкретизация), нарийвчлах (детализация) эрх зүйн хэрэгсэл болдог.¹

Бизнесменүүд:

- ∞ Гэрээг заавал байгуулах,
- ∞ Гэрээг хуульд заасан (амаар, бичгээр) хэлбэрийн шаардлагыг хангах
- ∞ Гэрээний нөхцлийн талаар тохиролцох
- ∞ Бүртгүүлэх болон нотариатаар гэрчлүүлэх ёстой гэрээг зохих журмын дагуу гүйцэтгэх
- ∞ Гэрээгээр хүлээсэн үүргийг тохиролцсон нөхцөл болзлын дагуу биелүүлэх
- ∞ Хэрэв гэрээний үүргийг биелүүлээгүй буюу зохих журмаар биелүүлээгүй бол хариуцлага хүлээлгэх зэрэг үндсэн шаардлагуудыг хангасан байх ёстой.

Аж ахуйн хууль тогтоомж. Бизнесийн удирдлагыг хэрэгжүүлэх нэг чухал хэлбэр бол аж ахуйн хууль тогтоомж байдаг. Төрийн эдийн засгийн бодлого нь төрөл бүрийн аж ахуйн хууль тогтоомжийн хэлбэрээр илэрч амьдралд хэрэгждэг байна.

Аж ахуйн хууль тогтоомж нь нийт өмчтөнүүдийн түгээмэл эрх ашгийг хамгаалсан нийтлэг заалттай байхын сацуу бас тодорхой өмчийн төрөл, хэлбэрийг зохицуулсан ялгаварт шинжтэй байдаг. Жишээ нь: Иргэний хууль нь бизнесийн ба бизнесийн бус байгууллага, иргэдэд хамаарч байдаг бол Нөхөрлөлийн хууль нь үүсгэн байгуулагчид нөхөрлөлийг байгуулах, эд хөрөнгөө

¹ А. Г. Быков. План и хозяйственный договор М, 1985 с 31

нийлүүлэх, түүнийг өмчлөх, захиран зарцуулах журмыг заадгаараа өвөрмөц юм.

Хяналт шалгалт. Зах зээлийн тогтолцоон дахь үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах, аж ахуйчлалын эсрэг элдэв сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх, өмчийн халдашгүй эрх, бизнесменүүдийн язгуур эрх ашгийг хамгаалах, хууль ёсыг сахихад хяналт шалгалт ус агаар мэт ач холбогдолтой нь хэнд ч ойлгомжтой.

Бизнесменүүд хяналт, шалгалтаас ангид бус харин уг хэлбэрийг зүй зохистой ашиглах нь бизнесийн зорилгыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болдог. **Хяналт, шалгалтыг:**

1. дотоод хяналт шалгалт
2. гадаад хяналт шалгалт гэж ангилж болно.

Аж ахуйн нэгж хянан шалгагч буюу хяналтын зөвлөлийг байгуулж, түүний эрх үүрэг, ажиллах журмыг дүрмээрээ тогтоох, энэ нь дотоодын хяналт, шалгалт юм. Монгол Улсын Компанийн хуульд: компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг томилон ажиллуулж болно гэж заажээ.

Татварын албаны болон төрийн бусад эрх бүхий байгууллагын шалгалт нь гадаад хяналт шалгалт байна.

Гуравдугаар бүлэг

БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН СУБЪЕКТ

1§. Бизнес эрхлэх хэлбэр

Хүн төрөлхтөн аж ахуйгаа эрхлэхдээ хамгийн энгийн хэлбэрээс эхэлсэн түүхтэйг бид мэдэх билээ. Монгол Үндэстэн ч энэ зүй тогтлыг тойроогүй ирсэн, тэгэхдээ өвөрмөц хөгжлийн зүй тогтлоор бүрэлдэн тогтсон мал аж ахуй, түүнийг адуулж маллах, түүхий эд бүтээгдэхүүнээ боловсруулах, зах зээлд борлуулах, ачлага, тээвэр хэрэглэж ирсэн бөгөөд энэ явцад аж ахуйчлалын төрөл бүрийн хэлбэрийг үүсгэн байгуулж иржээ.

Бизнес эрхлэгч гэж хэнийг хэлэх вэ гэвэл: аливаа иргэн, хуулийн этгээд бүгдийг бус, зөвхөн тодорхой зорилгоор үйлдвэрлэл үйлчилгээг байнга эрхлэж ашиг, орлого хуримтлал бий болгож, түүндээ тулгуурлан нөхөн үйлдвэрлэл явуулдаг субъект хэмээн ойлгож болно.

Иргэн янз бүрийн арга замаар амьжиргааны материаллаг эх сурвалжийг бий болгох бөгөөд үүнийг хураангуйлан ангилж үзвэл **нэгд:** төрийн болон хувийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр хөлсний хөдөлмөр хийсний цалин, олговор, **хоёр:** аж ахуйн нэгж байгуулахгүйгээр төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр тодорхой төрлийн ажил үйлчилгээг байнга эрхлэх, **гуравт:** аж ахуйн аль нэг төрөл нэгж байгуулах хэлбэрээр бизнес эрхлэх, **дөрөв:** аль ч нийгэм, улс оронд зөвхөн бусдын асрамж, дэмжлэг, тэтгэвэр, тэтгэмж (бага насны, өвчний болон өндөр настай гм)ээр амьдардаг хүмүүс байдаг. Эдгээрийн хоёр, гурав дахь нь бизнес эрхлэгч болно. Иргэн бизнес эрхлэхийн тулд ямар шаардлага, нөхцлийг хангасан байх вэ. Юуны өмнө эрх зүйн бүрэн чадвар, чадамжтай монгол улсын иргэн, гадаадын харьяат, харьяалалгүй иргэн ямар ч төрлийн бизнес эрхлэх эрхтэй. Өөрөөр хэлбэл 18 насанд хүрсэн, сэтгэцийн өвчин эмгэггүй, бусдын өмнө эрх эдэлж, үүрэг хүлээх чадамжтай иргэн байна гэж товч хариулж болно.

2§. Аж ахуйн нэгжийг байгуулах нь

Бизнесийн эрх зүйн субъект буюу аж ахуйн нэгжийг иргэн, төр, түүнээс эрх олгосон байгууллага, хуульд заасан бол бусад хуулийн этгээд, гадаад улсын болон, харъяалалгүй иргэн хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулж болно.

Аж ахуй нэгжийг а. Үүсгэн байгуулагчдын харилцан тохиролцсон гэрээний үндсэнд, б. Төрийн эрх бүхий байгууллагын эрх зүйн актын дагуу байгуулна. Аж ахуйн нэгжийг байгуулахад урьдчилсан нөхцлийг хангасан байх ёстой. Тэрхүү урьдчилсан нөхцөл нь:

1. Эд хөрөнгө, түүнийг бүрдүүлэх арга, хэлбэрийг шийдэх,
2. Эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний зорилго, төрөл, чиглэлийг тогтоох,
3. Үүсгэн байгуулагчдын эрх зүйн байдал, тэдгээрийн харилцан тохиролцож хийсэн баримт бичиг (гэрээ, дүрэм) боловсруулах,
4. Зарим үйл ажиллагааг явуулахад эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авах ёстой бол түүнийг авах зэрэг урьдчилсан ажиллагааг хийнэ.

Юуны өмнө аж ахуйн нэгжийг байгуулахад үүсгэн байгуулах баримт бичиг боловсруулах бөгөөд баримт бичиг нь байгуулах аж ахуйн нэгжийн төрлөөс хамаарч өөр өөр хэлбэртэй байна. Тухайлбал хувьцаат компанийг шинээр үүсгэн байгуулахад хувьцааны захиалга авах төсөл, Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг байгуулахад гэрээ, хоршоо үүсгэн байгуулахад **дүрэм**, боловсруулах жишээтэй.

Гэрээ бол сэтгэл санаа, хөрөнгө, хөдөлмөрөө нэгтгэн тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэх, ашиг орлого бий болгох зорилгоор үүсгэн байгуулагчдын эрх үүргийг тодорхойлж, харилцан тохиролцож гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хэлбэр юм.

Гэрээнд: байгуулах аж ахуйн нэгжийн оноосон нэр, харъяалал, орших газрын хаяг, үүсгэн байгуулагчдын нэр, хаяг, мэргэжил, регистрийн дугаар, эд хөрөнгийн нэр, төрөл, түүнийг бүрдүүлэх хугацаа, эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл

чиглэл болон бусад шаардлагатай гэж үзсэн асуудлыг заасан байна.

Дүрэм бол үйл ажиллагааны үндсэн чиглэл, төрөл, зохион байгуулалтын бүтэц, техник, технологийн журам, горим, зардал, ашиг хуримтлалыг бий болгох, хуваарилах, тайлан баланс гаргах, тайлагнах, аж ахуйн нэгжийн удирдах, субъектүүдийн эрх үүрэг зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний дэг журмыг заасан эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичиг юм.


3§. Аж ахуйн нэгжийг бүртгэх нь

Аж ахуйн нэгж байгуулах нөхцөл болзлыг хангаж, бүртгэх байгууллагад бүртгүүлнэ. Аж ахуйн нэгжийг бүртгэж байгаа нь нэгд: аж ахуйн нэгжийн зорилго, эрхлэх үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх, хоёрт: бүрдүүлсэн бичиг баримт ямар нэг зөрчилгүй, хууль зүйн үндэстэй болохыг гэрчилж батлах, гуравт: байгуулах аж ахуйн нэгж нь бизнесийн эрх зүйн харилцаанд оролцох чадвар, чадамжтай болохыг хүлээн зөвшөөрөх, **дөрөвт**: төрийн ивээл, хамгаалалт, хяналтанд орсныг баталгаажуулж буй хэрэг юм. Бүртгэлийг төрийн нэрийн өмнөөс улсын татварын ерөнхий газрын улсын бүртгэлийн алба гүйцэтгэнэ. Татварын алба нь тус улсын болон гадаадын иргэн, байгууллага, хамтарсан үйлдвэр, аж ахуйн газраас авах төрөл бүрийн татварын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн эрх бүхий тусгай байгууллага юм.

Татварын байгууллага нь татвар төлөгчөөс хуулинд заасан хэмжээний татварыг хугацаанд нь хураан авч улсын төсвийн орлогыг бүрдүүлэх үүрэгтэ. Мөн бүртгүүлэлгүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орлогоо нуух, татвар төлөхөөс зайлсхийх, татварын хэмжээг хууль бусаар багасгах, чөлөөлөгдөх гэсэн аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоож, гэм буруутай байгууллага, хүмүүст арга хэмжээ авах эрхтэй байна.

Бүртгэх байгууллагын эрх нь:

1. Бүртгүүлэх гэж байгаа аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагчдаас зайлшгүй шаардлагатай бичиг баримтыг шаардах,



Hecho code

2. Хэрэв хууль ёсоор бүрдүүлэх ёстой бичиг баримтаас гадна тухайн аж ахуйн нэгжийн эрх ашигт зайлшгүй хэрэгцээтэй өөр материал, баримт авах,

3. Бүрдүүлсэн бичиг баримт нь хууль тогтоомжид нийцээгүй, эсхүл бусад шалтгаанаар бүртгэх боломжгүй гэж үзвэл бүртгэхээс татгалзах,

4. Боловсруулсан бичиг баримтыг санхүүгийн болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэх зорилгоор, түүнд засвар, өөрчлөлт хийхийг шаардах зэрэг эрхтэй байна.

Бүртгэх байгууллагын үүрэг нь:

1. Бичиг баримт бүрэн бүрдэл болсон гэж үзвэл түүнд ямар ч хориг саад хийхгүйгээр бүртгэх:

2. Бүртгэгдсэн аж ахуйн нэгжид улсын бүртгэлийн гэрчилгээ олгох:

3. Аж ахуйн нэгжийг бүртгэсэн тухай нийтэд мэдээлэх:

4. Хэрэв аж ахуйн нэгж, түүний гэрээ дүрэм, дүрмийн сан, гишүүний бүрэлдэхүүнд нэмэлт, өөрчлөлт орсныг бүртгэсэн бол энэ тухай зохих шатны статистикийн байгууллагад мэдэгдэж, мөн нийтэд мэдээлэх зэрэг үүрэгтэй.

Бүртгэх байгууллага үндэслэлгүйгээр бүртгэхээс татгалзах, ач холбогдолгүй материал, баримт бичиг шаардах эрхгүй. Үүсгэн байгуулагчид бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдсон гомдол, саналаа харъяа байгууллага буюу шүүхэд гаргах эрхтэй байдаг.

Зарим аж ахуйн нэгжийн эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог шинж байдал, нарийн мэргэжил, ур ухаан шаардаж байвал түүнд тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Тухайлбал төрөл бүрийн зэвсэг үйлдвэрлэх, засварлах, тэсэрч дэлбэрэх болон радио идэвхит, шатамхай бодис бэлтгэх, архи болон бусад согтууруулах ундаа хийх, үнэт цаас үйлдвэрлэх, эд мөнгөний хонжворт сугалаа борлуулах, одон медаль, тамга, тэмдэг хийх, ахуйн зориулалтай химийн бараа, үнэртэн гоо сайхны зүйл бэлтгэх зэрэг ажил үүрэг гүйцэтгэх г м. Эдгээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хүсэгчид өргөдлөө зөвшөөрөл олгох эрх

бүхий байгууллагад гаргана. Эрх бүхий байгууллагад Монгол Улсын Засгийн газар, Дэд бүтцийн Яам, Эрүүл мэнд нийгэм хамгааллын Яам болон тэдгээрийн харъяа мэргэжлийн байгууллага хамаарна.

Эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээ нь байгаль орчины унаган төрх, тэнцвэрт байдал, хүний амь нас, эрүүл мэнд, улмаар улс орны тусгаар тогтнолд нөлөөлөх учраас төрийн хяналтын хэлбэр болох тусгай зөвшөөрлийг олгож байгаа юм.

4§. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа дуусгавар болох

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа дуусгавар болох нь тухайн нэгжтэй холбоотой бизнесийн бүх харилцаа зогсож буй хууль цаазын факт байдаг. Аж ахуйн үйл ажиллагааг:

1. Энгийн аргаар татан буулгах,

2. Албадлагын аргаар татан буулгах гэсэн хоёр хэлбэртэй байна.

Энгийн арга нь:

● Аж ахуйн нэгжийн гэрээ дүрэмд заасан хугацаа дууссан бол үйл ажиллагаа зогсоно. Ийм тохиолдолд нэгжийг татан буулгахгүйгээр үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэхээр шийдвэрлэвэл гэрээ, дүрмээ дахин боловсруулж, бүртгэх байгууллагад бүртгүүлэн гэрчилгээг шинээр авах шаардлагатай байдаг.

● Аж ахуйн нэгжийн үүсгэн-байгуулагчид хугацаанаас өмнө харилцан тохиролцох журмаар нэгжээ татан буулгаж болно.

● Аж ахуйн нэгжийг өөрчлөн байгуулахад (нэгдэх, нийлэх, салах, тусгаарлах) үйл ажиллагаа зогсдог. Жишээ нь хэд хэдэн аж ахуйн нэгж татан буугдаж шинээр нэг нэгж үүсгэн байгуулах г м.

● Аж ахуйн нэгж эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрх үүрэг бүгдийг (худалдах, бэлэглэх г м) бусдад шилжүүлсэн бол үйл ажиллагаа дуусгавар болно. Жишээ нь хувьчлалд улсын үйлдвэрийн газар татан буугдаж, шинээр аж ахуйн нэгж үүсдэг

Албадан татан буулгах арга нь: аж ахуйн нэгж өөрийн зориг санааны дагуу биш, төрийн эрх бүхий (шүүх) байгууллагын шийдвэрээр татан буугдана гэсэн ойлголт юм.

- Гэрээ, дүрэмд зааснаас өөр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэсэн, энэ тухай удаа дараа анхааруулсан боловч үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн,
- Хориотой үйлдвэрлэл эрхлэсэн, жишээ нь хар тамхи, түүнтэй адил чанартай эм урвалж, мансууруулах бодис үйлдвэрлэх г.м,
- Хориотой аргаар үйдвэрлэлийг удаа дараа эрхлэсэн, тухайлбал хөдөлмөр хамгаалал, техник, технологийн дүрэм журам зөрчиж байгаль орчин, хүний биед ноцтой хохирол учруулсан буюу учруулах нөхцөлтэй бол албадан татан буулгана.
- Шударга бус өрсөлдөж, өрсөлдөгчдөө их хэмжээний хохирол учруулсан бол шүүхийн шийдвэрээр албадан татан буулгах үндэслэл болно.

• Аж ахуйн нэгж дампуурсан,

• Монгол улсын компаний хуульд "нэг ч гишүүн үлдээгүй бол шүүх татан буулгана" гэж заасан байна. Субъектгүй эрх зүйн харилцаа байдаггүйтэй адил гишүүнгүй бизнесийн байгууллага байж болохгүй нь ойлгомжтой. Энгийн аргаар татан буулгахыг тухайн нэгжийн хамт олон (бүх гишүүдийн хурал) харин албадлагын аргаар татан буулгахыг шүүх тус тус шийдвэрлэнэ.

Татан буулгах комисс. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа зогссонтой холбогдож түүний эд хөрөнгө, төлбөр, тооцоо, өр ширийн асуудлыг шийдвэрлэх, өөрөөр хэлбэл хуульд зааснаар татан буулгах комиссийг байгуулдаг. Татан буулгах комиссийг бүх гишүүдийн хурал, эсхүл төлөөлөн удирдах зөвлөл томилсоноор нэгжийн удирдлагын бүрэн эрх комист шилжинэ.

Татан буулгах комисс нь:

1. Нэгжийн үйл ажиллагаа зогсоосныг банкны байгууллага ба харилцагч байгууллага иргэдэд мэдэгдэх, үүний дагуу банк төлбөр тооцоо хийж дуусгах, уг аж ахуйн нэгжтэй нэмэж эрх нээж мөнгө санхүүгийн харилцаа тогтоохыг хориглох, харилцагч этгээд нь өр төлбөр, өглөг, авлагаа бодож тооцоо нийлнэ.

2. Өр төлбөрийг хэрхэн барагдуулах арга хэмжээ авах, тухайлбал мөнгөн хөрөнгө нь өр төлбөрийг барагдуулж хүрэлцэхгүй бол бусад эд хөрөнгийг худалдах, шүүхэд аж ахуйн нэрийн өмнөөс оролцох, шүүхийн шийдвэрийн дагуу эд хөрөнгийг дуудлага худалдаанд оруулж борлуулна.

3. Өр төлбөрийг борлуулж дууссаны дараа дуусгалтын баланс гаргах бөгөөд үүний дараа (хуульд заасан тодорхой хугацааны дараа) эд хөрөнгийг хувь нийлүүлэгч буюу гишүүдэд эрэмбэ дарааллын дагуу хуваарилж өгнө.

4. Татан буулгах комисс нь татан буулгахтай холбогдсон бүх асуудлыг хэрэгжүүлсний дараа бүртгэх байгууллагад мэдэгдэх, бүртгэх байгууллага нь бүртгэлээс хассан өдрөөс эхлэн аж ахуйн нэгж татан буугдсанд тооцно.

5. Татан буулгах комиссийн үйл ажиллагаатай холбогдож үүссэн маргааныг шүүх шийдвэрлэнэ.

Дөрөвдүгээр бүлэг

**ХОРШОО, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ****1§. Хоршооны тухай ойлголт**

Хүн төрөлхтөн аж ахуйчлалын урт удаан хугацааны түүхэнд хоршоо, хоршоолол, хорших гэсэн ойлголт эртний гарал үүсэлтэй бөгөөд угтаа үйлдвэрлэл, үйлчилгээг хамтран хийж гүйцэтгэх угта санааг илэрхийлж ирсэн байна. Хоршооллын хөдөлгөөн 17-р зууны үед Францад, 18-р зуунд Англид, 20-р зууны үед Германд анх үүссэн хэмээн ном зохиолд бичсэн нь бий. Энэ нь дээрх орноос бусад улсад хоршооны ямар нэг элемент, хэлбэр байгаагүй гэсэн үг биш, харин хоршооны сонгодог хэлбэрүүд жинхэнэ утгаараа үүсэж, хөгжснийг өгүүлсэн хэрэг юм.

Монголчууд янз бүрийн агуулга, хэлбэртэй ажил, үйлдвэрлэлийг тухайн хэлбэрт нь тохирсон арга замаар хамтран хоршиж хийсээр эдүгээг хүрсэн байна. Хэд хэдэн хот, айл, саахалтаараа хөдөлмөр хүчээ нэгтгэн мал тариулах, оторлох, жин тээх, эсгий хийх, тариа тарих, үүц базаах, мал ноослох, өцөн хороо барих, жижиг гар үйлдвэрлэл эрхлэх зэрэг ажлыг хамтран хийж байлаа. Үүнийг тус орон дахь хамтын хөдөлмөрийн түүхэн хэлбэр, монгол загварын хоршооны дүр төрх хэмээн хэлж болох бүрэн үндэстэй юм. Дээр дурьдсан ажил үүргийг ихэнхдээ ард түмний өвлөж тогтсон заншлын хэм хэмжээ, төрийн хуулиар давхар зохицуулж ирсэн онцлогтой.

Хоршоо нь хувиараа эрхлэх натурал аж ахуйтай харьцуулбал илүү дээд боловсронгуй хэлбэр юм. Нэг хот айл, өрх, эсхүл нэг иргэн, дангаараа аж ахуйн тодорхой зорилтыг хэрэгжүүлэхэд хөрөнгө мөнгө хүч чадал хүрэлцэхгүй байх, үүнээс хамтын хөрөнгө хүч, оюунаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хэрэгцээ буюу сонирхол бий болно. Нөгөө талаар хамтын хөдөлмөрөөр сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, өндөр хүч чадалтай машин, техник худалдан авах, мэрэгжилтэй боловсон хүчин бэлтгэх шаардлага аяндаа урган гардаг. Ийм учраас хууль зүйн хэд хэдэн этгээд нэгдэн хоршоо байгуулах шаардлага аж ахуйн амьдралын гүнээс урган гарах зүй тогтолтой байна.

Хоршоо нь аж ахуйг эрхлэх уламжлалт хэлбэр, бизнесийн эрх зүйн харилцааны нэг өвөрмөц субъект юм.

1998 онд батлагдсан Хоршооны тухай хуульд: материаллаг болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хувь хүмүүс сайн дураараа нэгдэн, ардчилсан удирдлага, хяналт бүхий, хамтран өмчлөх дундын эд хөрөнгө дээр үндэслэн аж ахуй эрхлэх хуулийн этгээдийг хоршоо гэж тодорхойлжээ.

Хоршооны эрх зүй нь хоршоог байгуулах, бүртгүүлэх, үйл ажиллагааг дуусгавар болгох, гишүүнчлэл, хоршооны эд хөрөнгийн болон удирдлага, зохион байгуулалттай холбогдож үүссэн харилцааг зохицуулна.

Хоршооны онцлог шинж нь үүсгэн байгуулагчид анхнаасаа сэтгэл санаа, зорилгоороо нэгдсэн байх явдал бөгөөд энэ талаар зохицоогүйгээр эд хөрөнгөө нэгтгэнэ гэсэн ойлголт байж болохгүй билээ. Үүсгэн байгуулагчид юуны өмнө ямар зорилго, хэлбэртэй хоршоо байгуулж, яаж ажиллах арга зам болон ирээдүйд хүрэх үр дүнгээ харилцан зохицох нь эхний бөгөөд гол шалгуур байдаг.

Хоршоог ямарч төрөл, тухайлбал үйлдвэрлэл, үйлчилгээний, материал, түүхий эд боловсруулах, борлуулалт, хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн, засварын г м олон төрөл чиглэлээр байгуулж болно.

2§. Хоршоог байгуулах, бүртгэх журам

Монгол Улсын иргэн, гадаадын болон харъяалалгүй иргэн өөрийн хөрөнгө хүч, боловсрол, мэдлэг, ур ухаандаа тулгуурлан ямар ч төрлийн хоршоог үүсгэн байгуулах эрхтэй. Хоршоо байгуулахыг ятгах, хориглох эрх хэнд ч байж болохгүй. Хоршооны тухай хуульд 9-өөс доошгүй иргэн хоршоог үүсгэн байгуулж болох бөгөөд үүсгэн байгуулах баримт бичиг нь бүх гишүүдийн **хурлаар баталсан** дүрэм байна гэж заажээ. Дүрэмд дараах зүйлийг тусгана. 1. Хоршооны оноосон нэр, оршин байгаа газрын хаяг байна. Хоршооны нэр нь түүний үйл ажиллагааны агуулгыг илэрхийлсэн оновчтой байхын зэрэгцээ уул, ус нийтэд содон

гавъяат бие хүнээр нэрлэж болно. Өөр хоршооны нэрийг ашиглах, давхардуулах, гадаад үгийг ямар ч утга учиргүй чамирхаж хэрэглэхийг хориглодог. Хоршооны удирдлагын байгаа газар нь түүний орших газар, хаяг байна.

2. Үүсгэн байгуулагч гишүүдийн эцэгийн болон өөрийн нэр, хаяг, үнэмлэхийн дугаар байна. Үүсгэн байгуулагчийн албан ёсны бүртгэлтэй засаг захиргааны нэгж нь оршин суугаа газар болно.

3. Хоршооны зорилго, үйл ажиллагааны төрөл, хугацааг заана. Энэ гурван ухагдахуун хоорондоо холбоотой хоршооны хувь заяаг шийдвэрлэх заалт юм. Өөрөөр хэлбэл үүсгэн байгуулагчид юуны өмнө аж ахуйн зорилгоо тодорхойлж, түүнд хүрэхэд ямар төрлийн ажил, үйлчилгээг, хэдий хугацаанд яаж хэрэгжүүлэх вэ гэдэгт хариулт өгөх заалт байдаг.

4. Үүсгэн байгуулагчдаас хоршоонд оруулах хувь хөрөнгийн хэмжээ, нэр, төрөл, түүнийг бүрдүүлэх хугацаа, хэлбэрийг заах ёстой. (Энэ тухай дараагийн зүйлд үзнэ).

5. Хоршооны гишүүнчлэл, тухайлбал гишүүн элсүүлэх, гишүүнээс гарах, хасах журам, гишүүний эрх, үүрэг, хүлээх хариуцлагын асуудлыг тусгана.

6. Хоршооны удирдлагын бүрэлдэхүүн, түүний бүрэн эрх, шийдвэр гаргах журам, хүлээх хариуцлага. Удирдлагын бүрэлдэхүүнд: бүх гишүүдийн хурал, Тэргүүлэгчид, Хоршооны дарга, Хяналтын зөвлөл байна.

7. Хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах үндэслэл журмыг заана.

8. Хоршоодын холбоонд эвлэлдэн нэгдэх нөхцөл болон үүсгэн байгуулагчид шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг дүрэмд зааж болно.

Хоршооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж, оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ гэж хуульд заасан. Харин гишүүдийн эрх ашиг, ахуй амьдралд болон хоршооны хувь

заяанд эерэг буюу сөрөг байдлаар нөлөөлж болох, тухайлбал хоршооны эрхлэх ажил үүргийг өөрчлөх, гишүүдийн хоршоонд оруулах хувь хөрөнгийн хэмжээ болон тэдний нөхөх хариуцлагын хэмжээг өөрчлөх, хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах зэрэг асуудлыг хуралд оролцсон гишүүдийн дөрөвний гурваас доошгүйн саналаар шийдвэрлэнэ.

Хоршооны дүрэм батлагдснаас хойш 30 хоногийн, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж шийдвэрлэснээс хойш 10 хоногийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэх болон бүртгүүлж байхаар Хоршооны хуульд заасан байдаг. Хоршооны дүрмийг бүх гишүүдийн хурлаас сонгогдсон тэргүүлэгчид шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж бүртгэх байгууллагад өргөдөл гаргана. Өргөдөлд дараах бичиг баримтыг хавсаргасан байх ёстой.

1. Үүсгэн байгуулагч гишүүдийн гарын үсэгтэй дүрэм
2. Үүсгэн байгуулагч гишүүдийн нэрсийн жагсаалт, эцэгийн болон өөрийн нэр, үнэмлэхийн дугаар,
3. Хоршоог байгуулсан хурлын тэмдэглэл,
4. Тэргүүлэгчид болон хяналтын зөвлөл тэдгээрийг сонгосон хурлын тэмдэглэл,
5. Хэрэв эрхлэх үйл ажиллагаа нь заавал зөвшөөрөл авах ёстой бол эрх бүхий байгууллагын зөвшөөрөл байна.

Бүртгэх байгууллага бичиг баримтыг хянан үзэж, шаардлага хангасан бол улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгосноор хоршооны иргэний эрх зүйн чадвар, чадамж бий болж аж ахуй эрхлэх эрх нээгдэж буй хууль зүйн факт юм.

3§. Хоршооны эд хөрөнгийн ба удирдлагын эрх зүйн зохицуулалт

А. Эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт. Хоршооны эд хөрөнгө өмчлөх эрх ямар арга замаар үүсэх, түүнийг хэрхэн эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах, өмчлөх эрх дуусгавар болох нь хоршооны эд хөрөнгийн эрх зүйд хамаарна. Хоршооны эд хөрөнгө өмчлөх эрх нь:

1. Гишүүнээс нийлүүлсэн хувь хөрөнгө
2. Дүрэмд заасан бол гишүүний элсэлтийн татвар
3. Хоршооны үйл ажиллагааны орлогоос нөөц санд хуваарилсан хөрөнгө

4.Бэлэглэсэн, хандивласан хөрөнгө гэсэн эх үүсвэртэй болохыг хуульд заасан байна.

Гишүүд нь хөдлөх ба үл хөдлөх зэрэг биет зүйлээр илэрхийлэгдэх хөрөнгө, мөнгө (төгрөг буюу валют), оюуны өмчийн хэлбэрээр хоршоонд хувь хөрөнгө нийлүүлж болно. Гишүүн оруулсан эд хөрөнгөө хамтран дундаа буюу хэсгээр дундаа өмчилж болох, тэгэхдээ ямар нэр төрлийн эд хөрөнгийг дундаа, эсхүл хэсгээр өмчлөхөө дүрэмд тодорхой зааж тохиролцсон байх шаардлагатай.

Хамтран өмчлөх эд хөрөнгийг бүх гишүүдийн хурлаар, хэсгээр өмчлөх эд хөрөнгийг түүнийг өмчлөгч гишүүний зөвшөөрлөөр тус тус захиран зарцуулах журамтай байна. Хоршоо үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсны эцэст зардлаа нөхөж, гишүүдэд тогтоосон журмын дагуу хувь олгоод, үлдсэн хөрөнгө нь хоршооны **нөөц сан** болох ба энэ нь хоршоонд өмчлөх эрх үүсэх үндэслэл болдог. Болзошгүй алдагдлыг нөхөх, шинэ техник худалдан авах, үйлдвэрлэлээ өргөтгөх, гишүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг **нөөц сан** байгуулж хуримтлуулах шаардлагатай байдаг.

Б.Удирдлагын эрх зүйн зохицуулалт. Хоршооны удирдлагын субъектэд: *бүх гишүүдийн хурал, Тэргүүлэгчид, дарга, хяналтын зөвлөл* байна.

Бүх гишүүдийн хурал. Жилд нэгээс доошгүй удаа хуралддаг бүх гишүүдийн хурал нь хоршооны удирдах дээд байгууллага байна. Бүх гишүүдийн ээлжит хурлыг Тэргүүлэгчид бэлтгэлийг хангаж хуралдуулж, ээлжит бус хурлыг гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар буюу Тэргүүлэгчид, хяналтын зөвлөл ажиллахгүй болсон, ажилласан ч үүргээ гүйцэтгэж чадахгүй бол яаралтай зарлан хуралдуулна. Гишүүд бүх гишүүдийн хуралд биеэрээ оролцож, хэлэлцэж буй асуудалд саналаа өгөх, хэрэв хуралд хүндэтгэх шалтгааны улмаас оролцох боломжгүй бол өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулж эрхээ хэрэгжүүлж болно. Бүх гишүүдийн (ээлжит) хурлыг тайлангийн жил дууссанаас хойш 6 сарын дотор багтаан хийх ба ээлжит бус хурлыг хэдийд ч хийж болдог.

Бүх гишүүдийн хурал нь Хоршооны хуульд заасан нэр бүхий асуудлаас гадна хоршооны үйл ажиллагаатай холбоотой чухал гэж үзсэн асуудлыг хэлэлцдэг.

Тэргүүлэгчид. Бүх гишүүдийн хурлын чөлөө цагт хоршооны бүх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зохицуулах эрх бүхий субъектыг Тэргүүлэгчид гэнэ. Тэргүүлэгчдийн бүтэц, бүрэлдэхүүн, эрх хэмжээ, эрх үүргийг бүх гишүүдийн хурлаас батална.

Тэргүүлэгчид нь нягтлан бодох бүртгэлийг хөтлүүлэх, бүх гишүүдийн хурлыг зарлаж хэлэлцэх асуудал, түүний материалыг бүрдүүлэх, хоршоог шүүхэд болон байгууллага, иргэдтэй харилцахад төлөөлөх, үйлдвэрлэлийн ашиг, алдагдлыг тооцох зэрэг үүрэг гүйцэтгэдэг байна.

Тэргүүлэгчид хууль болон дүрэмд заасан эрх, үүргээ зөрчиж гишүүдийн эрх ашгийг хохироосон, хөрөнгө, мөнгийг зүй бус зарцуулж хоршоог төлбөрийн чадваргүй буюу дампууруулахад хүргэсэн, хоршооны нууцыг задруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дүрэмд заасан арга хэмжээг авдаг.

Дарга. Хоршооны өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий субъект нь дарга байх бөгөөд Тэргүүлэгчдийн дарга нь хоршооны дарга байна. Дарга нь бүх гишүүдийн хурал болон Тэргүүлэгчдийн олгосон эрх хэмжээний хүрээнд бүх гишүүдийн хурлыг даргалах, хоршооноос гаргасан мэдээ, мэдээллийн үнэн зөвийг хариуцах, хөлсөөр ажиллагсадтай гэрээ байгуулах, бүх гишүүдийн ба Тэргүүлэгчдийн хурлын шийдвэр болон төлөөлөх итгэмжлэлд гарын үсэг зурж баталгаажуулах зэрэг үүрэгтэй байна.

Хяналтын зөвлөл. Хяналтын зөвлөл нь:

- 1.Хоршооны Тэргүүлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих,
- 2.Хөндлөнгийн хяналтын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх гэсэн үндсэн хоёр чиг үүрэгтэй байна. Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, огцруулах асуудлыг бүх гишүүдийн хурал шийдвэрлэдэг.

Хяналтын зөвлөл нь шалгалтад холбогдох баримт бичиг шаардан авах, мэдээлэл, илтгэл сонсох, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөвийг шалгах, тайлан балансын гаргалт, ашиг алдагдал, орлогыг хэрхэн хуваарилсан байдалд дүн шинжилгээ хийж бүх гишүүдийн хуралд оруулж хэлэлцүүлэх, Тэргүүлэгчид бусдад зээл олгох асуудлыг шийдвэрлэх зэрэг эрх эдэлдэг.

4§. Хоршооны гишүүний эрх зүйн байдал

Монгол Улсын Үндсэн хуульд хүн бүр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй гэсэн заалтын амьдралд хэрэгжиж буй нэг баталгаа нь иргэн хоршоонд сайн дураараа элсэх явдлаар илэрч байна. Хоршоонд элсэхийг хүссэн иргэн өргөдөл гаргах, уг өргөдөл тухайн хоршооны үйл ажиллагаа, дүрмийн заалт, нөхцөл болзлыг хүлээн зөвшөөрч байгаа, нийлүүлэх хувь хөрөнгийн хэмжээ, нэр, төрөл, холбогдох хариуцлагыг хүлээх чадвар, чадамжтай болохоо илэрхийлсэн байна. Өргөдлийг Тэргүүлэгчид хүлээн авч элсүүлэх асуудлыг бүх гишүүдийн хурал, хэрэв дүрэмд заасан бол тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэж, бүртгэх байгууллагад бүртгүүлнэ. Бүх гишүүдийн хурал буюу Тэргүүлэгчид элсэхийг шалтгаангүйгээр татгалзах, болзол тавих, хууран мэхлэх явдал гаргахыг хориглоно.

Хоршооны хуульд зааснаар гишүүн дараах эрх, үүрэгтэй байдаг. Эрх нь:

1. Хоршооны дүрэмд заасны дагуу хоршооноос зохих үйлчилгээ авах,
2. Өөрийн хүсэлтээр гишүүнээс гарах, дахин элсэх,
3. Хоршооны үйл ажиллагаанд оролцож, Тэргүүлэгч болон Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгох, сонгогдох,
4. Бүх гишүүдийн хуралд оролцож асуулт тавих, санал гаргах, шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцох,
5. Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах тухай санал гаргах,
6. Хоршооны жилийн орлогоос тогтоосон журмын дагуу хувь хүртэх,
7. Жилийн тайланг бүх гишүүдийн хурлаар батлахаас өмнө Хяналтын зөвлөлийн дүгнэлтийг шаардан авах,
8. Бүх гишүүдийн хурлын тэмдэглэлтэй танилцах,

9. Хоршооны гишүүдийн бүртгэлтэй танилцах,

Үүрэг нь:

1. Хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцох,
2. Хоршооны тухай хууль болон Хоршооны дүрэмд, бүх гишүүдийн хурлын шийдвэрийг дагаж мөрдөх, хоршоонд оруулах хувь хөрөнгөө хугацаанд нь бүрэн нийлүүлэх,
3. Хоршооны болон бусад гишүүдийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх,
4. Хаягаа өөрчилсөн нөхцөлд цаг тухайд нь хоршоонд мэдэгдэх.

Гишүүний эрх зүйн байдалд хамаарах нэг асуудал нь гишүүн хоршооноос **гарах, хасах** тухай сэдэв байдаг.

Ямар нэг зөрчил, дутагдал гаргасан үндэслэлээр бус өөрийн хүсэлт, амьдралын гарцаагүй нөхцөл байдлаас шалтгаалж гишүүнчлэлийн харилцаа дуусгавар болохыг **гишүүнээс гарах гэнэ**. Жишээ нь өөр орон нутагт шилжсэнээр Хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцох боломжгүй болсон, өөрт оногдох хувь хөрөнгө бусдад шилжүүлсэн, гишүүн нас барсан г м.

Хоршооны хууль, дүрэм, бүх гишүүдийн хурлын шийдвэрийг санаатай буюу болгоомжгүй зөрчсөнөөс хоршоо, гишүүдийн эрх ашиг, эд хөрөнгөд удаа дараа болон анх удаа ноцтой хохирол учруулсан бол **гишүүнээс хасах** тухай ойлголт гарч ирдэг. Жишээ нь: Хоршооны эд хөрөнгөд хохирол учруулсан, тухайн хоршоотой өрсөлдөх хоршоог өөрөө байгуулсан, эсхүл өрсөлдөгч хоршоонд хувь хөрөнгө нийлүүлсэн г м.

Хоршооноос гарсан, хасагдсан гишүүн нь хувь хөрөнгөө авах эрхтэй бөгөөд тэгэхдээ тухайн хоршооны бусдад өгөх ёстой өр-шир, төлбөр, татварыг бусад гишүүдийн нэгэн адил төлж дуусгаад өөрт ноогдох хувийг авна.

Тавдугаар бүлэг

НӨХӨРЛӨЛ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.§ Нөхөрлөлийн тухай ойлголт

Аж ахуй эрхлэх нэг төрөл бол Иргэний эрх зүй дэх хуулийн этгээдийн эрхийн чадвар, чадамж бүхий аж ахуйн нөхөрлөл юм. Нөхөрлөл нь ашгийн төлөө үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэдэг бизнесийн эрх зүйн субъект болно. Нөхөрлөлийн тухай үзэхийн өмнө уншигч авгай нарын мэдлэгийн санд тус болох үүднээс бяцхан түүхийг товч дурьдах нь зүйтэй гэж үзэв.

Монгол орон зах зээлд шилжсэнээр бизнесийн харилцаа үүсэж, түүний эрх зүйн зохицуулалт болох тулгуур хуулиудыг гаргаж эхэлсэн билээ. 1992 онд "Аж ахуйн нэгжийн хууль"-д ХЭАА Нэгж, Хоршоо, Компани гэсэн гурван субьектийн эрх зүйн байдлыг тогтоосон нэгдмэл хууль үйлчилж эхэлсэн юм. 1994 онд шинэчлэн найруулсан "Монгол Улсын Иргэний хууль" батлах үед нөхөрлөл бол аж ахуйг эрхлэх субьект гээд түүний эрх зүйн е рөнхий үндэслэлийг заасан байна.

1995 онд "Нөхөрлөл", "Компаний хууль", "Хоршооны хуулийг тусгаарлан баталсан юм. Харин ХЭАА нэгж нь хуулийн этгээд буюу бизнесийн эрх зүйн субьект мөн, биш гэсэн мэтгэлцээн өрнөж, эцсийн бүлэгт ХЭАА нэгж нь нэг өрхтэй адил, харин татвар, төлөгч л байна гэсэн үндэслэлээр Иргэний хууль болон бусад аж ахуйн хууль тогтоомжоос хассан билээ. 1999 оны 7 сард "Нөхөрлөл", "Компаний хуулийг "Нөхөрлөлийн тухай хууль", "Компаний тухай хууль" хэмээн тусгай хууль болгон баталсан юм. Нөхөрлөлийн тухай тодорхойлолтыг Монгол Улсын Иргэний хуульд заасан байна. Хуулийн 33 дугаар зүйлд Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ энэхүү эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасан дагуу хариуцдаг этгээдийг нөхөрлөл гэнэ" гэж тодорхойлжээ.

[Нөхөрлөл зөвхөн сайн дурын үндсэнд байгуулагдах зарчимтай. Үүсгэн байгуулагчид аж ахуйн тодорхой зорилгод хүрч, ашиг хуримтлал бий болгохын тул хөрөнгө хөдөлмөрөө нэгтгэн нөхөрлөлийг байгуулах журамтай] Нөхөрлөлийн зорилго, үйл ажиллагааны үндсэн зарчим нь бусад аж ахуйн нэгжтэй адил болохын сацуу ялгаатай байна. **Нэгд:** Нөхөрлөлийн гишүүд нь бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай, зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай гэж ялгавартай байдаг бол бусад аж ахуйн нэгжид ийм шинжгүй байна. **Хоёр:** Хэрэв хоршоо, хувьцаат Компанийг үүсгэн байгуулахад, дүрэм, төсөл боловсруулдаг бол нөхөрлөлийг байгуулахад гэрээг боловсруулдаг. **Гуравт:** Хэрэв хоршооны гишүүн хоршооны үйл ажиллагаа, удирдлагад биечлэн оролцдог бол нөхөрлөлийн удирдлагад зөвхөн бүрэн хариуцлагатай гишүүд оролцдог байна.

Нөхөрлөлийн эрх зүй нь Нөхөрлөлийг үүсгэн байгуулах, бүртгэх, татан буулгах, нөхөрлөлийн эд хөрөнгийн болон удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг зохицуулна.

2§. Нөхөрлөлийг байгуулах, бүртгэх

Нөхөрлөлийг гишүүдийн хүлээх хариуцлага, нөхөрлөлийн үйл ажиллагаанд оролцох байдлыг нь шалгуур болгон

1. Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
2. Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэж хоёр хэлбэрт хуваана.

Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл:

Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хамтран хариуцдаг нөхөрлөлийг бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэж Монгол Улсын Иргэний хууль болон Нөхөрлөлийн хуульд тодорхойлжээ. Энэ заалт нь Нөхөрлөлийн гишүүд бусад байгууллага, иргэдийн өмнө хүлээсэн эд хөрөнгийн үүргийг оруулсан хөрөнгөөрөө, хэрэв хүрэлцэхгүй бол өөрийн хувийн эд хөрөнгөөр бүрэн хариуцах юм гэсэн санааг илэрхийлж байна.

Иймд нөхөрлөлийн үйлдвэрлэл, үйлчилгээг зохион байгуулах, эд хөрөнгийг ашиглах, захиран зарцуулахад бүрэн хариуцлагатай гишүүд заавал өөрөө биечлэн хэрэгжүүлж нөхөрлөлийн хувь заяаг бүрэн хариуцах үүрэгтэй байдаг.

Бүрэн хариуцлагатай гишүүн өөр аж ахуйн нэгжийн гишүүн болон удирдлагад байхыг хуулиар хориглосон нь үүнтэй холбоотой юм. Харин оруулсан хөрөнгөөрөө өөрөө хариуцлага хүлээдэг гишүүн (бүрэн бус хариуцлагатай гишүүн ч гэж нэрлэгддэг) нөхөрлөлд биечлэн ажиллахгүйгээр зөвхөн үйлдвэрлэлийн ашгаас өөрт ноогдох хувиа авах эрхтэй байж болно.

Нөхөрлөлийг байгуулах журам. Нөхөрлөлийг байгуулах анхны бичиг баримт нь үүсгэн байгуулагчдын боловсруулсан гэрээ байна. Гэрээ бол үүсгэн байгуулагчид ашиг олох зорилгоор эд хөрөнгөө нэгтгэн, тодорхой төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийн тулд харилцан бие биенийхээ өмнө хүлээх эрх үүргийг тодорхойлсон хэлцлийн нэг төрөл юм.

Гэрээнд: байгуулах нөхөрлөлийн нэр, орших газар, хаяг, ямар төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээг хэдий хугацаанд гүйцэтгэх, удирдах, төлөөлөх этгээдийн овог нэр үнэмлэхийн дугаар, гишүүдийн нөхөрлөлд оруулах эд хөрөнгийн хэмжээ, нэр, төрөл, үнэлгээ, эд хөрөнгийг буцаан олгох нөхцөл, журам, ашиг алдагдлыг хуваарилах зэрэг асуудлыг тохиролцсон байх ёстой. Хэрэв үүсгэн байгуулагчид шаардлагатай гэж үзсэн бусад зүйлийг гэрээнд тохиролцож зааж болдог.

Гэрээнд үүсгэн байгуулагчдын хэн нь бүрэн хариуцлагатай, хэн нь оруулсан хөрөнгөөрөө хариуцлага хүлээх гишүүн болохыг ялган салгаж бичээд гарын үсгээ зурж нотариатаар гэрчлүүлнэ. Одоогийн дагаж мөрдөж буй Нөхөрлөлийн хуульд нотариатаар гэрчлүүлэх тухай заалт байхгүй. Практикаас харахад үүсгэн байгуулах гэрээ хууль зүйн үндэслэлтэй болсон эсэх, хожим үүсэж болох сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэхэд нотариатын гэрчилгээ хэрэгтэй болох нь үгүйлэгдэж байгаа юм. Нөхөрлөлийг оршин суугаа газрын нь нутаг дэвсгэрийн бүртгэх байгууллага, тэдгээрийн өргөдлийг үндэслэн бүртгэнэ.

Өргөдөлд:

1. Нотариатаар гэрчлүүлсэн үүсгэн байгуулах гэрээ,
 2. Тусгай зөвшөөрөл шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх бол холбогдох эрх бүхий байгууллагын албан ёсны зөвшөөрөл,
 3. Байрлах байр, хэрэв түрээсийн байранд байрлах бол түрээсийн гэрээ буюу түрээслүүлэгчийн баталгаа,
 4. Гишүүдээс нөхөрлөлд оруулсан хөрөнгийн талаар холбогдох байгууллагаас гаргуулсан баталгаа болон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээг хавсаргасан байна. Нөхөрлөлийн нэрийг үүсгэн байгуулагчид тохиролцож өгөх, нэр нь товч бөгөөд төрийн албан бичгээр илэрхийлэгдсэн, бусад нөхөрлөлийн оноосон нэртэй давхардаагүй байх ёстой.
- Бүртгэх байгууллага материалыг хянан үзэж, бүртгэж гэрчилгээ олгосноор нөхөрлөл үйл ажиллагаагаа эхлэх бөгөөд харин гэрээ (хуульд заасан бол дүрэм)-гээр батлаагүй, зорилго нь хуульд нийцээгүй, үүсгэн байгуулагч нь эрх зүйн чадамжгүй оноосон нэр давхардсан, болон бусад шалтгаанаар бүртгэхээс татгалзах эрхтэй байдаг, Бүртгэгдсэн нөхөрлөлийн талаар бүртгэх байгууллага нийтэд мэдээлэх үүрэгтэй.

3§. Нөхөрлөлийн эд хөрөнгийн ба удирдлагын эрх зүйн зохицуулалт

Эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт нь Нөхөрлөлийн эрх зүйн зохицуулалтын чухал хэсэг бөгөөд түүнд нөхөрлөлийн эд хөрөнгө өмчлөх эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох, эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, өмчлөх эрхийг хамгаалах зэрэг асуудал хамаарна.

Нөхөрлөлийн эд хөрөнгийн эрх үүсгэх үндсэн хэлбэр нь үүсгэн байгуулагчдын оруулсан эд хөрөнгө 1.эд юмс. 2.бэлэн мөнгө, 3.оюуны өмч байхаас гадна ажиллах чадвараа нийлүүлж болно.

Үүсгэн байгуулагчид үндсэн ба эргэлтийн хөрөнгийг аль ч хэлбэрээр оруулж болох бөгөөд гэрээгээр тохиролцсон нэр,

төрлийн хөрөнгөө бүгдийг заавал өгсөн байх шаардлагатай. Нөхөрлөлд оруулсан эд хөрөнгийн чанар, үүнийг үүсгэн байгуулагч буюу өмчлөгч өөрөө тодорхойлох, түүнийг бусад үүсгэн байгуулагчид зөвшөөрсөн байна. Хэрэв шаардлагатай бол нарийн мэргэжлийн шинжээчээр чанар, үнэлгээг тогтоосон дүгнэлт гаргуулж болно.

Нөхөрлөлд оруулах оюуны өмчийг заавал үнэлэх шаардлагатай байдаг. Оюуны өмч нь нэгэн сэдэвт зохиол, диссертаци, программ, загвар, төсөл, судалгааны тайлан г м хэлбэртэй байх бөгөөд үнэлгээг мэргэжлийн шинжээч тогтооно. Оюуны өмчийн агуулга нь нөхөрлөлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, техник технологи, удирдлага, зохион байгуулалтад чанарын шинэ, шинэлэг, дэвшилтэд өөрчлөлт оруулахад чиглэсэн хүний оюуны үнэт бүтээл байх юм.

Нөхөрлөлд эд хөрөнгө, оюуны өмчөөс гадна ажиллах чадвараа оруулж болно гэж гадаадын ном зохиолд бичсэн, манай хууль тогтоомжид ч цухалзах болсон юм.¹ Зах зээлийн өндөр хөгжилтэй оронд хүн өөрийгөө үнэлж чаддаг бөгөөд манай улс ч хөгжлийн энэ гольдролоор явж байгаа тул ажиллах чадвараа үнэлж сурах хэрэгтэй болж байна. Хүн өөрийнхөө мэдлэг боловсрол, авъяас, овсгоо самбаа, ур дүйг үнэлж, түүнийг бусад үүсгэн байгуулагчид хүлээн зөвшөөрөх юм. Харин одоогоор хэрхэн үнэлэх арга, арга зүйн талаар нарийвчлан тайлбарлах боломжгүй байгаа учраас эрхэм уншигчдаас хүлцэл өчье.

Удирдлагын эрх зүйн зохицуулалт. Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хувьд аль ч гишүүн ямар нэг болзол, нөхцөлгүйгээр нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй. Харин зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийг зөвхөн бүрэн хариуцлагатай гишүүн удирдах эрхтэй байна. Нөхөрлөлийн үйл ажиллагааны цар хүрээ, гишүүдийн олон цөөнөөс хамаарч нэг буюу хэд хэдэн гишүүн удирдана.

Хэрэв нэг гишүүн удирдаж байгаа бол гишүүдийн хамтын шийдвэрийг, тэднээс олгосон эрх хэмжээний хүрээнд

¹ 1995 онд батлагдсан "Нөхөрлөл Кампанийн хууль"-д нөхөрлөлд ажиллах чадвараа оруулж болно гэсэн заалт байсан бөгөөд дараагийн хуульд оруулаагүй хассан байна.

хэрэгжүүлнэ. Хэд хэдэн гишүүн удирдаж буй бол олонхийн саналаар шийдвэр гаргадаг.

Нөхөрлөлийн удирдлагад бүх гишүүд хяналт тавих эрхтэй. Удирдлагын арга барил, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн байдал, гэрээ, дүрмийн биелэлт, эд хөрөнгө хэрхэн зарцуулж буйд хяналт тавина гэсэн ойлголт болно. Хэрэв удирдлагын арга барилаас шалтгаалж нөхөрлөл болон гишүүний эрх хохирсон, эсхүл хохирч болох байвал удирдлагыг дуртай цагтаа огцруулах эрх гишүүдэд олгогдсон байна.

Нөхөрлөлийн хуульд хянан шалгагч буюу хяналтын зөвлөл байна гэж заасангүй, мөн байж болохгүй ч гэж заасангүй. Иймд нөхөрлөлийн гишүүд шаардлагатай гэж үзвэл хянан шалгагч буюу хяналтын зөвлөлийг ажиллуулж болох бөгөөд түүнийг байгуулах журам, гүйцэтгэх үүрэг нь бусад аж ахуйн нэгжийнхтэй адил байна.

Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, түүний онцлог. Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцдаг, бусад гишүүд нь гагцхүү нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг нөхөрлөлийг зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ гэж хуульд тодорхойлжээ.

Энэ заалт нь нөхөрлөлийн гишүүд бусдын өмнө хариуцлага хүлээх хэлбэрээр, тухайлбал нэг хэсэг нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн гишүүн шиг нөгөө хэсэг нь тийм үүрэг хариуцлага хүлээдэггүйгээр ялгагдаж байна. Нөхөрлөлийн бүх гишүүд бүгд бүрэн бус хариуцлагатай байж болохгүй. Энэ учраас хуульд наад зах нь нэг гишүүн бүрэн хариуцлагатай гэж зориуд заасны утга учир үүнд оршино. Оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг гишүүд нөхөрлөлийн үйл ажиллагаанд биечлэн оролцохгүй байж болдог онцлогтой. Бүрэн хариуцлагатай гишүүн нөхөрлөлөөс гарвал нөхөрлөл татан буугдах үндэслэл болдог бол нөгөө гишүүн гарвал нөхөрлөл татан буугдах үндэслэл болохгүй.

45. Нөхөрлөлийн гишүүдийн эрх зүйн байдал

Нөхөрлөлийн гишүүний эдлэх эрх, хүлээх үүргийг нөхөрлөлийн гэрээ, дүрэмд нарийвчлан зааж баталгаажуулсан байдаг.

Бүрэн хариуцлагатай гишүүд. Нөхөрлөлдөө заавал биечлэн ажиллах, үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахад идэвхтэй оролцох, ажил сайжруулах санал, дүгнэлт гаргах, ашиг алдагдлыг хуваарилагдах биечлэн оролцож шударга зарчим баримтлах, төрийн хууль, гэрээ, дүрмийг хүндэтгэн биелүүлэх, нөхөрлөлөөс гарах зэрэг, эрх, үүрэгтэй байна.

Бүрэн бус хариуцлагатай гишүүд. Нөхөрлөлд гэрээгээр тохиролцсон эд хөрөнгийг хугацаанд нь оруулах, нөхөрлөлийн хуралд оролцож ажил хэрэгч санал, дүгнэлт гаргах, нөхөрлөл татан буугдахад оруулсан хөрөнгөө тэргүүн ээлжинд буцаан авах давуу эрх эдлэх, гишүүнээс гарах болон гэрээ, дүрэмд заасан бусад эрх, үүрэгтэй байна.

Нөхөрлөлийн бүрэн хариуцлагатай гишүүн саналын эрхтэй байх, саналын эрхийн тоог гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээг үндэслэн бүх гишүүдийн хурлаар тогтооно.

Нөхөрлөлд гишүүн элсүүлж болох бөгөөд элсэх гишүүн нь нөхөрлөлийн дүрмийг хүлээн зөвшөөрсөн, зохих журмын дагуу эд хөрөнгө оруулсан, эрх зүйн чадамжтай байхыг шаардана. Гишүүн элсүүлэх асуудлыг бүх гишүүдийн хурал шийдвэрлэдэг. Гишүүн нөхөрлөлөөс гарах эрхтэй. Бүрэн хариуцлагатай гишүүн удаан хугацаагаар өөр газар (*аймаг, хот, гадаадад*) амьдрах болсон, ял шийтгүүлсэн болон өвчний учир нөхөрлөлийн үйл ажиллагаанд биечлэн оролцох боломжгүй болсон бол хоёр байдлаар шийдвэрлэж болох юм. **Нэгд:** гишүүнээс гаргаж ногдох хувь хөрөнгийг буцаан өгөх, **хоёр:** Нөхөрлөлийн гишүүний бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, тухайлбал бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийг зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл болгох г м.

Гишүүнийг нөхөрлөлөөс гаргах тохиолдолд уг гишүүн оруулсан эд хөрөнгөө буцаан авах эрхтэй. Буцаан олгох хөрөнгө нь гишүүний анх оруулсан (биет юмс) эд хөрөнгө (элэгдэл хорогдлыг хасна) үйл ажиллагааны явцад бий болсон ашгаас

гишүүнд ногдох хувь байна. Эд хөрөнгийг биет байдлаар өгөх боломжгүй бол түүний үнийг олгодог.

Хөрөнгө хуваах. Нөхөрлөл татан буугдах, салах, тусгаарлах тохиолдолд хөрөнгө хуваах асуудал гардаг. Нөхөрлөл татан буугдах үндэслэл нь:

1. Бүрэн хариуцлагатай гишүүн нөхөрлөлөөс гарсан, хассан
2. Гишүүн нас барсан, сураггүй алга болсон
3. Хөрөнгийн чадваргүй болж дампуурсан
4. Нөхөрлөлийн гишүүд хугацаанаас өмнө тохиролцож татан буулгаж болно. Эдгээрээс бусад үндэслэлээр татан буугдаж болохыг урьд бүлэгт үзсэн билээ. Гишүүнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлах асуудлыг шүүх шийдвэрлэсэн байх ёстой.

Ийм тохиолдолд нөхөрлөлийн асуудлыг дараах байдлаар шийдвэрлэж болно. Хэрэв бүрэн хариуцлагатай гишүүнд дээрх нөхцөл тохиолдсон бол нөхөрлөл татан буугдах, харин бүрэн бус хариуцлагатай гишүүн байвал татан буулгах асуудал яригдахгүй нь мэдээж.

Сураггүй алга болсон, нас барсанд тооцсон гишүүний эд хөрөнгийг түүний өв залгамжлагчид, хэрэв өвлөгч байхгүй бол төрийн өмчид шилжүүлнэ. Харин өв залгамжлагч нас барагчийн эрх, үүрэг нөхөрлөлийн гэрээ дүрмийг зөвшөөрч гишүүн болохыг зөвшөөрвөл гишүүнээр элсүүлэн авна.

Татан буугдсан нөхөрлөлийн эд хөрөнгийг бүртгэх борлуулах хуваарилах ажлыг татан буулгах комисс гүйцэтгэх бөгөөд ажлын явц эцсийн дүнг гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх үүрэгтэй. Хөрөнгийг дараах дарааллын дагуу хуваарилна. Үүнд:

1. Хэрэв нөхөрлөлд хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад байгаа бол тэдний цалин, олговор
2. Татан буулгах комисс эд хөрөнгийг бүртгэх, борлуулахтай холбогдож гарсан зардал
3. Харилцагч байгууллага, иргэдийн өр төлбөр,
4. Гишүүдийн нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө
5. Үлдэх эд хөрөнгийг гишүүдэд оруулсан хөрөнгөтэй нь хувь тэнцүү хуваана.

Зургадугаар зүйл

КОМПАНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1§ Компанийн тухай ойлголт

Компани гэдэг нь худалдаа, аж ахуйн, тээвэр гэх аж ахуйн болон бизнесийн салбаруудад субъектүүд нэгдэж ажиллах хэлбэр гэсэн утга бүхий франц гаралтай үг аж.¹

Дэлхий улс орнууд хөгжлийнхөө урт удаан хугацааны түүхэнд аж ахуй эрхлэх төрөл бүрийн байгууллага буюу нэгжийг үүсгэн байгуулж ирсний нэг нь компани юм.²

Компанийг зарим улсын хууль тогтоомжид хувьцаат нийгэмлэг, корпораци зэргээр янз бүрээр нэрлэдэг боловч хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө, хувьцаа эзэмшигчид нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага, эрсдэл хүлээдэг зэрэг нийтлэг шинжтэй хуулийн этгээд байна. Аж ахуйн нэгжийн ийм хэлбэр нь Формацын онолын үүднээс нийгмийн хөгжлийг ангилж үзвэл капиталист нийгмийн хөгжлийн эхний үе шатанд капиталист үйлдвэрлэл бий болмогц мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэн тодорхой зорилгоор ашиглахын тулд анх бий болсон² гэж бичих нь бий.

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орж аж ахуй эрхлэх шинэ хэлбэр, төрөл зохион байгуулалтыг бий болгосон бөгөөд хувийн өмчид тулгуурласан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй компанийн эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгохын зэрэгцээ байнга боловсронгуй болгосоор ирсэн. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй компанийн хуулийн үйлчлэх хүрээ, хязгаар нь Монгол улсад байгуулагдсан болон байгуулагдах бүх компаний зохион байгуулалтын харилцааг зохицуулах бөгөөд банк, санхүү, даатгал, хөрөнгө оруулалт үнэт цаасны салбарын болон төрийн

¹ Ф.Н.Петрова "Словарь иностранных слов М 1980г

² Гражданское право, под-ред Е.А. Суханова том 1, М. 1998, стр 20.

өмчит үйлдвэрийн газрыг үүсгэн байгуулах, тэдний эрх зүйн байдлын онцлогийг бусад хуулиар зохицуулах юм.

Компани нь:

1. Хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг нээлттэй хувьцаат компани
2. Хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь компанийн дүрмээр хязгаарлагддаг хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай гэсэн үндсэн хоёр хэлбэртэй байдаг.

Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн тоог компанийн дүрмээр хязгаарладаггүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үүсгэн байгуулагчдын тоо тавиас дээшгүй байх ёстой. Харин хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдсаны дараа хувьцаа эзэмшигчдийн тоог хязгаарлаж болохгүй.

Компани нь хуулиар хориглоогүй ямарч төрлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд үйл ажиллагааны хүрээг компанийн дүрмээр хязгаарлаж болдог. Хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах компани нь холбогдох эрх бүхий байгууллагаас бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр энэ үйл ажиллагааг явуулна. Жишээлбэл архи болон согтууруулах ундааны төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зөвшөөрлийг зөвхөн Монгол улсын Засгийн газар олгодог, зөвшөөрөл аваагүй бол ямар ч компани ийм төрлийн үйлдвэрлэл явуулах эрхгүй.

Хугацааны хувьд дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийг тодорхой бус хугацаагаар үүсгэн байгуулдаг.

Компани нь хуулийн этгээд болох тул заавал оноосон нэр, ялгах тэмдэглэл, бэлгэдэл болон барааны тэмдэгтэй байна. Хуулинд зааснаар компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний тэргүүлэх байгууллагын оршин байгаа газраар тодорхойлдог.

Компани нь салбар болон төлөөлөгчийн газартай байж болох бөгөөд эдгээр нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй, түүнийг



байгуулсан компаниас баталсан журмын дагуу, компанийн нэрийг өмнөөс үйл ажиллагаа явуулдаг.

Салбар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрлах компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэдэг тусгай нэгж юм. Тэгвэл компанийн төлөөлөгчийн газар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрлах компанийн хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, компанийн нэрийг өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулах эрхтэй.

Мөн компанийн тухай хуулинд хараат, охин, толгой компанийн тухай ойлголт шинээр орж ирсэн. Компанийн нийт энгийн хувьцааны 20-51 хүртэл хувийг өөр компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компани хараат компани болно. Хувьцааг эзэмшиж байгаа компанийг толгой компани гэж нэрлэдэг. Харин компанийн нийт энгийн хувьцааны 51-100 хүртэл хувийг өөр (толгой) компани дангаараа эзэмшдэг нэгжийг охин компани гэж нэрлэдэг байна. Хараат, охин, толгой компани нь цөмөөрөө бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдэлдэг.

2§. Компани байгуулах журам

1. Компанийг үүсгэн байгуулах
2. Өөрчлөн байгуулах гэсэн хоёр хэлбэрээр байгуулж болно.

Компанийг шинээр үүсгэн байгуулах. Компанийг үүсгэн байгуулагч, компанийн хувьцаа эзэмшигчид нь зарим тохиолдолд давхцадаг боловч ондоо ойлголт юм. Компанийг үүсгэн байгуулагч нь Монгол улсын иргэн, хуулийн этгээд, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн байж болох бөгөөд эдгээр нь мөн компаниас гаргасан хувьцааны эзэмшигч байж болдог. Харин компанийг үүсгэн байгуулагч нь тухайн компанийн хувьцаа эзэмшигч байх албагүй.

Хуулинд заасан бол төр, түүний байгууллага нь компанийн үүсгэн байгуулагч болон хувь нийлүүлэгч байж болох юм. Төр, түүний байгууллага нь өмч хувьчлалын хуулийн дагуу компанийг

үүсгэн байгуулах буюу төрийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар шинээр бий болсон компанийн хувьцааг эзэмшиж, түүнчлэн дампуурлын хуулиар тогтоосон журмын дагуу дампуурч буй компанийн төрд төлөх өрийн оронд тухайн компанийн хувьцааг худалдан авсан зэрэг тохиолдолд компанийн хувьцаа эзэмшигч байх бөгөөд төр нь эдгээр хувьцааг гурван жилийн дотор худалдах үүргийг хуулиар хүлээдэг. Ингэжээг төрөөс аж ахуйн үйл ажиллагаанд оролцох явдлыг аль болох хязгаарлах, аж ахуй эрхлэх ажиллагааг бизнесийн буюу хувийн секторт шилжүүлэх бодлогыг төрөөс баримталж байгаа юм.

Үүсгэх аргаар нь компанийг нээлттэй болон хаалттай гэж хоёр ангилдаг. Компанийг үүсгэн байгуулагчдын боловсруулсан төслийг нийтэд (нээлттэй) санал болгож хувьцааны захиалга авах, эсхүл хязгаарлагдмал хүрээнд (хаалттай) цөөн тооны этгээдээс захиалга авч шинээр үүсгэн байгуулдаг. Төсөлд компанийг эрхлэх үйл ажиллагааны чиглэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн төвлөрсөн хэмжээ, зарлах хувьцааны тоо, шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагаа явуулах хугацаа, төвлөрсөн ашгийн хэмжээ, захиалга эхлэх дуусах хугацаа зэргийг тусгах ёстой.

Хувьцааны захиалгыг захиалгын хуудсаар авах бөгөөд захиалагч эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурснаар захиалга хийгдсэнд тооцно. Төлбөр хийгдсэн хувьцааны үнийн дүн нь тогтоосон өөрийн хөрөнгийн доод хэмжээнд хүрсэн бол компани байгуулах нөхцөл бүрдсэн гэж үздэг. Өөрийн хөрөнгө гэдэг нь компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн өр төлбөрийг хасаад үлдсэн хөрөнгийг хэлдэг. Компанийг бүртгэх өдөр хувьцаат компанийн өөрийн хөрөнгө нь арван сая, хязгаарлагдмал хариуцлагатай компанийх нэг сая буюу түүнээс дээш байх шаардлагатай. Субъектийн хувьд компанийг хэд хэдэн этгээд хамтран үүсгэн байгуулах эрхтэйгээс гадна нэг этгээд үүсгэн байгуулж болно. Жишээлбэл төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар шинээр бий болсон компанийн үүсгэн байгуулагч нь ямагт нэг этгээд буюу төр, түүний байгууллага байдаг.

Компанийн үүсгэн байгуулах хурлыг үүсгэн байгуулагчид зарлан хуралдуулахын зэрэгцээ үүсгэн байгуулагчдаас хурал даргалагчийг сонгоно. Үүсгэн байгуулагч бүр хуралд саналын

тэнцүү эрхтэйгээр оролцдог. Үүсгэн байгуулах хурлаар компани байгуулах тухай шийдвэр гаргах бөгөөд шийдвэрийг хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар гаргадаг. Компанийг нэг этгээд байгуулж байгаа тохиолдолд тухайн этгээд нь мөн үүсгэн байгуулах шийдвэр гаргах ёстой.

Үүсгэн байгуулах хурлаар хэлэлцэж батлах ёстой нэг асуудал бол компанийн дүрэм юм. Дүрэм бол компанийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг юм. Харин компанийг үүсгэн байгуулах талаар үүсгэн байгуулагчид хамтран ажиллах гэрээ байгуулж боловч энэ нь үүсгэн байгуулах бичиг баримтад хамаардаггүй. Компанийн дүрэмд хуулинд заасан (Компанийн тухай хууль 16 дугаар зүйл) зүйлийг тусгахаас гадна иргэний хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй зүйлийг тусгаж болно. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон, энэ асуудлаар саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнхи олонхоор батлах журамтай юм.

Компани нь улсын бүртгэлд бүртгүүлснээр байгуулагдсанд тооцогдож дүрэмд заасан үйл ажиллагаа явуулна. Өөрөөр хэлбэл компани улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн статус, эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадвар, чадамжтай болдог. Иймд бүртгэлтэй холбоотой харилцааг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай. Үүсгэн байгуулах хурлаас компани байгуулах тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын арван хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгөх ёстой. Холбогдох баримт бичиг гэдэгт компанийн оноосон нэр, оршин байх газар зэргийг заасан эрх бүхий этгээдийн гарын үсэг бүртгүүлэх тухай өргөдөл, шуудангийн хаяг, компани байгуулах тухай үүсгэн байгуулах хурлын шийдвэр, дүрэм, бүртгэлийн хураамж төлсөн баримт бүрдүүлэх өдөр байх ёстой хөрөнгийн доод хэмжээг харуулсан эхлэлтийн баланс зэргийг ойлгоно.

Дээрх бичиг баримтыг бүртгэх байгууллага хүлээн авснаас хойш ажлын гурав хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох, эсхүл компанийг бүртгэхээс татгалзсан

үндэслэл бүхий шийдвэр гаргадаг. Татгалзсан тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл компанийн үүсгэн байгуулагчид нь шүүхэд хандаж гомдол гаргах эрхтэй.

Нөхөрлөл Компанийн тухай хуулиас Компанийн тухай хуулийн ялгагдах нэг онцлог нь бүртгэх байгууллагын эрх хэмжээг харьцангуй багасгаж компани байгуулах шаардлагыг зарим тохиолдолд энгийн болгосон явдал юм. Жишээлбэл Нөхөрлөл, Компанийн тухай хуульд эрхлэх үйлдвэрлэл үйлчилгээний төрлийг заавал тусгах үүрэгтэй бөгөөд бүртгэх байгууллага нь бүртгэгдсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эсхүл түүнтэй холбогдсон бэлтгэл ажлаа эрхлээгүй, үйл ажиллагаагаа эхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаанд тасалдсан тохиолдолд компанийг улсын бүртгэлээс хасах бүрэн эрхтэй байсан бол Компанийн тухай хуульд орсон зохицуулалтаар компани дүрэмдээ эрхлэх үйлдвэр үйлчилгээний төрлийг тусгах шаардлагагүй бөгөөд хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлж болохыг хуульчилсан. Мөн бүртгэх байгууллага компанийг бүртгэхээс хуульд тодорхой тохиолдолд татгалзах эрхтэй боловч, компанийг бүртгэлээс хасах эрхийг эдлэхгүй.

3§. Компанийг өөрчлөх замаар байгуулах

Компанийг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх гэсэн хэлбэрээр өөрчлөн байгуулж болдог. Эдгээр нь тодорхой төрлийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж дуусгавар болгодог хууль зүйн факт юм. Компанийг өөрчлөн байгуулах үед хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн нэг зүйл бол өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувь нийлүүлэгч нь өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол өөрийн эзэмшиж байсан хувьцааг компанид эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхтэй байдгаар илэрнэ.

Компаниуд нийлэх. Хоёр буюу хэд хэдэн компанийн үйл ажиллагааг зогсоож тэдний эрх, үүрэг, хариуцлагыг шинээр буй болсон компанид шилжүүлэхийг компаниуд нийлэх гэнэ.

Компаниуд нийлсэн тохиолдолд тэдгээрийн үйл ажиллагааг дуусгавар болж шинээр өөр нэг компани бий болдгоороо онцлогтой. Нийлж байгаа компаниуд хувь нийлүүлэгчид тус тусдаа хуралдах бөгөөд хурлаар компаниуд нийлэх тухай шийдвэр, гэрээг гаргана. Харин компаниуд нийлснээр шинээр бий болсон компанийн хувь нийлүүлэгчдийн хуралдах хугацаа, товыг гэрээндээ заахаас гадна энэ хурлаар компанийн дүрмийг баталдаг.

Компани нэгдэх. Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр компанид шилжүүлэхийг компани нэгдэх гэдэг. Компани нэгдэх ажиллагаанд нэгдсэн, нэгтгэсэн гэх хоёр субъект оролцох бөгөөд шинээр компани бий болдоггүй, харин нэгдсэн компанийн үйл ажиллагаа нь дуусгавар болж эрх үүрэг нь нэгтгэсэн компанид шилждэг зэргээрээ нийлэхээс ялгагддаг онцлогтой. Компанийг нэгдэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн дийлэнх олонхоор гаргадаг. Нэгдэж байгаа компанийн нийт энгийн хувьцааны 75-аас илүү хувийг эзэмшиж байгаа бөгөөд нэгдсэнээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар нэгдэх тухай шийдвэр гаргаж, нэгдэх журмыг баталж болно.

Компанийг хуваах. Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүргийг шинээр үүсэх компаниудад бүрэн шилжүүлэхийг компанийг хуваах гэнэ. Компанийг хуваах тухай шийдвэрт өөрөөр заагаагүй бол хуваагдаж байгаа компанийн энгийн хувьцаа эзэмшигчид нь компанийн хөрөнгийн хуваагдсан хэмжээтэй хувь тэнцүүлэн шинээр бий болсон компани тус бүрийн энгийн хувьцааны эзэмшигч болно. Шинээр байгуулагдсан компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаар компанийн дүрмийг баталж, хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгодог. Компанийг хуваах тухай гэрээгээр талууд тохиролцоогүй бол шинээр үүссэн компани бүр бусад компанийнхаа өмнөөс давхар хариуцлага хүлээнэ. Давхар хариуцлага гэж чухам юу болох талаар иргэний хууль болон бусад хууль тогтоомжид заалт байхгүй. Иймд давхар хариуцлага гэдгийг хуваагдсан компаниудын хүлээх хамтын

хариуцлага гэж ойлгох хэрэгтэй юм. Гэхдээ хамтын хариуцлага нь зөвхөн компанийг хуваах өмнөх ажиллагааны эрх, үүрэгтэй холбоотой үүсдэг болохоос хуваагдсан компани болгон нэгнийхээ өмнөөс хариуцлага хүлээнэ гэж ойлгож болохгүй.

Компанийг тусгаарлах. Компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим хөрөнгө, эрхийг шинээр байгуулагдсан компанид шилжүүлэхийг компанийг тусгаарлах гэж тодорхойлдог. Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулахад өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигч болно. Иймд тусгаарлагдсан компани нь үндсэн компаниас үүсмэл байдаг. Шинээр байгуулагдсан компанийн хувь нийлүүлэгчдийн хурал нь энэ байгуулагдсан компанийн дүрмийг баталж, хэрэв төлөөлөн удирдах зөвлөл байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүнийг сонгодог. Компанийг тусгаарлахад өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь өөрийн бүх өрийг хариуцна. Өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн өмнөөс түүний өрийг шинээр бий болж байгаа компаниар төлүүлэхийг балансаар тогтоож болно.

Компанийг өөрчлөх. Хувьцаат компани нь хязгаарлагдмал хариуцлагатай, компани болох замаар өөрчлөгдөж болно. Ингэж өөрчлөх төслийг компанийг төлөөлөн удирдах зөвлөл байхгүй бол гүйцэтгэх удирдлага боловсруулан хувь нийлүүлэгчдийн хуралд оруулан уг асуудлаар саналын эрхтэй хуралд оролцогчдын олонхоор шийдвэрлэдэг. Компанийг өөрчлөхөд түүний эрх, үүрэг шинээр бий болж буй компанид шилжинэ. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтөөр үүссэн компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг хуульд заасан журмын дагуу зарлан хуралдуулж компанийн дүрэм, удирдах байгууллагыг шинэчлэн баталж болох бөгөөд үүнийг компанийг өөрчлөх төсөлд зааж өгөх шаардлагатай. Компанийг өөрчлөх тохиолдолд холбогдох өөрчлөлтийг компанийн оноосон нэр болон дүрэмд тусгадаг.

45. Компанийн удирдлагын, эрх зүйн эрх зохицуулалт

Хувь нийлүүлэгчдийн хурал. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал юм. Нэг хувь нийлүүлэгчтэй компанийн хувьд хурлын бүрэн эрхийг хувь нийлүүлэгч өөрөө хэрэгжүүлнэ.

Хувь нийлүүлэгчдийн хурал ээлжит болон ээлжит бус байдаг.

Ээлжит хурлыг хуралдуулах шийдвэрийг компанийн санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага гаргах бөгөөд ингэж зарлан хуралдуулаагүй тохиолдолд хяналтын зөвлөл эсхүл компанийн аль нэг хувь нийлүүлэгч хурлыг зарлан хуралдуулах эрхтэй.

Шаардлагатай тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага), эсхүл саналын эрхийн 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчдийн санаачлагаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. Хувь нийлүүлэгчдийн хурлаар компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах, компанийг өөрчлөн байгуулах, компанийн өрийг хувьцаагаар солих зэрэг компанийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой чухал асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг. Хэлэлцэх асуудлыг хууль болон компанийн дүрэмд зааж өгөхөөс гадна төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж болно.

Хувь нийлүүлэгч нь:

1. Өөрийн биеэр
2. Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлж
3. Өөрөө хуралд оролцоогүй ч гэсэн санал авах хуудсаар саналаа ирүүлэх гэсэн гурван замаар хувь нийлүүлэгчдийн хуралд оролцдог. Харин компанийн хувьцааг хэд хэдэн этгээд дундаа хэсгээр өмчилж байгаа тохиолдолд хуралд оролцож санал өгөх эрхийг тэдний харилцан тохиролцооноор хэн нэг нь, эсхүл тэдний хамтын төлөөлөгч хэрэгжүүлнэ.

Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийн эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид хуралд оролцооноор хурлын ирц (кворум) буюу хурал хүчин төгөлдөр болдог. Кворум гэдэг нь ямар нэг байгууллагын хуралд оролцогч эрх бүхий этгээдийн шийдвэр гаргахад хангалттай хууль буюу дүрмээр заасан тоо гэсэн утга бүхий латин үг юм. Дээрхи хувь хэмжээ хүрээгүй бол хүчин төгөлдөр бус гэж үзэж дахин хуралдах өдрийг товлону. Харин хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж болохгүй бөгөөд хойшлогдсон хурал ажлын хорь хоногийн дотор хуралдаж чадахгүй бол шинээр хурал зарладаг. Хурлаар хэлэлцэж буй асуудлын ач холбогдлыг харгалзан компанийн дүрэмд хувь нийлүүлэгчдийн хурлаас шийдвэр гаргах кворумыг өөрөөр тогтоож болох юм.

Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр гаргах санал хураалт нь энгийн болон эчнээ гэсэн хоёр хэлбэртэй. Хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулж санал хураалт явуулсан бол энгийн гэнэ. Хурал хуралдуулахгүйгээр хувь нийлүүлэгчдээс эчнээ санал хураалт явуулж болно. Энэ тохиолдолд хувь нийлүүлэгч хуралд заавал оролцох шаардлагагүй. Гэхдээ ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар оруулж болохгүй.

Энгийн болон эчнээ санал хураалтын алиныг нь ч санал хураах хуудас ашиглан явуулдаг. Санал хураах хуудас нь хуулинд заасан тодорхой бүрдүүлбэртэй. Хуудасны агуулга, загварыг төлөөлөн удирдах зөвлөл, (байхгүй бол гүйцэтгэх удирдлага) батална.

Санал хураалтыг явуулах аргаар нь ердийн болон кумулятив гэж хоёр ангилдаг. Ердийн журмаар саналаа өгөхөд "зөвшөөрсөн" "татгалзсан" "түдгэлзсэн" алин болохыг тэмдэглэсэн саналын хуудас байна. Эдгээрийн зөвхөн нэгийг нь тэмдэглэсэн бол хүчин төгөлдөр гэж тооцдог. Кумулятив гэдэг нь сонгогч нь нэр дэвшигч болгоны тоогоор саналын эрх эдлэх гэсэн утга бүхий мөн латин гаралтай үг. Өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигч бүр төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байх аргаар сонгоно гэж ойлгож болно.

Хувь нийлүүлэгчдийн хурлын ажиллагаа болон санал хураалтыг тооллогын комисс зохион байгуулах бөгөөд хувьцаат компанийн хувьд тооллогын комиссыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл томилон ажиллуулдаг. Тооллогын комиссын үүргийг хөндлөнгийн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр хувь нийлүүлэгчдийн хурлаас тогтоож болно. Хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн албан тушаалтан болон эдгээр хүмүүстэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр томилохыг хуулиар хориглодог.

Хурлын протоколыг ажлын 15 хоногийн дотор гаргаж дарга гарын үсгээ зуран үнэн зөвийг нь хариуцна. Тэмдэглэлд хурал болсон он, сар, өдөр, газар, цаг зэрэг заавал тусгах зүйлийг хуульчилсан байдаг. Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэлд алдаа гаргасан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэс болохгүй.

Төлөөлөн удирдах зөвлөл. Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь хууль буюу дүрмээр хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн хамааруулснаас бусад хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Төлөөлөн удирдах зөвлөлийг гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтоодог. Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх шаардлагатай. Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаагаа хуралдааны хэлбэрээр явуулах бөгөөд компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хурлыг сард нэг удаа хийнэ. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх удирдлага болон дүрэмд заасан бусад этгээд төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг санаачлах эрхтэй. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

Хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд саналын нэг эрхтэй оролцдог. Компанийн дүрмээр тусгайлан өндөр хувь тогтоогоогүй бол хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болох ба хурлын шийдвэр нь тогтоол байна. Мөн тэмдэглэлийг хөтөлж хурал хийсэн газар, цаг, хуралд оролцсон гишүүд, хэлэлцэгдсэн

асуудал, санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн, гаргасан шийдвэр зэргийг заавал тусгах ёстой.

Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувь нийлүүлэгчдийн хурал хийх өдрөөр дуусгавар болох бөгөөд гишүүнийг улируулан сонгож болдог. Харин төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүдээс нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

Гүйцэтгэх удирдлага. Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал)-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын ажиллагааг удирдан зохион байгуулагч мөн. Хуулинд зааснаар гүйцэтгэх удирдлагыг хувь хүн болон хэсэг этгээд гүйцэтгэж болох юм. Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд нь гүйцэтгэх захирал байна. Багаар гүйцэтгэж байгаа тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдож багийн гишүүдийн ажиллах дотоод журмыг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр баталж түүний дагуу ажиллана. Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна. Гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгах ёстой. Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд гүйцэтгэх удирдлага нь хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна. Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл хувь нийлүүлэгчдийн хурал хэдийд ч гаргах эрхтэй.

Хянан шалгах зөвлөл. Хувьцаат компани нь хяналт шалгах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компани хянан шалгах зөвлөлтэй байж болно гэж хуулинд заасан байдаг. Өөрөөр хэлбэл хувьцаат компани заавал хянан шалгах зөвлөлтэй байдаг бол хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хяналтын зөвлөл байгуулж ажиллуулах нь түүний удирдлагын үзэмжийн асуудал юм. Хянан шалгах зөвлөлийн гишүүдийн тоо тэдгээрийг сонгох журам, бүрэн эрхийн хугацаа, эрх, үүргийг компанийн дүрмээр тогтоодог тул хянан шалгах зөвлөл нь

компанийн удирдлагын нэг хэсэг болох бөгөөд компанийн дотоод хяналтын гүйцэтгэнэ.

Хянан шалгах зөвлөлийн үүргийг нэг хянан шалгах хэрэгжүүлж болдог. Гэхдээ энэ тухай компанийн дүрэмд зааж өгөх ёстой. Хувь нийлүүлэгчидийн хурлаас зөвлөлийн гишүүдийг сонгох бөгөөд хянан шалгах зөвлөлийн гишүүд нь компанийн эрх бүхий албан тушаалтан байхыг хуулиар хориглодог зүй ёсны асуудал юм. Хянан шалгах зөвлөл нь компанийн эрх ёсны нийлүүлэгчидийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болов санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувь нийлүүлэгчидийн хуралд танилцуулах, хувь нийлүүлэгчидийн санал гомдлын дагуу компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгах, хувь нийлүүлэгчидийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах эрхтэй байдаг.

Аудитын хяналт. Компани нь санхүүгийн тайланг шалгах баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг томилуулж ажиллуулна. Аудитор нь компанийн удирдлагын бүтцэд орохгүй харин гэрээний үндсэн дээр санхүүгийн хөндлөнгийн шалгалтыг хэрэгжүүлдэг нарийн мэргэжлийн эрх бүхий этгээд, байгууллага байна. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл байхгүй бол хувь нийлүүлэгчидийн хурал аудиторыг сонгож түүнтэй байгуулах гэрээний төслийг баталдаг. Гэрээнд компанийн болон аудиторын эрх, үүрэг, хариуцлага, түүнд төлөх хөлсний хэмжээг заах ёстой.

Аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байдаг. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийдэг бол ээлжит бус шалгалтыг төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл энгийн хувьцааны арваас дээш хувийг эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийх эрхтэй. Аудиторын ээлжит шаардлагын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүнийг захиалж гэрээг нь байгуулж хийлгэсэн хувь нийлүүлэгч хариуцаж төлдөг. Аудиторын шаардлагаар компанийн эрх бүхий албан тушаалтан санхүү, эдийн засгийн талаархи баримт бичгийг танилцуулах үүрэгтэй. Аудитор нь баримтын шалгалтыг үндэслэн дүгнэлт гаргах бөгөөд хувь нийлүүлэгчидийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэйгээр оролцож болдог.

5§. Компанийн хийх зарим төрлийн хэлцэл, түүний эрх зүйн зохицуулалт

Шинээр батлагдсан компанийн тухай хуульд иргэний эрх зүйн урьд өмнө хэрэглэгдэж байгаагүй олон нэр томъёо орсон. Ийм нэр томъёоны нэг нь их хэмжээний хэлцэл юм. Их хэмжээний хэлцлийг хуулинд шууд зааж өгсөн. Үүнд:

1. Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл.

2. Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо холбоотой хэд хэдэн гаргалтыг их хэмжээний хэлцэл гэж тодорхойлсон.

Хууль зүйн агуулгаараа их хэмжээнийх нь хүчин төгөлдөр хэлцэл. Харин их хэмжээний хэлцлийг хийх эрх бүхий этгээд, түүний гаргах шийдвэрийн зохицуулалтаас нь шалтгаалан бусад төрлийн хүчин төгөлдөр хэлцлээс өөрөөр тодотгож нэмж нэрлэх шаардлагатай болсон. Их хэмжээний хэлцлийг хийх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл санал нэгтгэйгээр гаргадаг. Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэй гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувь нийлүүлэгчидийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувь нийлүүлэгчидийн саналын олонхоор шийдвэрлэдэг.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл. Энэ хэлцэл нь сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүхээс хүчин төгөлдөр бусад тооцож болох хэлцлийн нэг төрөл юм. Хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх журам, хэлцэл хийх сонирхол бүхий этгээдэд хуулиар тавигдсан шаардлагыг хуулинд заасан этгээд зөрчсөнөөр (компанийн тухай хуулийн 88, 89 дүгээр зүйл) бий болно. Хэрэв хуулинд заасан журам, шаардлагыг зөрчөөгүй бол хэлцлийг хүчин төгөлдөр гэж үзэх бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар гаргадаг.

Долоодугаар бүлэг

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1§. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ойлголт

А.Хөрөнгө оруулалтын тухай товч мэдэгдэхүүн. Аливаа улс орны нийгэм, эдийн засгийн өсөлт дэвшилтэд гадаадын хөрөнгө оруулалт онцгой ач тустай болох нь дэлхийн улс гүрнүүдийн хөгжлийн замнал, дүр төрх бэлхнээ харуулж байна.

Монгол улс ч энэ жишгийг харгалзан төрөөс гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих, эрх зүйн таатай нөхцөл бүрдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, олон хамтарсан аж ахуйн нэгж байгуулагдах болов.

Бизнес эрхлэгчид шинээр аж ахуйн нэгж байгуулах, байгуулснаа өргөтгөхөд хөрөнгийн эх үүсвэрийг урьдчилан шийдвэрлэх ёстой. Хөрөнгө оруулалт нь гадаадын болон дотоодын байгууллага, иргэдийн урт, богино хугацаатай зээл, тусламж, хандив, улсын төвлөрсөн төсөв, гадаадын хөрөнгө оруулалттай дагнасан буюу хамтарсан аж ахуйн нэгж байгуулах гэсэн хэлбэртэй байж болдог.

Гадаадын хөрөнгө оруулах, түүнийг ашиглах, захиран зарцуулах явцад эрх зүйн тодорхой харилцаа үүсдэг.)

Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүй нь хөрөнгө оруулагч ба хамтрагч (Монголын талын иргэн, аж ахуйн нэгж) талуудын эрх, үүрэг, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах, урамшуулах, аж ахуйн нэгж байгуулах, бүртгүүлэх, татан буулгах явцад үүссэн харилцааг зохицуулна.

Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн үндсэн зорилго нь Монгол улсын эдийн засаг аж ахуйн хөгжлийг түргэтгэх, ард иргэдийн амьдралыг сайжруулах, оруулсан хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, хөрөнгө оруулагчийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгддэг.)

Б. Хөрөнгө оруулагч ба хамтрагч талуудын эрх зүйн байдал. Монгол улсын тусгаар тогтнол, байгаль орчны тэнцвэрт байдал, иргэдийн эрүүл ахуй, эрх чөлөөг хамгаалахын зэрэгцээ хөрөнгө оруулж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн ашиг олох сонирхол бүхий этгээдийг хөрөнгө оруулагч гэнэ. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалж, хөрөнгийг өөрт болон хөрөнгө оруулагчид үр өгөөжтэй ажиллах тааламжтай нөхцөл бүрдүүлж хамтран ажиллагчийг хамтрагч гэнэ.)

Хөрөнгө оруулагчийг гадаадын ба дотоодын гэж хувааж болох юм. **Нэгд:** Монгол улсад хөрөнгө оруулж буй гадаадын хуулийн этгээд, харьяалалгүй иргэн, гадаад улсад байнга оршин суугаа монгол улсын иргэн, гадаадын хөрөнгө оруулагч байна. **Хоёрт:** Монгол улсын хуулийн этгээд, Монгол улсад байнга оршин суугаа гадаадын ба харьяалалгүй иргэн дотоодын хөрөнгө оруулагч байна.

Хөрөнгө оруулагч нь:

1. Эрхийн чадвар, чадамжтай,
2. Байнга оршин суух нутаг, оронтой, тэндээ албан ёсны бүртгэлтэй,
3. Өөрөө эд хөрөнгөтэй, түүнийгээ өөрөө мэдэж захиран зарцуулах эрхтэй байхыг шаардах бөгөөд эдгээр шинж байхгүй бол хөрөнгө оруулагч гэсэн ойлголтыг бүрдүүлж чадахгүй.)

В.Хөрөнгө оруулалтын төрөл. Хөрөнгө оруулагч, хамтрагч хоёр тал монголын газар нутаг, нийгэм эдийн засаг, амьдралын нөхцөл байдал, зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан хөрөнгө оруулалтаар өмчийн ямар зүйл байхыг тохиролцох учиртай. Өмчийн төрөл нь: 1. Хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгө, 2. Манай нутагт чөлөөтэй хөрвөх валют, 3. Үйлдвэрлэл, үйлчилгээний эцэст олсон ашиг (Монгол төгрөгөөр) 4. оюуны болон аж үйлвэрийн өмч байна.)

Г. Хөрөнгө оруулагчийн сонирхол. Хөрөнгө оруулагчид өөрийн эд хөрөнгөө гадаад, харийн нутагт байрлуулж, ашгийн төлөө ажиллах учраас манай орны тааламжтай зайлшгүй харгалзан үзэх болдог. Энэ ч зүй ёсны хэрэг мөн. Бусад улс оронд хөрөнгөө цацаж үрэн таран болгохыг хэн ч хүлцэхгүй нь мэдээж.

(Хөрөнгө оруулагчид юуг тааламжтай нөхцөл гэж үзэх вэ? гэвэл. **нэгд:** хөрөнгө оруулах гэж буй орны улс төрийн тогтвортой байдлыг сонирхдог.) Хэрэв засаг төр хямралтай, засгийн газар ахархан хугацаанд олон огцорч, солигдох, үүнтэй холбогдож төрийн байр суурь, бодлого өөрчлөгдөх нь хөрөнгө оруулагчдад ашиггүй байдаг, (**хоёрт:** Монгол улсын хуулиуд, тэр дундаас иргэний, гаалийн, татварын, газрын г м хуулийг анхаарна.) Тухайлбал манай хуулиуд хөрөнгө оруулж, үйлдвэрлэл, борлуулалтад ямар саад хориг байгаа, гааль, орлогын татварын хөнгөлөлт байгаа эсэхийг сонирхдог. (**Гуравт:** Монголчуудын аж амьдрал, соёл, сэтгэл зүйн чадавхи, ялангуяа манай бизнесменүүдийн мэдлэг, чадвар, ур ухааныг анхаардаг.) Хүнлэг чанар, мэдлэгтэй бизнесменүүдтэй түншлэхийг хичээх нь хэнд ч ойлгомжтой.

Д.Хамтрагч талын сонирхол. Хамтрагч тал өөрийн эрх ашгийг гол зорилго болгохын зэрэгцээ хөрөнгө оруулагчийн ашиг сонирхолыг онцгой анхаарч боломжтой бүх арга хэмжээг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой. Юуны өмнө хөрөнгө оруулагч чухам хэн бэ гэдгийг судлах, үүний тулд хир хэмжээний хөрөнгө, төлбөрийн чадвартай, зах зээлд нэр хүнд ямар зэргийг анхаарах нь чухал байдаг.

Хөрөнгө оруулагчийн мэргэжилтэн, инженер, менежер болон бусад ажиллагсдын ажиллаж, амьдрах нөхцөл орчинг бүрдүүлэх, болон үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангах хэрэгтэй байна. (Энэ нь хөрөнгө оруулагчид таатай нөхцлийг хир хангаж чадна, тэр хэмжээгээр өөрийн орлого нэмэгдэнэ гэсэн эцсийн сонирхолтой байна гэсэн ойлголт болно.)

2§. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн эрх зүйн байдал

А. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг байгуулах журам. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуульд: (Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, дүрмийн сангийн 20-оос доошгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн аж ахуйн нэгжийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж (ГХОААН) гэнэ) гэж тодорхойлжээ. 20 хувиас доош бол ГХОААН-ийн статусыг илэрхийлж чадахгүй юм.

(ГХОААН-ийг 1. гадаадын хөрөнгө оруулагч дангаараа 100 хувь хөрөнгө гаргаж байгуулах, 2. гадаадын хөрөнгө оруулагч өөрийн салбар нэгжээ шинээр нээж байгуулах, 3. Манай хөрөнгө оруулагчтай хамтран хөрөнгө оруулж аж ахуйн нэгж байгуулах гэсэн гурван хэлбэрээр байгуулна. ГХО-тай аж ахуйн нэгж байгуулахад: 1. Өргөдөл, 2. Гэрээ, 3 Дүрэм, 4. техник эдийн засгийн тооцоо (төсөл) гэсэн баримт бичгийг монгол хэл болон хөрөнгө оруулж буй талын албан ёсны хэл дээр боловсруулна.) Өргөдлийг хоёр тал хамтран эсхүл гадаадын хөрөнгө оруулагч 100 хувийн хөрөнгө оруулагч бол дангаараа гаргадаг.

(**Өргөдөлд:** гэрээ, дүрэм, төсөл болон хөрөнгө оруулагчийн танилцуулга, хөрөнгө оруулалттай холбоотой маркетинг, менежмент технологийн хэлэлцээр, хөрөнгө оруулагчийн төлбөрийн чадварын тухай үйлчлэгч банкны нотолгоо зэргийг хавсаргах үүрэгтэй байна.)

Хөрөнгө оруулагч иргэн буюу байгууллага хэн болохыг бүх талаас нь үнэн зөв тодорхойлсон (**баримт бичиг бол танилцуулга юм.** Танилцуулгад байгууллага бол түүний нэр, улсын харьяалал, хаяг, утас, телекс, факсын дугаар, байгуулагдсан он, бусад оронд салбар нэгжтэй эсэх, үйлчлэгч банкны нэр, хаяг бичигдсэн байна.) Хэрэв иргэн бол овог, нэр, иргэний харьяалал, паспортын төрөл, дугаар, боловсрол мэргэжил, эрхэлж буй ажил зэргийг тодорхойлдог. (Танилцуулга нь тухайн улсын эрх бүхий байгууллагаар баталгаажсан байх ёстой.)

Хөрөнгө оруулагч ба хамтрагч талууд аж ахуйн нэгж байгуулах, ямар төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ гүйцэтгэх талаар харилцан тохиролцож гэрээ байгуулах үүрэгтэй.

Гэрээнд: эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацаа, дүрмийн сан, ногдол хувь, хувьцааны тоо, нэг бүрийн ба нийт үнэ, хөрөнгө оруулагчдын оруулах эд хөрөнгийн хэлбэр, хэрэв хугацаандаа оруулаагүй бол хүлээлгэх хариуцлага, аж ахуйн нэгжийн удирдлага, хяналтын зөвлөлийг сонгох журам, эрх, үүрэг болон бусад зүйлийг тусгана.

Дүрэмд: үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах техник технологийн журам, эд хөрөнгө ашиглах, захиран зарцуулах, ашиг, алдагдал хуваарилах, ня-бо бүртгэл, тайлан тэнцэл гаргах журам, ажиллагсдын ахуйн хангамж, маргааныг шийдвэрлэх болон шаардлагатай гэж үзсэн бусад зүйлийг дүрмээр тогтоож болно.

Б.Техник эдийн засгийн тооцоо. Шинээр байгуулах аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээний чадавхийг эдийн засгийн бүх боломжит үзүүлэлтээр гаргах ёстой. Энэ нь үйдвэрлэлийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон төлөвлөгөө болно. Төлөвлөгөө нь үйдвэрлэл, борлуулалт, санхүү, худалдаа гэсэн гол чиглэлүүдтэй байх бөгөөд эдгээр нь хоорондоо нягт уялдсан байдаг. Тухайлбал, үйлдвэрлэл үйлчилгээний зорилго, хөрөнгийн нарийвчилсан судалгаа, материалын зарцуулалт, техникийн процесс ажиллах хүчний хэрэгцээ, түүнийг хэрхэн хангах гэх мэт олон үзүүлэлтүүдийг хангах болдог. Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгж техник эдийн засгийн ямар түвшинд үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж, хэрэглэгчийн эрх ашигт тохирсон, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөхгүй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ хийж эцсийн бүлэгт үр ашигтай байх ирээдүйн шинж төлвийг илэрхийлсэн баримт бичиг мөн.

В. ГХОААН-ийг бүртгэх журам. ГХОААН-ыг бүртгэх, хянах үйл явц нь бусад (манай үндэсний) аж ахуйн нэгжийг бүртгэхтэй ерөнхийдөө төсөөтэй боловч зарим нэг онцлог байдаг. Тэрхүү онцлог нь хууль ёсоор бүрдүүлсэн баримт материалаа өргөдөлд хавсаргаж ГХОГХА-т өгнө. ГХОГХА нь өргөдлийг хүлээн

авч бүрдүүлсэн материалыг бүрдэл болсон гэж үзвэл, хүлээн авсанд тооцох бөгөөд энэ өдрөөс эхлэн хуульд заасан хугацаанд үйлдвэрлэл үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулахын зэрэгцээ бусад нөхцөл байдлыг нарийвчлан тогтоох үүрэгтэй. Үүнд:

1. Бүрдүүлсэн бичиг баримт манай үндэсний болон олон улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх,
2. Хүрээлэн буй байгаль орчны унаган төрхийг хамгаалах нөхөн сэргээх талаар авахаар төлөвлөж буй арга хэмжээ нь байгаль орчныг хамгаалах хуульд тохирох эсэх,
3. Эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээ нь эрүүл ахуйн стандартад тохирч буй эсэх,
4. Техник технологи нь техникийн түвшинд тавих шаардлага хангасан эсэхийг тогтооно.

Дурьдсан нөхцөл байдлыг хангаагүй бол Худалдаа үйлдвэрлэлийн сайдын зөвлөл хуралдаж аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл өгөхөөс татгалзах эрхтэй. Хэрэв зөвшөөрсөн бол сайд тушаал гаргаж, уг тушаалыг үндэслэн гэрчилгээ олгодог. Гэрчилгээ олгосны дараа Үндэсний татварын ерөнхий газар бүртгэн нийтэд мэдэгдсэнээр аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлнэ.

Аж ахуйн нэгжийн гэрээ, дүрэм, дүрмийн санд өөрчлөлт орсон тохиолдолд аж ахуйн нэгж анхлан байгуулдаг журмын дагуу бичиг баримтыг шинээр боловсруулж урьд дурьдсан эрэмбэ дарааллын ёсоор гүйцэтгэх журамтай.

Г. ГХОААН-ийн үйл ажиллагааг зогсоох. Монгол Улсын аж ахуйн хууль тогтоомжид аж ахуйн нэгжийг татан буулгах талаар заасан заалт ГХОААН-д нэгэн адил хамаарах бөгөөд тэгэхдээ зарим нэг онцлог байдаг.

ГХОААН татан буулгах эцсийн шийдвэрийг ГХОГХА гаргана. Агентлаг нь аж ахуйн нэгж гэрээ дүрэмд заасан үүргээ зөрчсөн бол өөрийн санаачлагаар, харин аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагааг зогсоохоор шийдвэрлэсэн бол түүний хүсэлтээр шийдвэрлэдэг.

Худалдаа Үйлвэрлэлийн яам нь татан буугдаж байгаа аж ахуйн нэгж төлбөр тооцоогоо бүрэн дуусгасан, байгаль орчныг тухай Байгаль орчны яамны баталгаа болон бусад шаардлагатай материалыг хүлээж авна. Яам материалыг хянан үзээд урьд эрх Улсын татварын ерөнхий газар бүртэлээс хасаж, энэ тухай нийтэд мэдээлэх журамтай.

Худалдаа Үйлдвэрийн яам нь ГХОААН ийг зөвхөн бүртгэх зөвшөөрөх, үйл ажиллагааг нь зогсоох эрх, үүрэгтэй биш юм. Яам нь хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжид хяналт тавих, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл зарлах, шалгаруулах, хөрөнгө оруулалтын талаар төрийн нэгдсэн бодлого боловсруулах зэрэг үүрэгтэй байна.

Наймдугаар бүлэг

ӨРСӨЛДӨӨН, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1§. Өрсөлдөөний тухай ойлголт

Зах зээлийн нэг содон шинж буюу эдийн засаг, аж ахуйн амьдралын жам ёсны үзэгдэл бол өрсөлдөөн юм. Дэлхийд өрсөлдөөнгүй зах зээл гэж байдаггүй. Харин ч шударга өрсөлдөөн тэмцэл баймааж үйлвэрлэл, үйлчилгээний хүч чадал дээшлэх, бүтээгдэхүүний яс чанар, загвар нь хэрэглэгчийн хэрэгцээг хангаж, эцсийн бүлэгт улс орны эдийн засгийн хурдыг тодорхойлох нэг хүчин зүйл болдог жамтай аж.

Өрсөлдөөн гэдэг ухагдахуун бидний энэ бүлэгт авч үзэх аж ахуйн харилцаанд төдийгүй улс төрийн, сонгуулийн, албан тушаалын, үзэл бодлын г м. нийгмийн амьдралын өргөн хүрээнд хэрэглэгддэг ойлголт юм. Аливаа өрсөлдөөн нь тодорхой зорилго, үр дүнд нэг нь нөгөөгөөсөө урьтаж хүрэх буюу бүтээхийн тулд тэмцэлдэж буй субъектүүдийн үйлдэл байдаг.

Аж ахуйн харилцаан дахь өрсөлдөөн нь зах зээлийн эдийн засгийн амьдралд зайлшгүй байх юм бол түүний дотоод мөн чанар, илрэх хэлбэр, эрх зүйн үр дагаврыг танин мэдэх нь чухал юм. Өөрөөр хэлбэл өрсөлдөөн гэж юу болох, хэрхэн, яаж, юугаар өрсөлдөх, ямар өрсөлдөөнийг шударга гэх, өрсөлдөөнд төрийн эрх, үүрэг, байр суурь зэргийг мэдэх хэрэгтэй гэсэн үг юм.

Иймд өрсөлдөөн бол зах зээлийн нөхцөлд хүний хүссэн, хүсээгүй зайлшгүй байх нийгмийн үзэгдэл, үйл явц тул төрийн оролцоо, эрх зүйн зохицуулалт шаардлагатай байдаг. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 1-р зүйлд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагааг хориглон хязгаарлах, урьдчилан сэргийлэх эрх зүйн болон зохион байгуулалтын үндсийг тодорхойлж хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна гэж хуулийн зорилтыг тодорхойлсон байна.

Өрсөлдөөний эцсийн зорилго нь тодорхой зах зээл, хэрэглэгчийг сонгон авч түүнийг чанартай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр тогтвортой хангаж, өөртөө татахад чиглэгдэх учиртай. Энэ үйл ажиллагаа нь эрх зүйн хэм хэмжээний дагуу зохицуулагддаг.

Бүх төрөл чиглэлийн ажил үүрэг гүйцэтгэдэг аж ахуйн нэгжүүд хоорондоо өрсөлдөхгүй нь мэдээж. Ийм учраас өрсөлдөөн нь үйлдвэрлэлийн, үйлчилгээний, үнэт цаасны, худалдааны, санхүүгийн, оюуны өмчийн, хөдөлмөрийн г.м төрөлтэй байна. Нэг төрлийн бараа, бүтээгдэхүүнийг тодорхой зах зээлд нийлүүлж буй хоёр буюу түүнээс дээш субъектүүдийн хооронд өрсөлдөөн үүснэ.

Зах зээлд өрсөлдөгчид бие биенээ таньж мэдсэн байх шаардлагатай. Үүний тулд **нэгд**: өрсөлдөгчийнхөө санхүүгийн чадвар; тухайлбал төлбөрийн чадвар, өр зээлийг төлөх чадвар, ашигт ажиллагаа, санхүүгийн ачааллын индекс зэргийг судалж тодорхойлох хэрэгтэй. **хоёрт**: өрсөлдөгчийн шинжлэх ухаан, техникийн түвшин, мэргэжилтэн, судлаачдын мэдлэг, чадвар, нэр хүндийг мэдэх шаардлагатай, өрсөлдөгч нь үйлдвэрлэл, үйлчилгээнд орчин үеийн тэргүүний дэвшилтэд арга ажиллагааг ямар хэмжээ, түвшинд авч чадаж байгааг судлана. **гуравт**: өрсөлдөгчийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, түвшинг мэдэх хэрэгтэй. Энд удирдлагын арга барил, үйлдвэрлэлийн процессийн төрөлжилт, хоршилт, хөдөлмөрийн нөхцөл, технологийн сахилга бат, хөдөлмөрийн норм, норматив г.м. асуудал хамаарна. **дөрөвт**: өрсөлдөгчийн олж авсан зах зээл, уг зах зээлд түүний нэр хүнд ямар байгааг судлах хэрэгтэй.

Нэг зах зээлд олон, эсхүл цөөн өрсөлдөгч байх нь өрсөлдөөн болон хэрэглэгчийн нөхцөл байдалд нөлөөлдөг. Жишээ нь олон өрсөлдөгч оролцож байвал үнийн хэлбэлзэл их, харин цөөн өрсөлдөгч байвал үнэ харьцангуй тогтвортой буюу бага байна. Иймд өрсөлдөгчид аль болох цөөн, худалдан авагчид нь олон өрсөлдөгчтэй байхыг сонирхож байдаг.

Өрсөлдөөн шударга байх ёстой бөгөөд үүний тулд төр ямар өрсөлдөөнийг шударга ба шударга бус болохыг зөвшөөрсөн,

хориглосон эрх зүйн хэм хэмжээг батлан гаргасан байна. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 5-р зүйлд:

1. Давамгайлах байдал,
2. Ноёрхогч
3. Зүй ёсны ноёрхогч (монополь) гэж гурав ангилж, давамгайлах байдал, зүй ёсны ноёрхогчийг зөвшөөрч, хууль бус ноёрхогчийг хориглосон байна!

Зах зээлд тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын гуравны нэгээс дээш хувийг дагнан буюу бусад этгээдтэй хамтран хийж байвал давамгайлах байдалтай гэж үзнэ.

Давамгайлах байдлаа хууль бусаар ашиглах, өрсөлдөгчөө зах зээлд ороход саад учруулах, өрсөлдөөнийг болон хэрэглэгчийг хясан боогдуулахыг ноёрхох үйл ажиллагаанд тооцож, ийм төрлийн үйл ажиллагаа явуулсан этгээдийг ноёрхогч гэж үзнэ. Тухайлбал бүтээгдэхүүний зах зээлд нийлүүлэлт хийж байгаа нэг этгээд байхад л нийгмийн дундаж зардал, хамгийн бага байх зах зээлд дангаараа үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийг **зүй ёсны монополь** гэж үзнэ гэж тус тусад нь тодорхойлсон байна.

2§. Шударга бус өрсөлдөөн

Хууль ёсоор давамгай байдалтай болсон өрсөлдөгч, нэгэнт олж авсан давамгай байдлаа урвуугаар ашиглаж, зах зээлд өрсөлдөгч гаргахгүйн тулд түүний эсрэг аливаа хууль бус үйлдэл хийхийг хориглодог. Тухайлбал зохиомлоор барааны хомсдол бий болгож үнийг өсгөх зорилгоор өөрийн барааны үйлдвэрлэл, борлуулалтыг зогсоох, хэмжээг хязгаарлах эсхүл бараагаа зардлаасаа доогуур үнээр худалдах, өрсөлдөгчийн барааг худалдан авахгүй байх болзол тулгах, өрсөлдөгчөө салах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, татан буулгахыг шаардах г. м.

Эдгээр хууль бус үйлдэлүүдээс нэг жишээ авч тайлбарлавал давамгай байдалтай аж ахуйн нэгж шинээр гарч ирсэн өрсөлдөгчийг шахан зайлуулах зорилгоор талхны үйлдвэрлэлээ зогсоовол өрсөлдөгчийн талх зах зээлийг хангах нь

хомсдож, үүнийг дагалдан үнэ өсөх, хэрэглэгч хохирох, эцсийн бүлэгт шинэ өрсөлдөгчийн төлбөрийн чадвар доройтох болон дампуурахад хүрнэ. Өрсөлдөгчөө салах, тусгаарлахыг шаардах гэдэг нь түүний хөрөнгө, мөнгө санхүүгийн хүчин чадлыг сулруулна гэсэн үйлдэл болно.

(Давамгайл болсон аж ахуйн нэгж өрсөлдөөнд саад учруулахад чиглэсэн хэлцэл хийх, өрсөлдөгчөө эрхшээлдээ авахаар элдэв үйл ажиллагаа хийх, өрсөлдөгчийн хувьцааг худалдан авах зэрэг үйлдлийг хориглохоор хуульд заажээ.)

Өрсөлдөөнд харш үйл ажиллагаа. (Зах зээлийн орнуудын хууль тогтоомжид дараах үйл ажиллагааг өрсөлдөөнд харш хэмээн үзэж хуульчилдаг. Энэ жишгийг ч манай улс хуулиндаа заасан байна.)

1. Өрсөлдөгчийн болон түүний барааны нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах.

2. Өөрийн болон өрсөлдөгчийн үйлдвэрийн газар, түүний байршил, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн арга хэрэглээний шинж чанарын гол үзүүлэлт хэрэглэх аргын талаар худал зөрүүтэй мэдээлэх, бусдыг төөрөгдүүлэх,

3. Өөрийн барааг бусдын бараатай ижилсгэн сурталчлах. Ийнхүү өрсөлдөгчийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүний талаар худал зөрүүтэй мэдээ сурталчилгааг санаатай буюу болгоомжгүйгээр тарааснаар өрсөлдөгчийн ажил хэргийн нэр хүнд болон үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд хохирол учруулсан эсхүл зайлшгүй учруулах нөхцөл бүрдсэн байна. Худал хуурмаг мэдээг телевиз, радио, хурал цуглаан, сонин, сэтгүүл, хэвлэлд бичих¹ болон бусад энгийн хэлбэр, аргаар тараасан байдаг.

(4. Бараа бүтээгдэхүүн сурталчлахаар өгсөн захиалгын хугацаа, дарааллыг зөрчих маш их өрсөлдөөн бүхий барууны эдийн засгийн бүх салбарт ямар нэг зарлал, сурталчилгаагүйгээр

¹ Т. Мөнхжаргал "Иргэний эрх зүй" (үүргийн тусгай төрөл) 1998 УБ 165-р талд

ганц ч пүүс оршин тогтож чадахгүй² гэж гадаадын ном зохиолд тэмдэглэсэн байдаг. Зар сурталчилгаа бол үйлдвэрлэл, үйлчилгээний зорилго, үйл ажиллагааны бүх хүрээ, эсхүл тодорхой объектыг хамарсан байх бөгөөд түүнийг буруу зөрүү сурталчлах, зохих хугацаа, дарааллыг зөрчвөл өрсөлдөөнд сөрөг үр дагавар бий болгодог байна. Зар сурталчилгаа нь бизнесийн байгууллага өөрийн зах зээл, хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлж тэднийг өөртөө татах хэрэгсэл болдог онцлогтой.

(5. Бусдын барааны тэмдэг, шошиг, үйлдвэрийн нэр, барааны чанарын баталгааг дур мэдэн хэрэглэх, түүнчлэн барааны оноосон нэр, баглаа боодлыг хуулбарлах.)

Бараа бүтээгдэхүүний нэр, тэмдэг, шошго бол:

а. тухайн аж ахуйн нэгжийн эд хөрөнгийн өмчлөх эрхийг илэрхийлэх,

б. өөрийнхөө болон тухайн бараагаа бусдад сурталчлах

в. хэрэглэгчийг өөртөө татах хэрэгсэл болдог. Бусдын барааны нэр, тэмдэг, шошгыг дур мэдэн хэрэглэх нь өрсөлдөгчийн үйл ажиллагаанд хохирол учруулж, түүний өмчлөх эрхийг ноцтой зөрчиж буй хууль бус үйлдэл болно.

(6. Ивээн тэтгэгч этгээд ивээн тэтгүүлж байгаа этгээдээс өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаа явуулахыг шаардах.) Ивээн тэтгэгч нь тэтгүүлэгчид хөрөнгө, мөнгө санхүүгийн зээл, тусламж, хандиваар барьцаа, болзол, түүгээр хууль бус үйлдэл хийхийг тулган шаардаж болохгүй. Хууль бус үйлдэл нь тэтгүүлэгчийн бараа, бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ зах зээл, үнийг тогтоох, өрсөлдөгчтэйгээ хууль бус хэлцэл хийхийг тусгах г.м. хэлбэрээр илэрдэг.

(7. Барааны чанарын доголдол, аюултай шинж чанарыг нуун дарагдуулах.) Энэ нь иргэний эрх зүйн зарчмаас урган гарч байгаа юм. Худалдагч нь барааны ил далд согог гэмтэл, хэрэглэх арга, ачих буулгах хадгалах нөхцөл журмыг худалдан авагчид мэдэгдэх үүрэгтэй байдаг. (Аж ахуйн нэгж нь худалдагдаж байгаа барааны согог гэмтэл аюултай байдлыг мэдэгдэлгүй нууснаас худалдан авагч буюу өрсөлдөгчид хохирол учирч, үйлдвэрлэлийн ашиг, орлогод сөрөг нөлөөлж болно.)

² Вольфганг Хойлер. "Бизнес хийх ухаан" 1992. УБ, 104-р талд

35. Өрсөлдөөнд төрийн гүйцэтгэх үүрэг

Төр шударга өрсөлдөөнийг бүх талаар дэмжих, шударга бус өрсөлдөөнийг хориглох үүрэгтэй. Энэ нь төрийн эдийн засгийн бодлогын салшгүй нэг хэсэг байдагтай холбоотой юм. Төр аж ахуйн нэгжүүд хоорондын шударга бус өрсөлдөөнийг хориглохын сацуу төр өөрөө, тухайлбал төрийн болон орон нутгийн захиргаанаас шударга өрсөлдөөнд харшлах шийдвэр гаргахыг хориглодог байна. Хууль ёсоор байгуулагдсан аж ахуйн нэгж зөвшөөрсөн үйлдвэрлэл эрхлэх, бүтээгдэхүүнээ борлуулахыг, борлуулах зах зээл тогтоохыг, зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан шийдвэр гаргахыг хуулиар хатуу хориглосон байдаг. Мөн төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага нь зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны, нэр, төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилахад чиглэсэн болон нэг аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг өөр аж ахуйн нэгжид зээл олгохоор шийдвэрлэх эрхгүй байна.)

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах алба. Энэхүү алба нь шударга бус өрсөлдөөнтэй холбогдох бүх асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг юм. "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль"-д зохицуулах алба нь шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, таслан зогсоох, өрсөлдөөнд оролцож, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагааг шалган дүгнэлт гаргах, аж ахуйн нэгжийн давамгайл байдал болон зүй ёсны монополь байдалтай, түүнчлэн тэр байдлаа алдсаныг тогтоох болон шударга өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэх санал боловсруулан холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлэх үүрэгтэй гэж заажээ.)

Хяналтын албаны эрх үүрэг. (Шударга бус өрсөлдөөнтэй холбоотой хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, давамгайл байдалтай ба зүй ёсны ноёрхогч зохих журмын дагуу өрсөлдөөнд оролцож байгаа эсхүл, түүнчлэн тэр байдлаа алдсан шалтгааныг судалж тогтоох асуудлыг Засгийн газарт оруулж батлуулах үүрэгтэй.

Давамгайл байдлаа хууль бусаар ашиглаж буй аж ахуйн нэгжийг салгах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулахыг тухайн аж ахуйн нэгжийн удирдлагаас шаардах, шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргах эрхтэй байна. Мөн хууль бус өрсөлдөж байгаа аж ахуйн нэгжийг захиргааны шийтгэл оногдуулах эрх эдлэнэ.


Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийг зөрчиж гаргасан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийг хүчингүй болгуулах саналыг холбогдох дээд байгууллагад албан тушаалтанд гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй гэж хуульд заасан юм.) Холбогдох дээд байгууллагад тухайн шийдвэрийг хүчингүй болгох эрх бүхий байгууллага байна.

Хариуцлага. (Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж зөрчсөн аж ахуйн нэгж, албан тушаалтанд дараах арга хэмжээ авна.

1. Хууль тогтоомжийг ноцтой зөрчиж өрсөлдөгчид болон хэрэглэгчдэд хохирол учруулсан нь эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байвал.

2. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал Хянан зохицуулах албаны улсын байцаагч дараах арга хэмжээ авахаар хуульд заасан юм. Үүнд: давамгайл байдлаа шударга өрсөлдөөнд харшаар ашигласан, өрсөлдөгч аж ахуйн нэгж өрсөлдөөнд саад учруулсан хэлцэл хийсэн, өрсөлдөөнд харш үйл ажиллагаа хийсэн, өрсөлдөгчөө эрхшээлдээ авахаар завдсан буюу авсан бол хуульд заасан хэмжээний торгуулийг оногдуулах эрхтэй.)

Давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн удирдлага өрсөлдөгч аж ахуйн нэгжийн удирдлагад ажилласан, давамгайл байдалтай аж ахуйн нэгж өрсөлдөгч аж ахуйн нэгжтэй нэгдэж, нийлсэн бол зөрчсөн албан тушаалтныг торгож, зөрчил гаргахаас өмнөх байдлыг сэргээн тогтоодог.



Есдүгээр бүлэг

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ДАМПУУРЛЫН
ТУХАЙ ОЙЛГОЛТ**

1. § Дампуурлын тухай ойлголт

Сүүлийн үед аж ахуйн нэгжийн дампуурал хэмээх ойлголт бий болж, түүнийг зохицуулсан эрх зүйн акт гарсан нь тус оронд зах зээлийн эдийн засгийн харилцаа бий болсонтой холбоотой. Дампуурал гэдгийг хамгийн энгийнээр өгүүлбэл аж ахуйн нэгж сайн ажиллавал оршин тогтнох, муу ажиллавал устана гэсэн ойлголт аж. Ер нь аливаа иргэн, айл өрх, аж ахуйн нэгж, цаашилбал улс гүрэн оюун мэдлэг, овсгоо самбаатай ажиллавал өсөж өндийж өнгөтэй өөдтэй амьдрах, хэрэв тэгж чадахгүй бол өнгө зүс хүчин чадал буурсаар устаж үгүй болдгийг бид төсөөлөх билээ.

Аж ахуйн нэгжийн дампуурал нь зөвхөн капиталист нийгэмд байдаг, харин социалист оронд гарах, нийгэм, эдийн засгийн үндэсгүй хэмээн ойлгож байлаа. Энэ нь өмч улсын гарт төвлөрч, ямар үйлдвэрлэл явуулж, хэн борлуулахыг төлөвлөгөөгөөр шууд нэр заан гүйцэтгүүлж, хэрэв бүтээгдэхүүн нь борлогдохгүй буюу чанар муутай байсан ч захиргааны аргаар борлуулж, алдагдалтай үйлдвэрт тотац хэмээх зээл, тусламж өгч амьдруулж байсан учир аж ахуйн нэгж дампуурч байсангүй.

Тэгвэл өнөөдөр өмч хувьд шилжиж, өмчлөгчид дуртай аж ахуйн нэгжээ байгуулан, үйлвэрлэл үйлчилгээ эрхлэж, түүнийхээ хувь заяаг өөрөө мэдэж захиран зарцуулах болж байна. Энэ нь хэн сурч ажиллаж чадна, тэр амьдрана гэсэн зах зээлийн амьдралын хууль үйлчилж буй онцгой шинж юм.

Өмчлөгчид үйлдвэрлэлээ зөв сонгон авч зохион байгуулан, хэрэглэгчийн хэрэгцээ эрх ашигт тохирсон чанартай бүтээгдэхүүн хийхийн төлөө бусад аж ахуйн нэгжтэй хүч, оюун ухаанаараа уралдах бөгөөд энэ нь эцсийн бүлэгт өрсөлдөөн гэдэг ойлголтыг бий болгодог байна. Иймд дампуурал нь өрсөлдөөнтэй

холбоотой гэж хэлж болох боловч өрсөлдөөнд ялагдсан бүхэн дампуурна хэмээн туйлшруулж бас болохгүй.

Өрсөлдөөнд ялагдсан ч үйл ажиллагаа, чиглэлээ өөрчилж зохион байгуулагдан цаашид ажиллаж болно. Аж ахуйн нэгж дампуурахад олон хүчин зүйл нөлөөлөх бөгөөд тэдгээрийн заримыг хураангуйлсан авч үзье.

Нэгд: Үйлдвэрлэл, үйлчилгээний зохион байгуулалт, бүтэц, байршлыг зүй зохистой тогтоогоогүй, удирдлагын арга барил, эв дүйн хувьд алдаатай ажилласан

Хоёрт: орчин үеийн тэргүүний шинэ техник технологийг үйлвэрлэлдээ нэвтрүүлээгүй, өөрөөр хэлбэл хуучин буюу хуучирсан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийг солих, сэлбэх ажиллагаа хийгээгүй,

Гуравт: бүтээгдэхүүнээ борлуулах зах зээл, болон гадаад дотоодын найдвартай түншээ сонгож олоогүй, оллоо ч түншийнхээ итгэл найдварыг хөсөрдүүлсэн,

Дөрөвт: нарийн мэрэгжлийн боловсон хүчин болон менежер, удирдах ажилтныг бэлтгэх, давтан сургах талаар хангалтгүй ажилласан,

Тавд: захиалгагүй буюу борлогдохгүй, хэрэглэгчийн хэрэгцээг хангаж чадахгүй бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн,

Зургаад: сэтгэл санаа болон гар нийлсэн, эвсэг бүтээлч хамт олныг бүрдүүлээгүй, үйлдвэрлэл, үйлчилгээний сахилга, дэг журам задгайрсан зэрэг зүйлүүдийг нэрлэж болох юм.

Аж ахуйн нэгж дампуурах нь ихэнхдээ өөрөөс шалтгаалахаас гадна өөр хүчин зүйл нөлөөлөх нь ч бий. Тухайлбал төрийн эдийн засгийн бодлого, татвар, гааль орлогын албан татвар алдаатайгаас аж ахуйн нэгжүүдийг төлбөрийн чадваргүй болгох, байгаль цаг уурын гэнэтийн аюулд нэрвэгдэж дампуурах тохиолдол ч байж болох юм.

Аж ахуйн нэгжийн өрсөлдөөн, дампуурал нь зах зээлийн харилцаанд зайлшгүй байх нийгмийн үзэгдэл боловч түүнийг заавал байх ёстой хэмээн төрөөс зөнд нь орхих биш эрх зүйн зохицуулалт шаардлагатай байдаг. Учир нь дампуурал нь улс орон ард түмний хувь заяатай холбоо бүхий нийгмийн/сөрөг үзэгдэл тул дампуурлаас урьдчилан сэргийлэх, нэгэнт

Нэхэмжлэгчдийн санал хүсэлт болон шуухийн шаардлагаар хэдэн ч удаа хийж болох бөгөөд хуульд зааснаар шийдвэр нь хуралд оролцсон нэхэмжлэгчдийн

Нэхэмжлэгчдийн төлөөлөл шүүхэд томдол, санал тавих, зөвлөл нь хэрэг гүйцэтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, нэхэмжлэгчдийн зөвлөлийг байгуулж болно. Нэхэмжлэгчдийн

3. Нэхэмжлэгчдийн тоо 7-оос дээш байвал асуудлыг хэлэлцдэг.

2. Хэрэг гүйцэтгэлийг батлуулах, баталсан хэрэг гүйцэтгэлийн үйл ажиллагаанд томдол гаргах, түүнийг өөрчлөх, шийдвэрлэнэ.

Нэхэмжлэгчдийн шаардлагыг хангаж чадах эсэх асуудлыг хэлэлцэж эд хөрөнгө, мөнгө түүний хэмжээ, чанар, үнэ, төр нь санхүү, тайлан ба гялалт хэлэлцдэг. Өөрөөр хэлбэл харьцангуй баталсан бол түүний биелэлтэд хяналт тавих, харьцангуйн өөрчлөжүүлэх төлөвлөгөөг батлах эсэх, хэрэг төлөвлөгөөг шийдвэрлэнэ. Үүнд: 1. Харьцангуйг дампууруулахгүйгээр дахин

Нэхэмжлэгчдийн хурал дараах асуудлыг хэлэлцэж эгтээдийг оролцуулж болно.

Нэхэмжлэгчдийн хурал. Нэхэмжлэгчдийн хурлыг шүүх зохион байгуулна. Тухайлбал нэхэмжлэгчдийн хурал хийх он, сар, өдөр, газар, нэхэмжлэл гаргах журам, хугацаа, нэхэмжлэлийг тогтоосон хугацаанд гаргаггүйгээс үүсэх үр дагавар зэргийг шүүх зарлана. Нэхэмжлэгчдийн хуралд харьцангээс авлагатай иргэн, хуулийн этгээд заавал оролцохоос гадна харьцангид өргөтгөж

Шүүх дампуурын хэрэг үүсэх тухай нэхэмжлэл, хэргийг хүлээж авах, хэрэг үүсэх, шийдвэрлэхээр иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар ерэмбэ дараалал, зарчим, процессийн дэг журмыг баримтлахын сацуу зарим нэг өвөрмөц ойлгог байна. Жишээ нь: нэхэмжлэл, хүсэлт хуульд заасан шаардлага хангасан гэж шүүгч үзвэл түүнийг үндэсн авснаас хойш 5 хоногийн дотор дампуурын хэрэг үүсгэх тухай захирамж гаргана. Харьцангуйг төлбөрийн чадваргүй болсныг тогтоосноос хойш 7 хоногийн дотор шүүх энэ тухай мэдээллийн хэрэгсэлээр нийтэд мэдээлнэ г м. (шүүхийн процессийн ажиглалаар дампуурын тухай хуулийн 5, 6, 7, 8-р зүйлээс үзнэ үү)

БНХСН-ийн эрх зүй

Мэдэгтэж, дампуурын хэрэг үүсэх хүсэлт гаргасан.

2. Харьцангуй үүсгэж биелүүлж чадахгүй болсныг өөрөө дампуурын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл гаргасан.

1. Үүрийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харьцангуй тал иргэний хэрэг үүсгэнэ гэж заажээ.

Дампуурын тухай хуульд: шүүх дараах хоёр үндэслэлээр

ой гэдэгт асуудлын гол нь байдаг.

Шинж юм. Харин авлага, өргөл нь баталгатай бөгөөд найдвартай авах авцаа байна дагалдмал байдаг нь бизнесийн орныг чухал боломжгүй юм. Ер нь бизнес эрхлэгчид бусдад өгөх өргөл бусдаас өөрөө үйлдвэрлэж, борлуулна гэж өөрөөс байдаггүй, байх ч

Төхөрөмж, түүхий эд материал аа өөрөө бэлтгэж, бүтээгдэхүүнээ ахуйн харьцанад оролцохгүйгээр үйлдвэрлэлийн тоног

Аливаа аж ахуйн нэгж бусад байгууллага, иргэдтэй аж

Банкны эзэлийг төлөх боломж найдваргүй гэсэн ойлголт юм.

байна. "Биелүүлэхгүй" гэдэг үгийн чаад улга нь бусдын өр шир, биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүй тооцно гэж заасан

Тэгнэх хэмжээний үүрэг хууль буюу гэрээнд заасан хугацаанд хуулийн 4-р зүйлд: өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай

нь төлбөрийн чадваргүй болох явдал юм. Дампуурын тухай нь ажуйн нэгжийг дампуурсанд тооцох эрх зүйн үндэслэл

28. Дампуурын хэрэг үүсэх үндэслэл, журам

Дампуурах нь нийгэм цэвэршиж байна гэж үздэг байна.

Шт ажиглаж чадахгүй бол байснаас байгагүй нь ч дээр гэдэг үүрэг хүлээж чадваргүй, өөрөөр хэлбэл жинхэнэ аж ахуйн нэгж

Үйлдвэрлэж хэрэглээг хохиргоотой, бусдын өмнө эрх эдэлж, хэмээн үзэх явдал байдаг. Тэнд чанаргүй бүтээгдэхүүн

нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлэхийн зэрэгтээ бас өөрөг талтай зах зээл хөгжсөн оронд аж ахуйн нэгжийн дампуурал нь холбоотой байсан бусад байгууллага, иргэн хохирдог байна

Тодорхой хэмжээний зардал гаргах, дампуурсан аж ахуйн нэгжтэй

ажилгүйгээр нэмэгтэж тэдний амьдралыг харж үзэхэд төрөөс дампуурснаас үүсэх сөрөг үр дагавар нь юуны өмнө

хэмжээ авдаг. Дампуурсан бол түүний эцэст гарсан үр дагаврыг ариглах арга

БНХСН-ийн эрх зүй

нийт нэхэмжлэлийн саналын эрхийн 66,7-оос дээш хувиар баталсан бол хүчин төгөлдөр байна.

3§. Хэрэг гүйцэтгэгч, түүний эрх, үүрэг

Хэрэг гүйцэтгэгчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэгчтэй адил хэмээн үзэх явдал практикт тохиолддог. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч бол шүүхийн хүчин төгөлдөр тогтоол, шийдвэрийг төрийн нэрийн өмнөөс биелүүдэг төрийн төлөөлөгч юм. Хэрэг гүйцэтгэгч бол дампуурлын хэргийн нэхэмжлэгч, хариуцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор шүүхээс томилсон эрх бүхий этгээд байна.

Дампуурлын хуульд зааснаар хэрэг гүйцэтгэгч нь хариуцагчийн үйл ажиллагаанд санхүү, эдийн засгийн сонирхолгүй, хууль, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой хувь хүн, эсхүл хууль зүй, эдийн засаг, санхүүгийн чиглэлээр мэргэжлийн зөвөлгөө, үйлчилгээ өгөх эрх бүхий хуулийн этгээд байна. Харин хариуцагч, нэхэмжлэгчийн удирдлагад, ажилладаг түүний гишүүн, хувьцаат компаниас бусад хариуцагч хуулийн этгээдийн гишүүн, нэхэмжлэгч хувь хүн хэрэг гүйцэтгэгч байхыг хориглоно.

Эд хөрөнгийн талаар хэрэг гүйцэтгэгчийн эрх, үүрэг нь хариуцагчийн эд хөрөнгө, түүнтэй холбогдох баримт бичгийг хамгаалалтанд авч, эд хөрөнгийн тоо, чанар, хэрэгцээ болон элэгдэл хорогдлыг харгалзан тоолж данслах, үнэлэх эрхтэй. Шүүхийн шийдвэрээр хариуцагчийн эд хөрөнгийг битүүмжлэхээр тогтоосон бол тухайн нэр бүхий эд хөрөнгийг битүүмжилж хамгаалалтын асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй байна.

Хэрэг гүйцэтгэгч хариуцагчийн эд хөрөнгийг захиран зарцуулах эрх эдэлж болно. Чухам ямар тохиолдолд энэ эрхийг эдлэх вэ гэвэл Дампуурлын тухай хуулийн 14-р зүйлд. Хэрэв хариуцагч энэ хуулиар тогтоосон хугацаанд дахин хөрөнгөжүүлэх хүсэлтээ гаргаагүй, төлөвлөгөөг шүүхэд өгөөгүй буюу уг төлөвлөгөөг шүүх батлаагүй, эсхүл хариуцагчийг татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан бол хариуцагчийн эд хөрөнгө захиран зарцуулах, аж ахуйн үйл ажиллагааг удирдах эрхийг шүүхийн шийдвэрээр хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ гэж заасан байна. Захиран зарцуулах хэлбэр нь хариуцагчийн эд хөрөнгийг

худалдах, ингэж худалдахдаа хамгийн өндөр үнэд хүргэх аргаар худалдахын зэрэгцээ хариуцагчийн саналыг харгалзан үзэх учиртай.

Хариуцагчийн хийсэн хүчин төгөлдөр бус гэрээ, хэлцлийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандах эрхтэй. Хүчин төгөлдөр бус хэлцэл гэдэгт одоогийн дагаж мөрдөж байгаа Иргэний хуулийн 43 дугаар зүйлд заасан хэлцэл хамаарахын сацуу Дампуурлын тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд зориуд нэр заасан гэрээ хэлцэл орно. Харин хариуцагчийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн нөхцлийг хангахад чиглэсэн гэрээ, хэлцлийг төлбөрийн чадваргүй болсон үндэслэлээр цуцлах буюу өөрчлөхийг хориглодог.

Зохион байгуулалтын талаар хэрэг гүйцэтгэгчийн эрх, үүрэг нь шаардлагатай гэж үзвэл нэхэмжлэгчдийн зөвлөлийн хурлыг зарлах, хариуцагчийн нэрийн өмнөөс, түүний эрх ашгийн тулд нэхэмжлэгчдийн хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд бусадтай гэрээ хэлцэл байгуулах, тогтоосон цалин хөлсний хэмжээнд багтаан өөрт туслагчийг хөлсөөр ажиллуулах тусгай данс нээж хариуцагчийн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх зэрэг эрхтэй байна.

Хэрэг гүйцэтгэгч шударга ажиллах үүрэгтэй. Хэрэв хариуцлаггүй буюу нэхэмжлэгчид тал тохой татах буюу шунахай зорилгоор хариуцагчид хохирол учруулбал уг хохирлыг биечлэн хариуцах ёстой.

4. § Дахин хөрөнгөжүүлэлт

Дампуурлын тухай хуулийн 23 дугаар зүйлд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлж, үйл ажиллагааг нь цаашид үргэлжлүүлэх нь татан буулгаснаас нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой гэж үзвэл дараах этгээд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг түүнийг төлбөрийн чадваргүйд тооцсон өдрөөс хойш 60 хоногийн дотор шүүхэд гаргаж болно гэж заасан байна.

Хэн шүүхэд хүсэлт гаргах вэ гэвэл:

1. Хариуцагч өөрөө.

2. Хариуцагчаас нэхэмжилсэн нийт төлбөрийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг нэхэмжилж байгаа нэхэмжлэгч.
3. Хэрэг гүйцэтгэгч гэсэн гурван субъект байна.

Дахин хөрөнгөжүүлэхэд юуны өмнө хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байх шаардлагатай бөгөөд тэр нь дампуурлын хэрэг үүсгэх үед хариуцагчийн өмчлөлд байсан буюу хөрөнгөжүүлэх төлөвлөгөө батлах хүртэл шинээр бий болсон өмчлөлийн зүйлс, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад орсон орлого нь хөрөнгийн эх үүсвэр байна. Түүнээс гадна зээл, тусламж хандив эх үүсвэр байж болно. Өөрөөр хэлбэл хариуцагчийн үйл ажиллагааг дэмжсэн гадны байгууллага, иргэдийн хандив байна.

Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө бол хариуцагчийн эрхэлж байсан үйлдвэрлэл, үйлчилгээг тэр чиглэлээр, эсхүл өөр төрөл хэлбэрээр үргэлжлүүлэн явуулж, бусдын өр ширийг төлөөд цаашид бие даан ажиллаж улмаар төлбөрийн чадвартай болгоход чиглэсэн эдийн засаг эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичиг юм.

Төлөвлөгөө бол эд хөрөнгө, эрх зүй, зохион байгуулалтын үйл ажиллагааны чиглэлийг багтаасан олон үзүүлэлтүүдийн системээс бүрдсэн байна. Тухайлбал хариуцагчийн үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн зохион байгуулалтыг өөрчлөх, хариуцагч үнэт цаас гаргах эсэх, хэрэв гаргах бол үнэт цаасны төлбөрийн хугацаа, үнэ, эд хөрөнгийг худалдах журам, болон хуульд заасан үндэслэлийг төлөвлөгөөнд тусгана.

Хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн хурлаар хэлэлцэх бөгөөд хурлын бэлтгэл ажиллагааг хэрэг гүйцэтгэгч шууд хариуцаж хийх үүрэгтэй. Хэрэг гүйцэтгэгч төлөвлөгөөг хэлэлцэх тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр нийтэд мэдээлж, хурал хийх өдөр, төлөвлөгөөтэй хэрхэн танилцаж болох зэрэг асуудлыг мэдээлнэ.

Нэхэмжлэгчдийн хуралд төлөвлөгөөг санал болгосон иргэн, хуулийн этгээд заавал оролцох бөгөөд саналыг хэсэг тус бүрээр, тухайлбал нэхэмжилсэн үнийн дүнгийн 10 буюу түүнээс

дээш хувийг эзлэх барьцаат нэхэмжлэгчид, бусад барьцаат нэхэмжлэгчид, хариуцагчтай хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчид гэсэн гурван хэсгээр санал авна. Хэсэг тус бүрд оролцсон нэхэмжлэгчдийн олонхийн санал авснаар төлөвлөгөөг зөвшөөрсөн гэж үздэг.

Нэхэмжлэгчдийн хурлаас зөвшөөрсөн төлөвлөгөөг шүүх баталж эрх зүйн хэлбэрт оруулдаг. Баталсан төлөвлөгөөг хариуцагч өөрөө санал болгож биечлэн хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан бол хэрэг гүйцэтгэгчийн хяналтын дор гүйцэтгэдэг байна. Хэрэв ингэж хүсэлт гаргаагүй бол хэрэг гүйцэтгэгч төлөвлөгөөг гардан хариуцаж хэрэгжүүлнэ. Хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх явц болон эцэст нь эерэг ба сөрөг хоёр үр дагаврын аль нэг нь бий болох нь мэдээж. Төлөвлөгөөг үр ашигтай хэрэгжүүлбэл бусдын өр авлагыг төлөөд цаашид бие даан ажиллах хөрөнгийн чадвартай болох, хэрэв тэгэж ажиллаж чадахгүй бол дампуурахаас өөр аргагүй гэсэн ойлголт юм.

Хариуцагчийг татан буулгах ба хөрөнгө хуваах. Аж ахуйн нэгжийн дампуурал бол түүнийг татан буулгах үйл ажиллагааг зогсоож буй хууль цаазын факт юм. Шүүх дараах тохиолдолд хариуцагчийг дампуурсанд тооцож шийдвэр гаргана.

1. Дампуурлын хэрэг үүсгэх үед дахин хөрөнгөжүүлэх санал, хүсэлт гаргаагүй,
2. Дахин хөрөнгөжүүлэх санал, хүсэлт гаргасан боловч хуульд заасан хугацаанд төлөвлөгөөг өгөөгүй.
3. Хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг биелүүлээгүй, биелүүлэх боломж найдваргүй болсон бол шүүх дампуурсан тухай шийдвэр гаргана.

Шүүхийн шийдвэр гарсны дараа хариуцагчийн эд хөрөнгийг битүүмжилж тооллого явуулах бөгөөд тоолоход хариуцагч, буюу төлөөлөгчийг заавал байлцуулах, хэрэв тэд байлцахаас санаатайгаар зайлсхийсэн бол шүүхээс томилсон тооллогын комиссийг оролцуулдаг. Хэрэг гүйцэтгэгч эд хөрөнгийг тоолж дууссаны дараа баримт бичигт хариуцагч, буюу түүний төлөөлөгчдөөр гарын үсэг зуруулна. Хэрэв гүйцэтгэгч тооллогыг зохих журмын дагуу явуулаагүй, эд хөрөнгийн чанар, элэгдэл,

хорогдол, үнэлгээг буруу хийсэн гэж хариуцагч үзвэл шүүхэд тэр даруй гомдол гаргах эрхтэй байна.

Хэрэг гүйцэтгэгч хариуцагчийн эд хөрөнгийг бирж болон дуудлагын худалдаанд оруулж мөнгөн хэлбэртэй болгоно. Эд хөрөнгийг худалдахдаа хамгийн өндөр үнэд хүргэх аргаар худалдахын сацуу хариуцагчийн саналыг харгалзах үүрэгтэй.

Хэрэг гүйцэтгэгч хариуцагчийн мөнгөн хөрөнгийг төлөвлөгөөний дагуу нэхэмжлэлийн шаардлагыг Дампуурлын хуулийн 35-р зүйлд заасан дарааллаар хуваарилана. Үүнд:

1. Бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулахаар гаргуулах төлбөр,
2. Хэрэг гүйцэтгэгчийн цалин хөлс, хэрэг гүйцэтгэгчийн эрх үүргийнхээ хүрээнд буюу шүүх, нэхэмжлэгчдийн хурлын зөвшөөрөлтэйгөөр явуулсан үйл ажиллагааны зардал,
3. Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу нэхэмжлэл,
4. Барьцаат нэхэмжлэл,
5. Энгийн нэхэмжлэл,
6. Хариуцагчтай хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын хөдөлмөрийн цалин, хөлс,
7. Шүүхийн зардал.
8. Бусад

Дампуурлын хуульд хариуцагчийн бүх эд хөрөнгийг борлуулсан орлого нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж хүрэхгүй тохиолдолд тухайн хэсгийн нэхэмжлэлийг бүрэн барагдуулж дууссаны дараа дараагийн хэсгийн нэхэмжлэлийн шаардлагыг хангана. Нэг дараалалд орсон хэд хэдэн шаардлагыг нэгэн зэрэг хангаж хүрэхгүй тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагад хувь тэнцүүлэн ногдуулна гэж заасан байна. Татан буулгах ажиллагаа дуусгавар болсноор хариуцагч нэхэмжлэлийг хангагдаагүй үүргээс чөлөөлөгдөж, түүний нэхэмжлэгчдийн өмнө хүлээсэн үүрэг дуусгавар болно.

ҮНЭТ ЦААСНЫ ЭРХ ЗҮЙ

1§ Үнэт цаасны ойлголт

Бизнесийн эрх зүйн харилцаанд оролцогч субъектуудын өмчлөлд эд юмс байхаас гадна хуулиар зөвшөөрөгдсөн бол эд хөрөнгийн эрх байж болно. Эд хөрөнгийн эрхийг зарим тохиолдолд тусгай баримтаар илэрхийлэх бөгөөд үүнийг эх газрын эрх зүйд цаас, Англи Америкийн эрх зүйн системтэй оронд гүйлгээний баримт бичиг гэдэг.

Эдийн засгийн утгаараа үнэт цаас нь үнэт цаасны зах зээл дээр арилжаалах зориулалттай онцгой төрлийн товар буюу санхүүгийн бараа юм. Харин хууль зүйн талаас нь авч үзвэл иргэний болон бизнесийн эрх зүйн харилцаанд оролцогчдын эд хөрөнгийн эрхийг илэрхийлж баталгаажуулж буй баримт мөн.

Монгол улсын Иргэний хуулийн 78 дугаар зүйлийн нэгд: "Тодорхой хэмжээний мөнгийг эргүүлж төлөхийг шаардах, хувьцаат компанд хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн ногдол ашиг авах, түүнийг захиран зарцуулах болон хуульд заасан эд хөрөнгийн бусад эрхийг гэрчилж байгаа баримтыг үнэт цаас гэнэ" хэмээн тодорхойлсон бол "Үнэт цаасны тухай хуульд" хувьцаат компанд хөрөнгө оруулж, ногдол ашиг авах болон саналын эрхтэйг гэрчилсэн хувьцаа, эрх бүхий байгууллагаас гаргасан нэгээс дээш жилийн хугацаатай зээллэгээ засгийн газрын өрийн бичиг түүнчлэн үнэт цаасны хорооноос энэ хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг нэр томъёоны хувьд үнэт цаас гэнэ" гэж тайлбарласан байна.

Үнэт цаасыг бичиг баримт юм байна гэж ойлгож болохгүй. Учир нь хуулинд зааснаар үнэт цаас нь биет ба биет бус хэлбэртэй байхаар заажээ.

1. Тогтоосон журмын дагуу хэвлэсэн үнэт цаасыг биет.
2. Тусгайлан хэвлээгүй бүрдүүлбэр нь тусгай бүртгэл (ердийн ба тооцоолох машины)-д байгаа үнэт цаасыг биет бус үнэт цаас гэдэг. Бизнесийн харилцаа болон иргэний гүйлгээнд

сугалаа, гэрээслэл, төлбөрийн баримт, лиценз, зөвшөөрөл зэрэг үнэт цаастай төстэй янз бүрийн баримт хэрэглэгддэг. Эдгээрээс үнэт цаас нь ялгагдах нийтлэг шинжтэй байдаг.

1. Ийм шинжид юуны өмнө үнэт цаасны бүрдүүлбэр орно. Үнэт цаас нь түүний нэр, төрөл, үнэт цаас гаргагчийн нэр, түүний нэрлэсэн үнэ, үнэт цаасаар хуримтлуулсан мөнгийг зарцуулах зориулалт, олох ашиг, хүү авах нөхцөл, төлбөр хийх болзол зэрэг бусад нөхцлийг агуулсан байна. Үнэт цаасны бүрдүүлбэр нь түүнийг гаргагчийн санаанаасаа зохиож бичих зүйл биш, харин аль нэг зүйл нь байхгүй тохиолдолд тухайн үнэт цаасыг хүчингүйд тооцох хуулиар тавигдсан шаардлага юм.

2. Үнэт цаасыг хууль ёсоор эзэмшигчийн үнэт цаасаар эдлэх эрхийн хүрээ, хязгаар нь тодорхой байх ёстой. Энэ нь тодорхой мөнгөн төлбөр, ногдол ашгийн хувь хэмжээ зэргийг тодорхой зааж өгсөн байхаар илэрнэ.

3. Үнэт цаас эзэмшигч нь түүгээр гэрчлэгдсэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд үнэт цаасыг өөрийн нэр дээр хадгалах, хараа хяналтандаа байлгах ёстой. Тухайн үнэт цаас нь эзэмшигчид бодитой байхгүй (биет бус бол түүний нэр дээр бичигдээгүй бол эрхээ хэрэгжүүлэх боломжгүй). Харин үнэт цаас нь хууль бусаар бусдын эзэмшилд орсон тохиолдолд өмчлөх эрхийн хамгаалах аргаар (виндикаци, негатор нэхэмжлэл) эрхээ хамгаалуулахаас гадна, түүнийг алдсан, гээсэн зарим тохиолдолд эрхээ сэргээлгэх боломжтой байдгаараа онцлогтой.

4. Үнэт цаасыг бусад этгээдэд шилжүүлж, худалдаж, арилжиж болно. Ингэж нэг этгээдээс нөгөөд үнэт цаасыг шилжүүлэх нь түүний төрлөөс шалтгаалан хууль зүйн янз бүрийн зохицуулалттай байдаг.

Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлэх субъектын байдлаар нь үнэт цаасыг **мэдүүлгийн, зөвшөөрлийн, нэрийн** гэж гурав ангилдаг. Мэдүүлгийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг уг үнэт цаасыг хууль ёсоор олж авсан этгээд, нэрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг гагцхүү түүнд нэр заагдсан этгээд, зөвшөөрлийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг уг үнэт цаасыг өмчлөгч буюу түүнээс уг эрхийг шилжүүлж авахаар өөрийн нэр

дээр холбогдох бичилт хийлгэсэн этгээд үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдэлнэ.

Үнэт цаасыг субъектын хувьд Засгийн газар, түүнчлэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрснөөр аймаг, нийслэлийн Засаг дарга, Монгол улсын хуулийн этгээд болох компани гаргадаг бол үнэт зах зээлд андеррайтер, брокер, диллер, хөрөнгийн бирж, түүнчлэн үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, хөрөнгө оруулалтын сан оролцох эрхтэй. Харин брокерийн пүүс нь анх төрийн өмчид тулгуурлан хөрөнгийн биржийн харьяа байгуулагдсан бөгөөд үнэт цаасны хоёрдох зах зээл эхэлсэн үеэс үнэт цаасны компани болж хувьчлагдсан. Үнэт цаасны компани нь Компаний тухай хуулийн хүрээнд **зохион** байгуулагдаж (ихэнх нь ХХК-ийн хэлбэртэй байдаг) үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд юм.


2 §. Үнэт цаасны төрөл

Хувьцаа. Хувьцааг мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэн ашиглах зорилгоор гаргадаг бөгөөд ийнхүү төвлөрүүлсний эдийн засгийн ач холбогдол асар их юм. К.Маркс "Капитал" зохиолдоо Хэрэв төмөр зам тавих ажлыг хэн нэгэнд хөрөнгө хуримтлагдтал хүлээсэн бол манай дэлхийд одоо болтол төмөр зам байхгүй байхсан. Гагцхүү төвлөрсөн хувьцаат нийгэмлэг (Хувьцаат компани) энэ асуудлыг даруй шийдвэрлэсэн.

Тийм учраас хувьцаат нийгэмлэг том ажил бүтээх зорилго бүхий хөрөнгө төвлөрүүлсэн байгуулага" гэж тэмдэглэсэн байдаг.

Урьд өмнө үнэт цаасыг улсын болон хувийн облигаци, вексель, чек төлөөлж байсан бол өнөө үед хувьцаа гол цаас болжээ. Үнэт цаасны тухай хуульд заасны дагуу хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхийг эдэлнэ.

Хувьцаа нь бие даасан үнэт цаас болохын хувьд хэд хэдэн онцлог шинжтэй байдаг.



1. Хувьцаа нь түүнийг өмчлөгчийн эрхийг илэрхийлдэг баримт. Энэ эрх нь ашиг олох, эрх олгох байдлаар илэрнэ.

2. Хувьцаа нь бусад үнэт цаастай харьцуулбал хугацаагүй үнэт цаас байдаг. Хувьцааны эрх нь компанийг татан буулгах болон хуульд заасан бусад нөхцөл байдал хүртэл үргэлжилнэ.

3. Хувьцаа нь хязгаарлагдмал хариуцлагыг өөртөө агуулна. Компани татан буугдахад хувь нийлүүлэгч нь эзэмшиж байгаа хувьцаагаараа л хариуцлага хүлээдэг. Хувьцаа эзэмшигч нь өөр ямар нэг хариуцлага хүлээхгүй зөвхөн хувьцаагаа алдана гэсэн үг.

Хувьцааг янз бүрийн шалгуураар хэд ч ангилж болох боловч эрхийн хэмжээнээс хамаарч энгийн болон давуу эрхийн хувьцаа гэж ангилдаг нь хууль зүйн хоёр ондоо үр дагавар, өөр зохицуулалтыг үүсгэдэг. Хувьцааг ингэж ангилах нь Нөхөрлөл, Компаний тухай хуулинд урьд нь байсан, бөгөөд шинээр батлагдсан компаний тухай хуулинд зохицуулалт нь улам нарийсч хуульчлагдсан. Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээдэг, харин давуу эрхийн хувьцааг гаргах үүрэг хүлээхгүй.

Монгол улсад улсын үйлдвэрийн газрыг хувьчилж хувьцаат компани болгосноор дан энгийн хувьцаа гаргасан бол давуу эрхийн хувьцааг одоогоор нэг ч компани гаргаагүй байна. Энгийн хувьцаа эзэмшигч нь хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх, давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлөгдсөний дараагаар тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах, хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ. Харин давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь эрх бүхий байгууллагаас тогтоосон давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг тэргүүн ээлжинд авах, компаний татан буулгах үед эзэмшиж байгаа хувьцаандаа тохирсон эд хөрөнгө авах эрх эдэлдэг. Давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь хувь нийлүүлэгчийн хуралд заавал оролцох эрх эдэлдэггүй. Харин түүний эрх ашгийг хамгаалах зорилгоор хууль, компанийн дүрэм болон тухай төрлийн давуу эрхийн хувьцаа гаргах шийдвэрт заасан асуудлаар хувь нийлүүлэх хуралд саналын эрхтэй оролцож болохоор

хуульчилсан нь компаний эрх зүйн зохицуулалтад орсон нэг өвөрмөц өөрчлөлт юм. Хэрэв хуульд заасан бол дараах тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмшигчид нь хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцоно.

1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон дүрмийн шинэчилсэн найруулгыг батлахдаа тэдгээрийн эрхийг хязгаарласан заалтыг оруулж байвал

2. Компанийг өөрчлөн байгуулах явцад давуу эрхийн хувьцааг энгийн, бусад төрлийн үнэт цаас болон бусад хөврүүлж байвал.

Харин хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох хуралд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийг дараах нөхцөлд саналын эрхтэй оролцуулахаар компани дүрэмд зааж болно.

1. Компанийн дүрэмд энгийн хувьцаанд хөрвөх давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн төлөөлөгчдийг оруулж болохоор заасан.

2. Давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй. Компанийн тухай хуулиар зохицуулагдаж буй хувьцаанд хамаарах өөр нэг асуудал бол ногдол ашиг хуваарилах зохицуулалт юм. Ногдол ашгийг компани зөвхөн ашигтай ажиллаж байгаа тохиолдолд л хуваарилна. Иймд ногдол ашиг хуваарилах хэмжээ, хугацааг хуулиар тогтоож өгөх боломжгүй. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал) гаргана. Энэ байгууллага нь ногдол ашиг хуваарилахдаа хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож энэ талаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ.

Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбээр төлж болно. Энгийн хувьцаа эзэмшигч болон давуу эрхийн хувьцаа

эзэмшигчдэд ямар тохиолдолд ногдол ашиг хувиарлах нөхцөл журмыг хуульчилсан. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх, эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх. Мөн ногдол ашиг төлсний дараа компаний өөрийн хөрөнгийн хэмжээ нь компанийг анх үүсгэн байгуулсан үеийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилдаг. Харин давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахад ногдол ашиг төлсөний дараа компани нь төлбөрийн чадвартай байхаас гадна компани нь эргүүлэн авах үүрэгтэй давуу эрхийн хувьцааг бүрэн авсан байх шаардлага тавигддаг.

Компанийн тухай хуулийн зүйл зорилтын нэг бол хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолыг хамгаалах явдал юм. Үүний тулд хувь нийлүүлэгчдийн шаардлагаар компани хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл журмыг хуульчилсан. Хуулинд заасан тодорхой асуудлаар (компанийн тухай хууль 54 дүгээр) хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан буюу санал хураалтанд оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй байна. Мөн үүнээс гадна Компани нь хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар эргүүлэн авах хувьцааг зах зээлийн үнээр худалдан авах үүрэгтэй. Компанийн хувьцаа буюу бусад үнэт цаасны үнийг оролцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнэ гэж эдгээр эд хөрөнгийн үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, түүнийг худалдах үүрэг хүлээгээгүй худалдагч болон эд хөрөнгийг үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, худалдан авах үүрэг хүлээгээгүй худалдан авагч хоёрын хоорондын харилцан тохиролцсон үнийг хэлнэ. Хувьцааг эргүүлэн авахыг шаардсан тохиолдолд хувьцааны зах зээлийн үнийг хөндлөнгийн үнэ тогтоогч буюу аудитороор тогтоолгох үүрэгтэй, бусад тохиолдолд эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно. Нийтэд худалдагдаж байгаа хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо Хөрөнгийн биржийн албан ёсны мэдээнд тусгагдсан арилжааны сүүлийн зургаан сарын дундаж ханшийг харгалзан тогтоодог.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх байгууллагын удирдлага, компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдээс жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлагатай юм. Энэ зорилгоор манайд урьд өмнө байгаагүй хэд хэдэн шинэ зохицуулалтыг Компанийн тухай хуульд шинээр оруулсны нэг нь хяналтын багц хувьцааг худалдан авах журам, хяналтын багц хувьцааг эзэмшиж буй этгээдийн эрх, үүргийг хуульчилсан явдал юм.

Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг компанийн хяналтын багц гэх бөгөөд хувьцаат компанийн энгийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авах хүсэлтэй этгээд нь Компанийн тухай хууль буюу үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу энэ тухайгаа нийтэд мэдээлэх замаар худалдан авах тухай санал гаргадаг. Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөс хойш ажлын жар хоногийн дотор багтаан бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн зургаан сарын зах зээлийн үнийн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй. Компанийн хяналтын багцыг худалдан авсан этгээд нь дээрхи саналыг гаргаагүй бол уг этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрх эдэлдэггүй.

Алтан хувьцаа. Төр өөрийн болон нийгмийн ашиг сонирхолын үүднээс, тодорхой бодлого хэрэгжүүлэхийн тулд алтан хувьцаа гаргадаг. Засгийн газар төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмч давамгайлсан компаний төрд ногдох хэсгийг бүхэлд нь хувьчлах тухай шийдвэр гаргахдаа тодорхой хугацаанд компанийн тухай хуулинд заасан асуудлаар компанийн хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын шийдвэрт хориг тавих эрхтэй, ногдол ашиг авдаггүй, өөр ямар нэг эрхгүй алтан хувьцааг гаргах эрхтэй. Хориг тавих тухай шийдвэрийг Засгийн газар гаргах бөгөөд энэ шийдвэрт хориг тавих үндэслэлээ тодорхой заах ёстой. Алтан хувьцааг тодорхой хугацаатай гаргах бөгөөд хугацаа дуусмагц

хувьцаа нь хүчингүй болдог. Хугацааг дахин сунгах, бусдад шилжүүлэхийг хуулиар хориглодог.

Алтан хувьцаатай компанийн эрх барих байгууллага болон удирдлагаас дор дурдсан асуудлаар гаргасан шийдвэр нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрх ашигт харшилсан тохиолдолд хориг тавина.

1. Хувьчлахаас өмнө эрхэлж байсан үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх
2. Компанийг өөрчлөн байгуулах татан буулгах
3. Их хэмжээний хэлцэл байгуулах
4. Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифийг тогтоох өөрчлөх.

Алтан хувьцааг өмч хувьчлалд хэрэглэх бөгөөд хувьчлагдаж буй үйлдвэр, төрийн өмч давамгайлсан компани нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрх ашигт, эдийн засаг болон нийгмийн бусад харилцаанд нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулдаг том хэмжээний үйлдвэр, компанийг ойлгох юм.

Өрийн бичиг. Өрийн бичиг гэдэг нь түүнийг гаргасан этгээд болон түүнийг эзэмшигч хоёрын хооронд тодорхой хугацаагаар зээлийн харилцаа үүсгэдэг үнэт цаас мөн. Хувьцаа өрийн бичиг хоёр нь хоорондоо зарчмын ялгаатай.

1. Өрийн бичиг худалдаж авсан этгээд нь зээлдүүлэгч болдог бол хувьцааг худалдан авсан этгээд нь түүний өмчлөгч болдог.

2. Мөн өрийн бичгийг тодорхой хугацаатай гаргадаг бол хувьцааг эзэмшигчийн эрхэд хугацаа хамаарахгүй.

3. Өрийн бичиг хүү төлөгддөг бол хувьцаанд ногдол ашиг хуваарилагдана.

Өрийн бичгийг Засгийн газар, Аймаг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчидийн хурлын зөвшөөрлөөр Засаг дарга, хуулийн этгээдийн эрхтэй компани гаргах эрхтэй. Компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан эсхүл өөр компаниас тусгайлан гаргасан баталгаатайгаар тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн авах нөхцөлтэйгээр өрийн бичиг гаргах эрхтэй. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол өрийн

бичиг гаргах шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл гаргадаг. Энэ шийдвэртээ өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, төлөх хугацаа, эргүүлж авах үнэ, бусад мэдээллийг заасан байна. Хуульд зааснаар компани нь нэг удаа бүрэн төлөгдөх эсхүл хэсэгчлэн төлөгдөх өрийн бичиг гаргахаас гадна гаргасан өрийн бичгээ төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн авч болдог.

Хувьцаат Компаниас "Булигар"ХК 1,5 тэрбум төгрөгийн облигац гаргаж Монгол банкинд худалдсаныг эс тооцвол одоогоор Хөрөнгийн биржид өөр Компаниас өрийн бичиг гаргаж худалдаагүй байна. Засгийн газар бонд¹ гаргах замаар төсвийн орлогыг нэмэгдүүлж болно. Засгийн эрхэнд байгаа улс төрийн хүчин татварыг нэмэгдүүлэх сонирхол бага байдаг учир улсын төсвийг санхүүжүүлэх өөр эх үүсвэрийг Засгийн газар хайх хэрэгтэй болдог. Ийм нэг эх үүсвэр нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэгдээгүй байгаа бэлэн мөнгийг бонд гаргаж зээлдэх замаар мөнгөн хөрөнгийг төвлөрүүлдэг. Улсын Их хурлаас тогтоосон хэмжээнд багтаан Засгийн газраас гаргах, хүү (эсхүл хямдруулалттай)-тэй тодорхой хугацааны дараа эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр арилжаалагдах үнэт цаасыг бонд гэдэг. Бонд гаргагч нь Сангийн яам, бондыг үндсэн зуучлагч нь Монгол банк байна. Төлөгдөх хугацаа нь болсон бондын үндсэн үнэ ба хүүгийн төлбөрийг Сангийн яам хариуцах бөгөөд төлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Бонд нь биет ба биет бус хэлбэртэй байж болох бөгөөд Төрөл, арилжааны дугаар

1. Сери, дугаар
2. Нэрлэсэн үнэ
3. Буцаж төлөгдөх хугацаа
4. Хүү (эсхүл хямдруулалт) гэсэн бүрдүүлбэртэй байна.

Монгол банк нь бондыг зуучлан борлуулах эрх авсан арилжааны банк (брокер)-аар дамжуулан Монгол улсын иргэд, арилжааны банк, төсөвт байгууллагаас бусад аж ахуйн нэгж байгууллага, гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад

¹ Бонд облигац хоёр нь эдийн засгийн утгаараа адил ойлголт юм. Харин Нөхөрлөл Компаны облигац одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Компанийн тухай хуулинд өрийн бичиг гэж гаргах эрхтэй гэж заасан бол харин Засгийн газраас гаргах өрийн бичиг нь хууль тогтоомжинд гол төлөв бонд гэж нэрлэсэн байдаг.

худалдаж борлуулдаг. Бондын хүү, баталгаа зэрэг бусад нөхцөл нь арилжааны банкуудын мөнгөн хадгаламжийн нөхцөлтэй харьцуулбал илүү хөнгөлөлттэй, ашигтай, баталгаатай байх ёстой. Ийм тохилдолд л бусад субъект нь бондыг худалдан авах сонирхолтой болно. Төлөх хугацаанаас нь хамааруулж бондыг

1. Богино хугацаатай (30, 90, 180 хоногийн)
2. Дунд хугацаатай (1-5)
3. Урт хугацаатай 5-аас дээш жил гэж ангилах бөгөөд өнөөг хүртэл

Засгийн газар богино хугацаатай бонд арилжаалж ирсэн. Бондын хүү болон төлбөрийг тооцох журмаар нь хямдруулсан болон энгийн бонд гэж хоёр ангилдаг.

1. Нэрлэсэн үнээс зохих хэмжээний хямдралтайгаар борлогдох ба тодорхой хугацааны дараа нэрлэгдсэн үнээрээ буцаж төлөгдөх Засгийн газрын үнэт цаасыг хямдруулсан бонд гэдэг. Хямдруулсан бондыг зохих тушаал шийдвэрт өөрөөр заагаагүй бол үнэ хаялцуулах ажиллагаагаар борлуулдаг. Үнэ хаялцуулах ажиллагаагаар борлуулдаг. Үнэ хаялцуулах ажиллагаа нь иргэний хууль болон түүнд нийцүүлж гаргасан журмын хүрээнд явагддаг. Хямдруулсан бондын дэвсгэрт нь таван мянга, арван мянга, зуун мянга, сая, зуун сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй байна. Энэ үнээр нь Засгийн газар бонд эзэмшигчдээс бондыг худалдан авах ёстой.

2. Нэрлэсэн үнээр борлогдох ба тогтмол хүүтэй, тодорхой хугацааны дараа нэрлэсэн үнэ нь хүүгийн хамт буцааж төлөгдөх үнэт цаасыг энгийн бонд гэдэг. Энгийн бондын дэвсгэрт нь таван мянга, арван мянга, зуун мянга, сая төгрөгийн үнэтэй байдаг. Энгийн бондын гэрчилгээ нь тодорхой нэрлэсэн үнэгүй байх бөгөөд тухайн үйлчлүүлэгчийн бонд худалдан авахаар хийсэн төлбөрийг үндэслэн төлбөрийн дүнг тэмдэглэлийг гэрчилгээнд хийдэг. Энэхүү төлбөрийн тэмдэглэл нь тухайн гэрчилгээний нэрлэсэн үнэ болно.

Арваннэгдүгээр бүлэг

БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

Бизнесийн эрх зүй нь аж ахуй эрхлэгчдэд эд хөрөнгө олж авах, түүнийг өмчлөх, захиран зарцуулах нөхцөл боломжийг тодорхойлж тогтоох төдийгүй тэднийг эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус зөрчлөөс урьдчилан сэргийлэх гарсан зөрчлийг арилгаж бизнесмений эрхийг хамгаалах үүрэгтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлд Монгол улсын иргэн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй гэж зааснаас гадна Монгол Улсын Иргэнийн хуулийн 74 дүгээр зүйлд төр өмчийн бүх төрөл, хэлбэр чөлөөтэй хөгжих нөхцлийг бүрдүүлж, тэдгээрийн байдлыг хуулиар хамгаална гэж заасан юм. Энэ нь бизнесменийн эрхийг хамгаалах үндсэн зарчим, чиглэлийг хуулиар баталгаажуулсан хэрэг болно.

Бизнесменүүд зөрчигдсөн эрхээ хамгаалуулах эрхтэй, төр түүнийг хамгаалах үүрэгтэй байдаг. Бизнесменүүдийн эрх ямар хэлбэрээр зөрчигдөж болох буюу зөрчигдсөн, түүнийг хэн ямар аргаар яаж зохицуулж хамгаалах талаар манай хууль тогтоомжид тодорхой заасан байна.

1. Бизнесменүүд эрхээ өөрөө хамгаална. Энэ бол харьцангуй өргөн ойлголт юм. Иргэн, хуулийн этгээд эд хөрөнгийг шударгаар олж авах, аж ахуйн нэгж байгуулах, бусад байгууллага, иргэдтэй төрөл бүрийн аж ахуйн харилцаанд оролцохдоо хуулиар хориглоогүй үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой. Хуулийн дагуу ажиллаж байгаа нь өөрөө өөрийнхөө эрхийг хамгаална гэсэн ойлголт болно.

Бизнесмен аж ахуйн нэгж байгуулахад гэрээ дүрмийг зохих журмын дагуу хийх, бүртгэх байгууллагад бүртгүүлэх, зөвшөөрсөн үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэх үүрэгтэй. Энэхүү журмыг баримтлаагүй, баримталсан ч хууль зүйн агуулга, хэлбэрт нийцээгүй бол өөрийн болон бусдын эрх ашгийг хохироох болно.

Иргэний хуульд заасан тодорхой төрлийн гэрээгээр үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчийн ажил үүргийн дутагдлыг шаардлага гаргах, гэрээ цуцлахыг шаардах г.м хэлбэрээр өөрийн эрхээ хамгаалдаг. Иргэний хуулийн 299 дүгээр зүйлд ажил гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд ажил эрхлээгүй буюу удаан хийснээс түүнийг хугацаанд нь дуусгах боломжгүй болсон бол захиалагч гэрээг цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй. Мөн хуулийн 319 дүгээр зүйлд тээвэрлүүлэгч нь тээвэрлэлтийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргахын өмнө тээвэрлэгчид гомдлын шаардлага гаргана гэж заасан юм. Эдгээр заалт нь бизнесменүүд эрхээ өөрөө хамгаалах нөхцөлийг хуулиар тогтоосон хэрэг болно.

2. Бизнесменүүдийн эрхийг шүүх хамгаална. Шүүх эрх мэдэл хэрэгжих нэг зарчим бол хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш байх явдал билээ. Эрхээ ямар байдлаар зөрчигдсөн гэж үзэж буй аж ахуй эрхлэгчид уг эрхээ сэргээж хамгаалуулахаар шүүхэд хандаж мэдүүлэх эрхтэй байна. Шүүхэд мэдүүлэх эрхийг илэрхийлэх хэлбэр бол нэхэмжлэл болно. Бизнесменүүдийн зайлшгүй мэдвэл зохих зүйл нь нэхэмжлэл гэж юу болох, түүний агуулга, тавигдах шаардлага, хэргийн болон шүүхийн харъяал, нотлох баримтыг бүрдүүлэх зэрэг асуудал юуны өмнө тавигдах ёстой. Эдгээр шаардлагыг Иргэний Хэрэг Хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу бүрдүүлэх хэрэгтэй байна.

Нэхэмжлэл бол материаллаг эрх зүйн харилцаанаас үүссэн эрх зүйн зөрчил буюу субъектив эрхээ хамгаалуулахаар шүүхэд гаргасан нэхэмжлэгчийн шаардлага юм.

Нэхэмжлэл нь ямар шүүхэд гаргаж байгаа, нэхэмжлэгч, хариуцагчийн овог, нэр, хаяг, нэхэмжлэл бусад маргаан байгаа зүйлийн утга, нэхэмжлэгчийн хүсэлт, шаардлага юу болох, уг шаардлагыг нотлох, нотолгооны төрөл, хэлбэр шинжийг агуулсан байна. Хэрэв нэхэмжлэлийн шаардлага хангаагүй бол хэргийн ба шүүхийн харъяалал зөрчих, шүүхийн ажлыг хүндрүүлэх эцсийн бүлэгт нэхэмжлэгч өөрөө болон хэргийн бусад оролцогчдыг хохирооход хүрдэг.

Нэхэмжлэл нь эд хөрөнгийн (виндикация), эрх сэргээх (негатория), өмчлөх буюу эзэмших эрх зөвшөөрүүлэх гэсэн гурван төрөлтэй байна. Эд хөрөнгө өмчлөгчийн санаа зоригоос үл хамааран бусдын хууль бус эзэмшилд орсон тохиолдолд гаргах нэхэмжлэлийг эд хөрөнгийн нэхэмжлэл гэнэ. Эд хөрөнгө бусдын хууль бус эзэмшилд ороогүй боловч өмчлөгч буюу эзэмшигч уг эд хөрөнгөө ашиглах, захиран зарцуулах боломжгүй болсон тохиолдолд эрх сэргээх нэхэмжлэл гаргана. Эд хөрөнгө өмчлөх буюу эзэмших эрхээ шүүхээр тогтоолгохоор нэхэмжлэл гаргах, үүнийг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл гэнэ.

Бизнесменүүд иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчээр оролцож байгаа бол гаргасан нэхэмжлэлээ хангуулахаар шаардах, нэхэмжлэлээсээ татгалзах, шаардлагатай бол шинжээч томилуулах, шүүхийн шийдвэр гартал хариуцагчийн эд хөрөнгийг битүүмжлэх хүсэлт гаргах, шүүгч бусад шүүх бүрэлдэхүүнээс татгалзах, шүүхийн шийдвэрт давж заалдах г.м эрхтэй байна. Хэрэв хариуцагчаар оролцож байгаа бол нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ гаргах, эсхүл дэмжих, болон Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан бусад эрх, үүрэг эдлэнэ.

3. Арбитр бизнесменүүдийн эрхийг хамгаална. Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын дэргэд гадаад худалдааны арбитр ажилладаг бөгөөд 2000 оны 9 сард 40 жилийн ойг тэмдэглэсэн байна.

Гадаад худалдааны арбитр нь гадаад эдийн засгийн хэлцэл, эд хөрөнгийн шинжтэй харилцаанаас үүссэн эрх зүйн маргаантай холбогдуулан ашиг сонирхлоо хамгаалж иргэн, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэлийг арбитрын хэрэг үүсгэн хянан шийдвэрлэдэг.

Арбитр нь нэхэмжлэлийг хүлээн авч хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүхийн үйл ажиллагаатай адил боловч ялгаатай байна.

Арбитрын хянан шийдвэрлэх хэргүүд нь:

1. Нэг талаас Монгол улсын иргэн, хуулийн этгээд, нөгөө талаас гадаад улсын иргэн, хуулийн этгээдийн хооронд гадаад

эдийн засгийн, гэрээ, хэлцлээс үүссэн болон мөнхүү гэрээний өмнөх маргаан

2. Монгол улсад ажиллаж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дотоодын болон гадаадын үүсгэн байгуулагчдын хооронд үүссэн маргаан

3. Гадаадын хуулийн этгээдийн хоорондын маргаан.
Нэхэмжлэгч, хариуцагч талууд хэрэг шийдвэрлэх арбитрчаа сонгох, хоёр арбитрч хуралдаж даргалах гуравдахь арбитрчийг томилно. Хэрэв талууд арбитраа томилоогүй бол арбитрийн дарга тушаал гаргаж томилдог.

Арбитрийн шийдвэр эцсийн бөгөөд заавал биелэгдэх хүчинтэй байна.

Бизнесменүүдийн эрхийг хууль зүйн зөвлөгөөний аргаар хамгаална. Бизнес эрхлэгчид хуулийн зөвлөгөөг:

а. аж ахуйн нэгжүүд өөрийн орон тоо, төсөвтөө багтаан хуулийн зөвлөгч бусад хуулийн хэлтэс, тасаг бий болгож ажиллуулах,

б. өмгөөлөгч бусад хууль зүйн товчоотой гэрээ байгуулж хууль зүйн зөвлөгөө туслалцаа авах,

в. зөрчигдсэн болон маргаж байгаа эрхээ шүүх, арбитра хандаж шийдвэрлүүлэх үед өмгөөлөгч авч эрхээ хамгаалуулах гэсэн гурван хэлбэртэй байна.

Эдгээр хэлбэрийн эхний хоёр нь бизнесмен аж ахуй эрхлэх явцад эрх зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гурав дахь нь нэгэнт бий болж зөрчигдсэн эрхийг сэргээх, хамгаалах агуулгатай байна. Хуулийн зөвлөгөө, туслалцааг ямар хэлбэрээр зохион байгуулж авахаа бизнесмен өөрөө шийдвэрлэх эрхтэй.

www.osu.mmm